



Arlington Public Schools
АХЛАХ СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН
ХӨТӨЛБӨР
2021-2022

АХЛАХ СУРГУУЛИУД, АХЛАХ СУРГУУЛИЙН ИЖ БҮРЭН
ХӨТӨЛБӨРҮҮД

WAKEFIELD АХЛАХ ДУНД
СУРГУУЛЬ

1325 S. Dinwiddie Street
Arlington, VA 22206
(703)228-6700

YORKTOWN АХЛАХ
СУРГУУЛЬ

5201 N. 28th Street 22207
Arlington, VA 22207
(703)228-5400

NEW DIRECTIONS

2847 Wilson Boulevard
Arlington, VA 22207
(703)228-2117

WASHINGTON-LIBERTY
АХЛАХ СУРГУУЛЬ

1301 N. Stafford Street
Arlington, VA 22201
(703)228-6200

**КАРЬЕРЫН ТӨВ/
АРЛИНГТОНЫ**
ТЕХНОЛОГИЙН ХӨТӨЛБӨР

816 Walter Reed Drive
Arlington, VA 22204
(703)228-5800

ARLINGTON COMMUNITY
АХЛАХ СУРГУУЛЬ

800 S. Walter Reed Dr.
Arlington, VA 22204
(703)228-5350

АХЛАХ
СУРГУУЛИЙН
ҮРГЭЛЖЛЭЛ

LANGSTON
2121 N. Culpeper Street
Arlington, VA 22203
(703)228-5295

የመካከለኛ ደረጃ ት / ቤት የጥናት ፕሮግራም በአንግሊዝኛ ጽ / ቤቶች በሁሉም የአርሊንግተን የህዝብ ትምህርት ቤቶች ውስጥ ይገኛል ወይም በድር ጣቢያው ላይ www.apsva.us

العامة *Arlington* برنامج الدراسات للمدرسة المتوسطة متاح أيضًا باللغة الإنجليزية في مكاتب التوجيه في جميع مدارس www.apsva.us أو على الموقع الإلكتروني

Дунд сургуулийн сургалтын хөтөлбөрийг англи хэл дээр Арлингтон хотын бүх сургуулиудын удирдамж байрлуулах боломжтой эсвэл вэбсайтад: www.apsva.us

El Programa de Estudios de las Escuelas Secundarias está disponible en español en todas las oficinas de consejería de las Escuelas Públicas de Arlington o en el sitio web: www.apsva.us

**АРЛИНГТОН ХОТЫН АХЛАХ СУРГУУЛИЙН ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР
АГУУЛГЫН ТОВЬЁОГ**

Бриджит Лофтын үг, заах болон сурах арга барилын ахлах хянагч	ii
Хөтөлбөр төлөвлөлт.....	1
Тусгай Хөтөлбөрийн зохицуулалт	3
Сургуулийн зөвлөх мэргэжилтэнүүд	4
Төгсөхөд тавигдах шаардлага	5
Коллежийн тамирчин сурагчдын NCAA-д хамрагдах эрх.....	9
Сурагчдад үзүүлэх үйлчилгээ болон тусгай боловсрол	14
Номын сангийн үйлчилгээ	15
Сонгож болох хөтөлбөрүүд.....	15
Хичээлийн нэмэлт сонголтууд.....	17
Авьяаслаг сурагч үйлчилгээг авдаг сурагчдын боломж.....	19
Арлингтон ,Уэйкфилд, Вашингтон-Либерти, Йорктаун ерөнхий боловсролын коллеж дээр санал болгож буй хичээлүүд.....	20
Урлагийн боловсрол.....	20
Мэргэжил ба техникийн боловсрол	26
Бизнес ба мэдээллийн технологи (IT)	27
Компьютерийн шинжлэх ухаан	30
Гэр бүл ба хэрэглэгчийн шинжлэх ухаан.....	30
Маркетинг	32
Технологийн боловсрол.....	32
Жолоочийн боловсрол ба аюулгүй байдал.....	34
Англи хэлний урлаг	34
Эрүүл мэндийн боловсрол, биеийн тамирын хичээл	39
Англи хэл сургалтын хөтөлбөр	40
Математик	41
Шинжлэх ухаан.....	48
Нийгмийн судалгаа.....	53
Тусгай боловсрол.....	60
функционал хичээл	63
Сайн дурын ажилтны үйлчилгээ	64
Дэлхийн хэлүүд.....	64
Нэмэлт хөтөлбөрүүд ба хичээлүүд	
Арлингтон мэргэжил боловсролын төв - Бүх сурагчдад зориулсан тусгай хөтөлбөр, төрөлжсөн хөтөлбөрүүд Хичээлийн хөтөлбөрийн нэмэлт хавсралт	75
Арлингтон ерөнхий боловсролын ахлах сургууль - Бүх сурагчдад зориулсан тусгай хөтөлбөр ба хичээлийн хөтөлбөрийн нэмэлт хавсралт.....	102
Уэйкфилд ахлах сургууль - Бүх сурагчдад зориулсан тусгай хөтөлбөр ба хичээлийн хөтөлбөрийн нэмэлт хавсралт.....	104
Вашингтон-Либерти ахлах сургууль - Олон улсын бакалаврын хөтөлбөр ба хичээлийн хөтөлбөрийн нэмэлт хавсралт.....	113
Йорктаун ахлах сургууль - хичээлийн хөтөлбөрийн нэмэлт хавсралт	123
Давхар элсэх (NOVA)-н Тусгай хөтөлбөр.....	131
Давхар элсэж болох хичээлүүд	136
NOVA -ийн ерөнхий боловсролын гэрчилгээ.....	139
Хичээлийн хөтөлбөрт санал болгож буй хичээлүүдийн гарчиг	140
Хавсралт А - Дүрслэх урлагийн хичээлийн санал	146
Хавсралт Б - Мэргэжил ба техникийн боловсролын хичээлүүдийн танилцуулга	147
Хавсралт С - Онлайн хичээлийн санал	149



2021 оны 1-р сар

Эрхэм хүндэт Арлингтоны гэр бүлүүд:

Арлингтон хотын ерөнхий боловсролын ахлах сургуулиудын сургалтын хөтөлбөрт тавтай морилно уу! Таны Ахлах сургуулийн хичээлийн сонголтынхоо дарааллыг төлөвлөхөд энэ лавлагаа тус болно гэдэгт найдаж байна. Хичээлийн хөтөлбөр нь ахлах сургууль, Мэргэжил боловсролын төв,, манай сургалтын хөтөлбөрийн хүрээн дотор байгаа сургалтын санал, үйлчилгээний талаар ерөнхий болон тодорхой мэдээллийг сурагчид болон эцэг эхчүүдэд өгөх болно. Тодорхой товчлолыг бүрдүүлэхийн тулд бид ахлах сургуулийн олон хичээлийн талаар товч, бодитой тайлбар бичсэн болно. Та ахлах сургуулийнхаа Зөвлөх үйлчилгээний алба руу холбогдож сэдвүүдийн талаар нэмэлт мэдээлэл авах боломжтой:

Арлингтон ерөнхий боловсролы ахлах сургууль	703/ 228-5350
Арлингтон Ажил мэргэжлийн төв	703/ 228-5800
Лэнгстон	703/ 228-5295
Шинэ чиглэл	703/ 228-2117
Уэйкфилд ахлах сургууль	703/ 228-6702
Вашингтон-Либерти ахлах сургууль	703/ 228-6250
Йорктаун ахлах сургууль	703/ 228-5350

Сурагчид өөрсдийн сонирхлыг дагаж, мэдлэгээ тэлэх олон сонголт байдаг. Сурагчид, эцэг эхчүүд, сургуулийн зөвлөх мэргэжилтэнүүд хамтран сурагчийн ахлах сургуулийн жилүүдийг төлөвлөх, нөхцөлийн дагуу зохих засваруудыг хийх хэрэгтэй. Сурагчийн зорилго, сонирхол болон төгсөхөд тавигдах шаардлага нь шийдвэр гаргах чиглэл болж байх ёстой. 2021-22 оны хичээлийн хөтөлбөр нь энэ үйл явцыг дэмжих юм. Нэмж дурдахад танай сургуулийн Зөвлөх үйлчилгээний албатай хамтран ажилласнаар таны хүүхдийн авах боломжтой бусад олон дэмжлэгийг тодорхойлж болно. Жишээлбэл, сургуулиуд сурагчдад хэрэгтэй байгаа сэдвээр нэмэлт хичээл шаардлагатай үед дэмжлэг зааварчилгааны тусламж үзүүлдэг.

Энэхүү лавлагааны төгсгөлд та сургууль болгонд санал болгож буй хичээлүүдийн жагсаалтыг олох болно. Эдгээр хичээлүүд нь ахлах сургуулиудын сурагчдынхаа хэрэгцээг харгалзан, ажилтнуудынхаа давуу тал, ашиг сонирхлыг ашиглан бүрдүүлсэн жагсаалт болно.

Бид таныг нээлттэй өдөрлөг, сургууль руу буцаж ирэх өдөр болон бусад хуваарьт боломжуудыг ашиглан сургуультайгаа холбоотой байхыг зөвлөж байна. Та мөн хүүхдийнхээ зөвлөх мэргэжилтэн эсвэл багштай биечлэн уулзахаар цаг товлож болно.

Бид таныг ахлах сургуульд суралцаж байх жилүүдэд олдох олон боломжийг ашиглана гэж найдаж байна.

Хүндэтгэсэн,

Бриджет Лофт

Заах болон сурах арга барилын ахлах хянагч

ХӨТӨЛБӨР ТӨЛӨВЛӨЛТ

Сургалтын Хөтөлбөрийн нарийвчилсан судалгаа нь эцэг эх, сурагчдыг сургалтын хөтөлбөр, сургуулийн үйлчилгээтэй танилцуулж, төгсөлтийн болон хувийн шаардлагад нийцсэн цогц хөтөлбөрийг төлөвлөн гаргахад чиглэнэ. Зөвлөх Үйлчилгээний Алба нь төлөвлөлтийн хөтөлбөртэй холбоотой асуултанд хариу өгч ажиллана. Зөвлөхүүд 2 болон 3 дугаар сард хөтөлбөрийн төлөвлөгөө боловсруулах болон эцэг эхчүүдийн уулзалтыг товлох зорилгоор сурагчидтай (дунд ангийн зөвлөхүүд 9-р ангид орох сурагчидтай; ахлах ангийн зөвлөхүүд 10-р, 11-р ба 12-р ангид орох сурагчидтай) уулзах болно. Хөтөлбөр төлөвлөлтөд тус болох зарим удирдамжууд доор дурдагдана.

7 Хичээлтэй Өдөр Бүх сурагчид долоон хичээлд хамрагдах ёстой ба зарим хичээлүүд Ажил Мэргэжлийн Төдөөр заагдаж болно. Онцгой нөхцөлд сурагчид богиносгосон цагийн хуваарийг зөвшөөр болно.

Хичээлийн Сонголт Сургалтын чигийг сонгох нь сурагч, эцэг эх, багш болон зөвлөх нар анхааралтай бодож үзэж хамтаар гаргах үйл ажиллагаа юм. Хичээлийг сонгохдоо төгсөхөд шаардагдах зүйлс б ирээдүйн эрх ашгаа бодож үзэх нь зүйтэй. Ахлах сургуулийг төгссөний дараа, байнгын ажил, орох, зэвсэгт хүчинд алба хаах, бизнес/техникумд суралцах, эсвэл хоёр эсвэл дөрвөн жилийн коллежид нэмэлт боловсрол эзэмших гэх мэт сурагчийн гаргаж болох сонголтууды хязгаарлахгүй байхыг бид зорьж байна. Тиймээс танд сургалт курсуудын баяла боломжуудыг олгох болно.

Хичээл Сонголтын Хувилбарууд Сургалтын Хөтөлбөрт багтсан бүх курсууд сурагчдад нээлттэй. Сурагчид хичээлийн эцсийн хуваарийг бөглөх явцад, 15-с доос сурагчидтай курсууд нь сонгогдох боломжгүй. Тиймээ хичээл сонгохдоо, сурагчдын тоо хүрэхгүй нөхцөлд өөр хичээл сонгох хувилбартай байх н чухал. Хичээлийн хуваариас шалтгаалан нөөцөөр сонгосон хичээлийг авах шаардлага үүс болно. Хэрвээ хичээл төв сургуульд цуцлагдвал, сурагч тухайн хичээлд өөр сургуульд хэрэ орон тоо байвал хамрагдаж болно. Энэ тохиолдолд эцэг эх нь тухайн сурагчийг сургуул хооронд тээвэрлэх шаардлага үүсэж болно. Хичээл цуцлагдах болон давхсан тохиолдол, сурагчийн эрх ашиг ба хэрэгцээг хамгаална. Зарим тохиолдолд төсвийн нэмэлт асуудлы харгалзан тухайн жилд хичээл заагдахгүй байж болох бөгөөд цуцлагдсан хичээлийг сонгосон байсан сурагчид өөр хичээл сонгох хэрэгтэй. Мөн элсэлт хангалтгүй Хичээлийг зайнаа явуулж болно.

Гүнзгийрүүлсэн Хичээлүүдийн Бэлтгэл Арлингтон Улсын Сургуулиуд бүх сурагчдыг гүнзгийрүүлсэн сургалтуудад амжилт гаргахы дэмждэг. Гүнзгийрүүлсэн сургалтанд амжилт гаргах нь сурагчдад амжилтанд хүрэх чадвар, өөртө итгэх итгэл, сурах чадварыг суулгахаас гадна бусад ахисан шатны сургалтуудад хамрагдах боло сургууль төгссөний дараах амьдралд амжилт гаргах суурь болдог. Гэхдээ зөвхөн тухай суралцагчид цааш үргэлжлүүлэн ахисан түвшинд гүнзгийрүүлэн суралцах хүсэлтэй байх нь, хангалттай биш юм. Мэдлэг ба ур чадвар нь гүнзгийрүүлсэн сургалтанд амжилт гаргах хүчин зүй болдог.

Тиймээс, нийт сурагчид бүх сургалтанд хичээн сурснаар сурлагын өндөр амжилт гаргах суурий бэлддэг. Үүнд үр дүнтэй сурах зуршил, гэрийн даалгавар хийх, даалгаврыг цагт нь хийх шаардлагатай үед тусламж хүсэх болон илүү цаг гарган сурах, болон ахисан шатны хичээлүүдий өмнө үзэх ёстой хичээлүүдийг амжилттай сурах хамрагдана. Сурагчид хичээх гэдэгт сурагчи, даалгавруудыг биелүүлэх болон ур чадвар хөгжүүлэх дасгалуудыг хийснээр сургалтанд тавигдсан хамгийн доод шалгууруудыг даалгавруудыг давуулан биелүүлэх багтана. Сурагч, эцэг эхчүү, гүнзгийрүүлсэн сургалтад хамрагдах ба амжилт гаргах боломжийг нэмэгдүүлэхийн тулд дээр чадваруудыг хөгжүүлэн дэмжих чиглэлээр багш, зөвлөхүүдтэй нягт хамтран ажиллах нь нэ шаардлагатай. 9-р ангийн бүх сурагчид зөвлөхүүд болон эцэг эхчүүдтэй зөвлөлдсөний үндсэн дээр дөрвөн жилийн төлөвлөгөөгөө гарган, анги ахих тусам төлөвлөгөөгөө шинэчилж, сайжруула шаардлагатай.

Ахлах сургуулийн ахисан шатны сургалтууд нь гүнзгийрүүлсэн мөн түргэвчилсэн сургалтуу, бөгөөд, "эрчимжүүлсэн" гэж мөн нэрлэж болох бөгөөд салбарын гэрчилгээ авахад хүргэж болно. Дараах хүснэгт нь сурагчид 9-р ба 10-р ангидаа сонгосон гүнзгийрүүлсэн хичээлүүд нь 11-р ба 12-р ангид бий болох хичээлүүдийн сонголт болон боломжуудад хэрхэн нөлөөлөхийг харуулсан гурван жишээ багтаасан болно.

Хичээл:	Тайлбар:
Геометр	Математикийн хичээлүүдийн дэвшил нь Алгебр I, Геометр, Алгебр II ба AP хөтөлбөрийн хичээл гэсэн дараалалтай. Сурагч AP хөтөлбөрийн шинжлэх ухааны 11-р эсвэл 12-р ангидаа судлахыг хүсвэл Эрчимжүүлсэн Хими хичээлийг 10-р ангидаа үзсэн байх шаардлагатай. (AP хөтөлбөрийн хичээлүүд нь сурагчдад ахлах ангид байх хугацаандаа AP хичээлийн кредит авах боломжийг олгодог.) Алгебр II хичээлийг Эрчимжүүлсэн Хими хичээлтэй хамтад нь үзэх шаардлагатай байдаг. Тиймээс, сурагч 9-р ангидаа Геометр -г судлаагүй бол зуны сургалтанд хамрагдан кредитээ тооцуулснаар 10-р ангидаа Эрчимжүүлсэн Хими болон 11 эсвэл 12-р ангидаа AP хөтөлбөрийн шинжлэх ухааны хичээлийг үзэх боломжтой болох юм.
Испани Хэл II	Сурагч 9-р ангид Испани Хэл II -г судалснаар 10, 11 болон 12-р ангидаа Испани Хэл III, IV, ба V-г судлах эсвэл ахлах ангидаа өөр хэлийг хамгийн багадаа 2 жил үзэх боломжийг олгодог. Их сургуульд элсэхэд илүү тохиромжтой Ахисан Түвшин Хичээлийн Диплом -г авахад нэг гадаад хэлний 3 жилийн сургалт эсвэл 2 гадаад хэлний тус бүр 2 жилийн сургалт шаардлагатай.
Мэргэжлийн сертификат	Автомашинны Технологи I, II, ба III сургалтуудыг В болон дээш дүнтэй төгссөн сурагчид дүнгээ зэргийн кредит оноонд тооцуулан Үндэсний Автомашинны Үйлчилгээний Хүрээлэнгийн Шалгалтыг өгөн мэргэжлийн сертификат авж болно.

Сурагчид болон эцэг эхчүүд дөрвөн жилийн төлөвлөгөөнд урьдчилан үзсэн байх хичээлүүд ба дараагийн шатны сургалтуудыг багтаасан байхын тулд зөвлөхүүдтэй нягт хамтран ажиллах хэрэгтэй. Ийм хамтын ажиллагаа нь сурагчдад сургуулийн дараах олон боломжийг олгодог.

Хичээлийн Өөрчлөлт

Сурагчдад хувийн хэрэгцээг тусгасан нэмэлт өөрчлөлт шаардлагагүй анхааралтай боловсруулсан хичээлийн хуваарь нь нэн тустай. Боловсон хүчин, сурах бичиг, болон бусад шаардлагатай материалуудыг хичээлийн сонголт дээр тулгуурлан гаргадаг тул хичээлийг өөрчлөх нь онцын шаардлагагүй бол зөвшөөрөгдөхгүй. Хэрэв хичээл өөрчлөхөд хүндэтгэх шалтгаан байгаа бол хичээл өөрчлөх хүсэлтийг дараах хүчин зүйлийг тусган нягтлана.

- сурагч зуны Хичээлийг амжилттай төгссөн
- Испани Хэл III сонгох хүсэлт гаргасан ч Франц Хэл III -д хуваарьлагдсан гэх мэт хичээл сонголтын алдаа гарсан бол.
- зөвлөхийн зөвшөөрөлтэйгээр сурагч мэргэжлээ өөрчилсөн бол
- сурагч өмнөх жилийн нэг багшид хуваарьлагдсан бөгөөд өөр багшид хуваарьлагдах хүсэлтэй бол.
- Геометр -с Геометр -н Зарчим гэх мэт сурагч өөрийн чадварт тохирохгүй хичээлд хуваарьлагдсан бол

Сурагчид гүнзгийрүүлсэн хичээл сонгохдоо тухайн хичээлийн урьдчилсан нөхцөлийг хангаагүй байсан ч хамрагдаж болно. Урьдчилсан нөхцөлүүд нь уг хичээлд амжилт гаргахад шаардлагатай ур чадвар туршлагаудыг сурагчид ба сурагчдын гэр бүлийнхэнд танин мэдүүлэх зорилгоор багтаасан болно. Эцэг эхчүүд хүүхдүүдээ эдгээр хичээлүүдэд хамруулах боломжтой. Эцэг эхчүүд өөрсдийн хүсэл сонирхлын талаар сургуулийн хамт олон, ялангуяа хүүхдийнхээ зөвлөхтэй ярилцах хэрэгтэй. Энэхүү ярилцлагын зорилго нь сурагчдын амжилтыг баталгаажуулах болон эцэг эхчүүдэд эдгээр хичээлд шаардагдах академик ур чадвар ба шаардлагуудыг ухамсарлан ойлгоход тус болох юм. Хэрэв эцэг эх нь хүүхдээ анхлан санал болгоогүй хичээлд хамруулахаар шийдсэн бол шийдвэрээ хичээлийн жилийн төгсгөлөөс өмнө сургуулийн ажилтанд мэдэгдэх хэрэгтэй.

ТУСГАЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сурах Явцыг Сургуулийн Оролцоотой Түргэсгэх

Илүү хурдан сурж буй сурагчдын ахиц дэвшлийг хурдасгах боломжийг олгох зорилгоор сурлагын үйл ажиллагаануудыг зохион байгуулж болно. Зуны сургалтууд, анги хоорондын бүлэг хуваарилалт, сонгон суралцах хичээлүүд, эсвэл энд дурдсан ажиллаануудыг хослуулах гэх мэтээр сурах явцыг хурдасгаж болно.

Сурах Явцыг Хөтөлбөрөөр Дамжуулан Түргэсгэх

Сурагчид илүү ахисан шатны болон гүнзгийрүүлсэн хичээлүүдэд хамрагдахын тулд ганцаарчилсан зааварчилгаа авах, бүлэг хоорондын хуваарилалтанд орох, ур чадварын шалгалт өгөх, сонгон судлах хичээл судлах, болон сургалтын дараагийн шатанд хамрагдах байдлаар зүтгэл гаргахыг сургуулиас дэмждэг.

Давхар Хамрагдах

Сурагчдын сурах явцыг түргэтгэх./эсвэл баяжуулах зорилгоор Ахлах Сургууль ба Ахлах Сургуулийн Үргэлжлэл Хөтөлбөрийг сурах нөөц бололцоог харгалзан зохих зөвшөөрлөөр олгох боломжтой.

Бие Даасан Сургалт

Өндөр чадвартай суралцах өндөр эрмэлзэлтэй сурагчид сурлагын хөтөлбөрт ороогүй ч хувийн сонирхолд нийцсэн хичээлийг бие даан суралцах боломжтой. Судалгааны ажил, бие даасан сургалт, дадлага, сайн дурын эсвэл цалинтай ажлын туршлага зэрэг бие даан суралцах ажиллагаануудыг ахлах сургуулийн захирал урьдчилан тогтоосон нөхцөлтэйгээр ахлах сургуулийн кредитэд тооцох зөвшөөрөл өгч болно. Ерөнхийдөө бие даасан сургалт нь хамрах хүрээний хувьд онлайн хичээлтэй дүйцнэ. Сурагчид бие даан үзэх сургалт явуулах жилийн өмнөх хавар нь Зөвлөх Үйлчилгээний Албаар дамжуулан маягт бөглөснөөр сургалтын эрх хэрэгжинэ.

СУРГУУЛИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨХҮҮД

ЭРХЭМ ЗОРИЛГО БА АЛСЫН ХАРАА:

Эрхэм Зорилго: Арлингтоны улсын сургуулиудын зөвлөхүүд нийт сурагчдад заан зөвлөх болон дэмжлэг үзүүлэх замаар тэгш Хичээлийг болон сурах замыг бий болгохыг хичээнэ. Сургуулийн зөвлөх нь бүх Суралцагчдын сурлагын амжилт, ажил мэргэжлийн талаархи мэдлэг, нийгмийн/сэтгэл зүйн тогтвортой байдлыг анхааран үзнэ. Бүх сурагчид Сургуулийн Цогц зөвлөгөөг авах эрхтэй.

Алсын Хараа: Арлингтон Улсын Сургуулийн системд суралцсан бүх сурагчид насанд хүрэгчдийн тухай ойлголтыг хүлээн авч, өөрийгөө танин мэдэн, хувийн зохион байгуулалтад суралцан, хариуцлагатай шийдвэр гаргах чадвартай болон, харилцаа холбоо тогтоон, нийгмийн ухамсартай болон, амьдралд бэлдэгдсэн болж хүмүүжнэ.

ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД:

Сургуулийн зөвлөгөө өгөх хөтөлбөр нь сурагчид, эцэг эх, багш, сургуулийн удирдлага болон олон нийтэд хүртээлтэй хамтын хүчин чармайлт юм. Сургуулийн зөвлөгөө өгөх хөтөлбөр нь сурагчдын өдөр тутмын боловсролын салшгүй нэг хэсэг байх бөгөөд сургуулийн зөвлөхүүд сурагчдын амжилтын амжилтын хамтрагчид байна. Сургуулийн зөвлөгөө өгөх цогц хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг Америкийн Сургуулиудын Зөвлөхүүдийн Холбооны Загвард үндэслэсэн болно (ASCA).

Сурагчдад үзүүлэх шууд үйлчилгээ нь сургуулийн зөвлөх ба сурагчдын хоорондох биечлэн харилцах харилцаа ба дараах зүйлсийг агуулна.

- **Сургуулийн зөвлөгөө өгөх үндсэн хөтөлбөр:** Энэхүү сургалтын хөтөлбөр нь сурагчдын хүссэн чадамжийг олж авахад нь туслах, бүх сурагчдад тэдний хөгжлийн түвшинд тохирсон мэдлэг, хандлага, ур чадвар олгоход чиглэсэн тодорхой бүтэцтэй хичээлүүдээс бүрдэнэ. Сургуулийн зөвлөгөө өгөх үндсэн хөтөлбөрийг сургуулийн ерөнхий хөтөлбөрийн дагуу явуулах бөгөөд сургуулийн зөвлөхүүд бусад мэргэжлийн багш нартай хамтран I - XII анги, бүлгийн үйл ажиллагаануудад системтэйгээр танилцуулдаг. Арлингтоны Улсын Сургуулиуд хэд нөөц бололцоог ашигладаг: Нэг нөөц бололцоо нь Хүүхдийн Хоёрдахь Алхам Хөтөлбөрийн Хороо юм. Эдгээр I - VIII ангиудад зориулсан хичээлүүд нь нийгмийн, сэтгэл зүйн, эрдэм шинжилгээний ур чадварыг хөгжүүлэхэд чиглэгддэг. Хоёрдахь Алхам хөтөлбөрийн материалуудыг дараах холбоосоос үзэх [БОЛОМЖТОЙ \(http://www.secondstep.org/second-step-suite\)](http://www.secondstep.org/second-step-suite). Арлингтоны Улсын Сургуулиуд V ангид зориулсан Хоёрдахь Алхам Цогц хөтөлбөр болон Дунд Сургуулийн 2011 оны Нийгэм Сэтгэл Зүйн хөтөлбөрийг ашигладаг. Сургуулийн зөвлөхүүдийн явуулдаг сургалтын хөтөлбөрийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг үзэхийн тулд сургуулийн зөвлөхтэй цаг товлон уулзана.
- **Сурагчдад тусгайлан гаргасан төлөвлөлт:** Сургуулийн зөвлөхүүд сурагчдад хувийн зорилгоо тодорхойлох, ирээдүйн төлөвлөгөөгөө боловсруулахад нь туслах зорилгоор үйл ажиллагааг тогтмол зохион байгуулдаг. Хичээлийн төлөвлөлтийн үйл явц нь жилд дор хаяж нэг удаа явагддаг бөгөөд дараа жилийн хичээлээ төлөвлөх зорилгоор сурагчидтай уулзана. Энэхүү уулзалт нь 3 зорилго агуулна; 1) төгсөлтийн шаардлагыг хангасан эсэхийг нягтлах, 2) сонгох боломжтой хичээлүүд болон сурагчдын эрмэлзэж буй мэргэжлийн уялдаа холбоог хэлэлцэх, 3) сурагчдад сурлагын хичээл зүтгэлийг дэмжих. Энэхүү уулзалтын үр дүнд сурлагын болон ажил мэргэжлийн төлөвлөгөө (САМТ) гарч, гэр бүлүүдэд хуваалцдаг.
- **Хэрэгцээд Тулгуурласан Үйлчилгээ** Хэрэгцээнд Тулгуурласан Үйлчилгээ нь сурагчдын нэн шаардлагатай хэрэгцээ болон асуудлыг шийдвэрлэхэд зориулсан үйл ажиллагаа болно. Хэрэгцээнд Тулгуурласан Үйлчилгээнд ганцаарчилсан, жижиг бүлгийн эсвэл хямралын нөхцөлд үзүүлэх зөвлөх үйлчилгээ багтана.
- **Сурагчдад Үзүүлэх Шууд Бус Үйлчилгээ** Сургуулийн зөвлөхүүд сурагчдын өмнөөс эцэг эх, багш, бусад сурган хүмүүжүүлэгчид, болон олон нийтийн байгууллагуудтай нэмэлт тусламж авах, зөвлөлдөх, хамтран ажиллах зэргээр бусадтай харилцсан шууд бус үйлчилгээ юм.



ТӨГСӨХ ШААРДЛАГУУД

Виржиниа мужийн дунд сургуулийг Диплом аван төгсөхөд тавигдах шаардлага нь тухайн сурагч 9-р ангид анх ороход тавигдсан шаардлага тавина. Сурагчдад Виржиниа мужийн дунд сургуулийг төгсөхөд диплом олгоно.

9-с доорх ангийн сурагчид 9-с 12-р ангиудад кредиттэй суралцдаг хичээлүүдийг амжилттай дүүргэсэн тохиолдолд тухайн судалсан хичээлийн кредитийг төгсөхөд шаардагддаг нийт кредитийн тоонд оруулан бодно. Эдгээр хичээлүүдийг дүүргэн баталгаажсан кредит оноог авахын тулд сурагчид Виржиниа Мужийн Чанарын Стандартын Шаардлагыг ([HU8VAC20-131-110UH](#)) хангасан байх ёстой.

Хэрэв сургуулийн дотоод зөвлөлөөс доор дурдсанаас өөр төгсөх шаардлага гарган түүнийг Боловсролын Зөвлөлөөс батлаагүй бол стандарт эсвэл гүнзгийрүүлсэн сургалтын дипломын дараахь шаардлагыг цорын ганц шаардлага болгоно. Сургуулийн дотоод зөвлөлөөс гарган Боловсролын Зөвлөл баталсан нэмэлт шаардлагууд нь сургуулийн дотоод зөвлөл Боловсролын Зөвлөлд өөрчлөлт оруулах болон зогсоох хүсэлт хүргүүлэх хүртэл хүчин төгөлдөр байна.

Стандарт Дипломын Шаардлагууд.

2018-19 оны **9-р ангиас эхлэн** бүх сурагчид шаардагдсан стандарт ба баталгаажсан кредит оноог авна. Стандарт дипломтой төгсөхийн тулд сурагчид заавал үзэх ёстой болон сонгон суралцах хичээлүүдийг амжилттай үзэж дуусган хамгийн багадаа 22 кредит оноо авах болон хичээлийн төгсгөлд SOL шалгалт эсвэл бусад Боловсролын Зөвлөлөөр батлагдсан шалгалтанд тэнцсэнээр хамгийн багадаа 5 кредит оноо цуглуулах ёстой.

Хичээлийн Салбар	Шаардлагатай Кредит Оноо	Шаардлагатай Баталгаажсан Кредит
Англи Хэл (уншлага, бичиг)	4	2
Математик	3	1
Шинжлэх Ухаан	3	1
Түүх, Нийгмийн Шинжлэх Ухаан	3	1
Эрүүл Мэнд, Биеийн Тамир	2	
Дэлхийн Хэлүүд Дүрслэх Урлаг эсвэл Мэргэжил, Техникийн Боловсрол	2	
Эдийн Засаг, Хувийн Санхүү	1	
Сонгон Судлах Хичээл	4	Энэхүү шаардлагыг хамгийн багадаа 2 дараалсан сонгон судлах хичээлийг үзсэн байна.
Нийт	22	5

Төгсөх Нэмэлт Шаардлагууд

- AP Хөтөлбөр, Өргөмжлөл, Олон Улсын Бакалаврын сургалт (OUB), эсвэл Мэргэжлийн болон Техникийн Боловсролын Үнэмлэх - Чанарын Стандартын дагуу сурагчид (1) AP Хөтөлбөрт хамрагдах, Өргөмжлөл авах, эсвэл Олон Улсын Бакалаврын сургалтанд хамрагдах, эсвэл (ii) сурагчийн сонгосон мэргэжил техникийн үнэмлэх бэлэн бус эсвэл сурагчийн ур чадварыг хангалттай хэмждэггүй тохиолдолд сурагч тухайн сэдвийн хүрээнд стандарт дипломын шаардлага хангахуйц чадамжид суурилсан зааварчилгаа авах ба үүнээс өөр тохиолдолд зөвлөлөөс баталсан баталсан техникийн боловсролын үнэмлэх аван төгсөнө. Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн болон техникийн боловсролын үнэмлэх авахад мэргэжлийн гэрчилгээ, улсын лицензийн шалгалт, үндэсний мэргэжлийн ур чадварын үнэлгээ, эсвэл Виржиниа муж дахь ажлын байрны бэлэн байдлын үнэлгээ зэрэг багтана.
- Виртуал Хичээл – Сурагчид кредиттэй эсвэл сонгон судлах кредитгүй хичээлийг онлайн хэлбэрээр амжилттай үзэн судлах шаардлагатай.
- Анхан шатны тусламжийн сургалт, зүрх уушигны сэхээн амьдруулах (CPR), автомат гадаад дефибрилятор (AED) - Сурагчид анхан шатны тусламж, CPR, автомат гадаад дефибриляторийг (AED) ашиглан практик сургалтанд хамрагдан зүрх уушигны сэхээн амьдруулах чадварт суралцана. Энэхүү сургалтанд хамрагдахгүй боломжгүйг баталсан IEP эсвэл 504 план баримттай сурагчид [8vac20-131-420 B](#) -нд зааснаар энэ шаардлагаас чөлөөлөгдөнө.

- Таван С чадварын биелэлт – Сурагчид зөвлөлөөс баталсан Виржиниа Мужийн Танилцуулгад заасны дагуу эргэцүүлэн бодох, бүтээлчээр сэтгэх, хамтран ажиллах, харилцах болон иргэний суурь чадварыг эзэмшин харуулах болно.

Гүнзгийрүүлсэн Сургалтын Дипломын Шаардлагууд.

2018-19 оны **9-р ангиас эхлэн** бүх сурагчид шаардагдсан стандарт ба баталгаажсан кредит оноог авна.

Гүнзгийрүүлсэн Сургалтын Дипломтой төгсөхийн тулд сурагчид заавал үзэх ёстой болон сонгон суралцах хичээлүүдийг амжилттай үзэж дуусган хамгийн багадаа 26 кредит оноо авах болон хичээлийн төгсгөлд SOL шалгалт эсвэл бусад Боловсролын Зөвлөлөөр батлагдсан шалгалтанд тэнцсэнээр хамгийн багадаа 5 кредит оноо цуглуулах ёстой.

Хичээлийн Салбар	Шаардлагатай Кредит Оноо	Шаардлагатай Баталгаажсан Кредит
Англи Хэл (уншлага, бичиг)	4	2
Математик	4	1
Шинжлэх Ухаан	4	1
Түүх, Нийгмийн Шинжлэх Ухаан	4	1
Дэлхийн Хэлүүд	3	Нэг хичээлийг гурван жил үзэх эсвэл хоёр хэлийг тус бүр хоёр жил үзэх
Эрүүл Мэнд, Биеийн Тамир	2	
Дүрслэх Урлаг эсвэл Мэргэжил, Техникийн Боловсрол	1	
Эдийн Засаг, Хувийн Санхүү	1	
Сонгон Судлах Хичээл	3	Энэхүү шаардлагад хамгийн багадаа 2 дараалсан сонгон судлах хичээлийг үзсэн байна.
Нийт	26	5

Дараалсан Сонгон Судлах Хичээлийн Удирдамж

Ахлах Сургуулийн Стандарт Диплом эсвэл Тусгай Хэрэгцээтэй Иргэдэд Зориулсан Стандарт Диплом авахын тулд сурагчид хамгийн багадаа дараалсан хоёр сонгон судлах хичээл суралцах ёстой. Дараалсан сонгон судлах хичээлүүд нь сурагчид түвшин ахих тусам тухайн сэдвийн агуулга, хамрах хүрээ нь нэмэгдэх эсвэл өргөжин тэлэх юм. Сургууль төгсөхөд тусгайлан шаардагдаагүй тохиолдолд эдгээр хичээлүүд нь ямар ч салбарын байж болно. Дүрслэх Урлаг эсвэл Технологийн Хичээлийн нэг кредитэй дүйцдэг хичээлүүд энэ шаардлагыг хангана. Энэхүү шаардлагыг хангахын тулд анхан шатны хичээл, ахисан шатны хичээл гэсэн дараалалд ашиглах боломжгүй; Гэсэн хэдий ч анхан шатны хичээл, үргэлжлүүлэн ялгаатай түвшний адил хичээл үргэлжлүүлэн үзэж болно. Сурагчид сонгон суралцах хичээлүүдийг дарааллын дагуу жил дараалан эсвэл ахлах сургуулийн дараалаагүй хоёр жилд үзэх боломжтой. Зөвлөхүүд энэ шаардлагыг хангахын тулд сурагчдад хичээл сонгоход нь туслана. Гүнзгийрүүлсэн Сургалтын Диплом горилж буй сурагчид Дэлхийн Хэлүүд хичээлийн 1-с 3-р түвшинг сонгох боломжгүй. Харин энэ шаардлагад зөвхөн дэлхийн хэлний 4, 5-р түвшингүүд тооцогдоно.

Диплом

Сурагчийн 9-р ангид орох жилээс хамааран сурлагын өндөр амжилт эсвэл онцлох амжилтыг харуулсан сурагчид дараах шагналуудын аль нэгийг нь авах боломжтой.

- Гүнзгийрүүлсэн Сургалтын Дипломын шаардлагыг "B" болон "B"-ээс дээш үнэлгээтэй давсан, мөн AP түвшний сургалтанд (AP), эсвэл Олон Улсын Бакалавр (ОУБ), эсвэл Хос элсэлтийн Сургалтанд хамгийн багадаа 9 шилжүүлж болох AP кредит авсан сурагчдын диплом дээр Засаг Даргын тамгыг гардуулна.
- Стандарт Диплом эсвэл Гүнзгийрүүлсэн Сургалтын Дипломын шаардлагыг дунджаар "A" үнэлгээтэй давсан сурагчдын диплом дээр Боловсролын зөвлөлийн тамгыг гардуулна.

Амжилттай Төгсөгчдөд Гардуулах Тамганууд

Төгсөхөд тавигдах тодорхой шаардлагуудыг хангаж, үлгэр жишээ амжилт үзүүлсэн сурагчдын диплом дээрээ онцгой тэмдэгтэй төгсөнө. Виржиниа мужийн Боловсролын Алба Арлингтоны улсын сургуулиуд болон бусад орон нутгийн сургуулиудад дараах тамгыг ашиглах боломжийг олгодог:

- **Засаг Даргын тамгыг** Гүнзгийрүүлсэн Сургалтын Дипломын шаардлагыг "В" болон "В"-ээс дээш үнэлгээтэй давсан, мөн AP түвшний сургалтанд (AP), эсвэл Олон Улсын Бакалавр (ОУБ), Кэмбридж, эсвэл Хос элсэлтийн Сургалтанд хамгийн багадаа 9 шилжүүлж болох AP кредит авсан сурагчдад олгоно.
- **Боловсролын Зөвлөлийн Тамгыг** Стандарт Диплом, Гүнзгийрүүлсэн Сургалтын Дипломын шаардлагыг дунджаар "А" үнэлгээтэй давсан сурагчдад олгоно.
- **Боловсролын Зөвлөлийн Мэргэжил, Техникийн Тамгыг** дараах болзлыг биелүүлсэн сурагчдад олгоно:
 - ❖ Стандарт эсвэл Гүнзгийрүүлсэн Сургалтын Диплом авах болзол хангасан, мэргэжлийн болон техникийн боловсролын төвлөрөл эсвэл мэргэшсэн хичээлүүдэд "В" эсвэл "В"-с дээш үнэлгээтэй суралцах.
 - ❖ ЭСВЭЛ сертификат юм уу мэргэжлийн ур чадварын үнэмлэх олгодог хүлээн зөвшөөрөгдсөн салбар, худалдаа, мэргэжлийн холбоодын мэргэжил техникийн боловсролын төвлөрөл болон мэргэшлийн шалгалтанд тэнцэх эсвэл ур чадварын үнэлгээнд амжилттай оролцох
 - ❖ ЭСВЭЛ Виржиниа муж улсаас мэргэжлийн болон техникийн боловсролын чиглэлээр мэргэжлийн үнэмлэх авах.

Боловсролын Зөвлөл эдгээр шаардлагыг хангасан бүх мэргэжлийн үнэмлэх, шалгалтыг хүлээн зөвшөөрнө.

http://www.doe.virginia.gov/instruction/career_technical/path_industry_certification/index.shtml вэбсайт руу орон одоогоор батлагдсан лиценз ба шалгалтуудыг харна уу.

- **Боловсролын Зөвлөлийн Гүнзгийрсэн Математик, Технологийн Тамгыг** Стандарт Диплом эсвэл Гүнзгийрүүлсэн Сургалтын Диплом авах болзол хангасан ба Гүнзгийрүүлсэн Сургалтын Дипломны математикийн бүх шаардлагуудыг (Алгебр II-г багтаасан 4 кредит оноо; 2 баталгаажсан кредит оноо) дунджаар "В" болон "В"-с дээш үнэлгээтэй давсан байх ба:
 - ❖ Гэрчилгээ олгодог мэргэжлийн болон техникийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн салбар, худалдаа, мэргэжлийн холбоодоос олгох шалгалтанд тэнцэх.
 - ❖ ЭСВЭЛ Виржиниа муж улсаас мэргэжил болон техникийн боловсролын чиглэлээр мэргэжлийн үнэмлэх авах.
 - ❖ ЭСВЭЛ технологи эсвэл компьютерийн чиглэлээр AP түвшний кредит олгох Зөвлөлөөс батлагдсан шалгалтыг өгөх.

Боловсролын Зөвлөл эдгээр шаардлагыг хангасан бүх мэргэжлийн үнэмлэх, шалгалтыг хүлээн зөвшөөрнө.

http://www.doe.virginia.gov/instruction/career_technical/path_industry_certification/index.shtml вэбсайт руу орон одоогоор батлагдсан лиценз ба шалгалтуудыг харна уу.

- **Боловсролын Зөвлөлийн Иргэний Эрх Зүйн Тамгыг** дараах 4 шалгуурт тэнцсэн сурагчдад гардуулна:
 - ❖ Тусгай Хэрэгцээтэй Иргэдэд Зориулсан Стандарт Диплом, Стандарт Диплом болон Гүнзгийрүүлсэн Сургалтын Дипломны аль нэгийг авах болзол хангах
 - ❖ Виржиниа ба АНУ-ын түүх, Виржиниа АНУ-н Засгийн Газар хичээлүүдийг “В” эсвэл “В”-с дээш үнэлгээтэй сурах.
 - ❖ Сурагчид ядуу, өвчтэй болон эмзэг бүлгийн хүмүүст үйлчилгээ үзүүлдэг ашгийн бус болон шашны байгууллагад сайн дурын ажил хийх гэх мэт олон нийтийн ажилд эсвэл олон нийтийн сайн дурын үйл ажиллагаанд 50 цаг ажиллах; хөвгүүдийн скаут, охидын скаутууд эсвэл ижил төстэй залуучуудын байгууллагуудад оролцох, Өсвөрийн Нөөцийн Офицер Бэлтгэх Корпус-д (ӨНОБК) хамрагдах; улс төрийн кампанит ажил, засгийн газрын дадлага ажилд оролцох, Хөвгүүдийн Муж, Охидын Муж болон Үлгэр Жишээ Нийтийн Хуралдаанд оролцох; болон АНУ-ын цэргийн хүчинд алба хаах зэрэгт төгсөхөөсөө өмнө оролцох нь олон нийтийн үйлчилгээний энэхүү шаардлагыг хангасанд тооцно.
 - ❖ Хичээлийн сайн ирцтэй байх ба сургуулийн зөвлөлийн бодлогоор тодорхойлсон сахилгын зөрчилгүй байх.

- Боловсролын Зөвлөлийн Хоёр Хэл Эзэмшсэний Тамгыг Боловсролын Зөвлөлөөс баталсан дипломыг авах болзол хангасан болон дараах шаардлагуудыг хангасан сурагчдад олгоно:
 - ❖ Англи Хэлний уншлага болон бичгийн хичээлийн төгсгөлийн шалгалтыг мэргэжлийн болон түүнээс дээш түвшинд давах.
 - ❖ Англи хэлнээс бусад нэг буюу хэд хэдэн хэл дээр дунд болон дундаас дээд түвшний мэдлэг эзэмшсэн гэдгээ Олон нийтийн сургалтын ахлах ажилтны баталсан жагсаалтны үнэлгээнд батлан харуулах. Америкийн дохионы хэл нь англи хэлнээс ялгаатай хэлэнд тооцогдоно.

- Боловсролын Зөвлөлийн Шинжлэх Ухаан, Хүрээлэн Буй Орчны Тамгыг 2018-19 жил ба түүнээс хойш удаа есдүгээр ангид элсэн орсон бөгөөд дараах шалгууруудыг хангасан сурагчдад олгоно:
 - ❖ Стандарт Диплом эсвэл Гүнзгийрүүлсэн Сургалтын Диплом авах болзол хангах
 - ❖ Хамгийн багадаа Зөвлөлөөс баталсан 3 өөр шинжлэх ухааны лабораторийн хичээл үзэх ба, хамгийн багадаа нэг гүнзгийрүүлсэн түвшний эсвэл коллежийн түвшний лаборатори хичээл үзэх.

Коллеж-д элсэх Тамирчин-сурагчдын Үндэсний Коллежийн-Тамирчдын Холбоонд (NCAA) Хамрагдах Шаардлага

I хэлтэс эсвэл II хэсэгд эхний жилдээ спортын тэтгэлэг аван бэлтгэл хийх, тэмцээнд оролцох, зорилготой сурагчид NCAA-н бүртгэлийн төвөөр дамжуулан хамрагдах эрхээ баталгаажуулсан байх ёстой. NCAA-н бүртгэлийн албаны ажилчид сурагчид, сурагчдын гэр бүл, болон ахлах сургуулийн удирдлага болон дасгалжуулагчтай хамтран ажиллана.

NCAA-н I хэсгийн Шаардлагууд

Эхний жилдээ курсдээ санхүүгийн тусламж аван бэлтгэл хийх, тэмцээнд оролцох сурагчид:

- NCAA-д www.eligOVBilitycenter.org -р дамжуулан бүртгүүлнэ
- Батлагдсан 16 хичээлд зөвшөөрөгдөх хамгийн бага голч оноог даван суралцах
- SAT эсвэл АСТ шалгалтын нийт оноо үндсэн хичээлийн голч дүнтэй дүйцэх (Коллежийн Суралцагч Тамирчинд зориулсан NCAA гарын авлагаас "харьцангуй А" -г үзнэ үү)
- NCAA-ийн бүртгэлийн системд дахин нэвтэрч, сонирхогчдын эцсийн гэрчилгээ хүсэх шаардлагатай.
- Ахлах сургуулийг төгсөх

2016 оны 8 сарын 1-с хойш элссэн сурагчид сургуулийн шинэ болзлыг хангана.

Сурагч-тамирчид дараах гурван академик сертификаттай статусын аль нэгэнд ангилагдана.

- Академийн Бүх Шаардлагыг Хангасан
- Шаардлага Хангаагүй
- Академикийн Шаардлагыг Хангасан

Академикийн Шаардлагыг Хангасан:

- Эхний жилдээ спортын тэтгэлэг аван бэлтгэл хийн, тэмцээнд оролцох эрхтэй

Академикийн Шаардлага Хангаагүй:

- Эхний жилдээ спортын тэтгэлэг авах, бэлтгэл хийх, тэмцээнд оролцох эрхгүй

Академикийн Шаардлагыг Хангасан:

- Эхний жилдээ спортын тэтгэлэг аван бэлтгэл хийх эрхтэй боловч тэмцээнд оролцох эрхгүй. Хоёрдох улиралдаа бэлтгэх хийх эсэх нь Суралцагчийн коллеж эсвэл AP эхний жилдээ гаргасан сурлагын амжилтаас хамаарна.

NCAA-н II хэсгийн Шаардлагууд

Эхний жилдээ курсдээ санхүүгийн тусламж аван бэлтгэл хийх, тэмцээнд оролцох сурагчид:

- NCAA-д www.eligOVBilitycenter.org -р дамжуулан бүртгүүлнэ
- Ахлах сургуулийг төгсөх
- 16 батлагдсан хичээлд хамгийн багадаа 2.0 голч оноотой суралцах ба SAT -н нийлбэр шалгалтанд (уншлага ба математик) хамгийн багадаа 820 оноо авах эсвэл АСТ шалгалтанд хамгийн багадаа 68 оноо авах
- II хэсэгд харьцангуй дүгнэлт байхгүй
- NCAA-ийн бүртгэлийн системд дахин нэвтэрч, ахлах сургуулийн сүүлийн жилийн 4-р сард сонирхогчдын эцсийн гэрчилгээ хүсэх шаардлагатай.

I ба II хэсгийн Үндсэн-Хичээлийн Задаргаа

- Англи Хэл
- Математик
- Байгалийн эсвэл Физикийн Шинжлэх Ухаан
- Нийгмийн Ухаан
- Гадаад Хэл
- Харьцуулсан Шашин Судлал эсвэл Гүн Ухаан (зарим нөхцөлд)

Хичээлийн Шаардлагууд:

- Хичээл нь академик, коллежийн дөрвөн жилийн бэлтгэлд багтсан байх ёстой.
- Хичээл нь ахлах сургуулийн ердийн академиик түвшинд эсвэл түүнээс түвшинд байх ёстой.
- Математикийн хичээлүүд нь Алгебр I эсвэл түүнээс илүү түвшинд байна.
- Албан ёсны академик байгууллагаас тодорхойлсон шаардлагын дагуу мэргэшсэн багш хичээлийг заана.

Жич: 2016 оны 8-р сарын 1-с эхлэн сурагчийн Ахлах Сургуулийн 7-р улирлаас өмнө I хэсэг сургуулиас үзэж судалсан 10 хичээлийг голч дүнг тооцоолох зорилгоор ахин сурах боломжгүй болно.

Англи хэл сайжруулах хичээлүүд (ELD) нь ахлах сургуулийн NCAA -н зөвшөөрөгдсөн хичээлд тооцогдохгүй.

NCAA-н жагсаалтад зөвшөөрөгдөхгүй хичээлүүд

- Жолоочийн боловсрол, арван хуруугаар бичих, хөгжим, биеийн тамир эсвэл авто кузов зэрэг мэргэжлийн ангиуд болон дүрслэх урлагийн хичээлүүд, болон бусад үндсэн бус хичээлүүд
- Сурагчдыг ажил мэргэжил, амьдралд эсвэл хувийн санхүү, хэрэглэгчийн боловсрол эсвэл технологийн бэлтгэл гэх мэт хоёр жилийн коллеж, техникийн сургуульд бэлтгэдэг хичээлүүд.
- Хичээлийн түвшингээс доогуур, хурд багатай сурагчдаас хүчин чармайлт харьцангуй бага шаарддаг танилцуулсан анхан шатны хичээлүүд
- Шалгалт-өгөн-кредит-авдаг хичээлүүд NCAA-с батлагдсан үндсэн хичээлд тооцогддоггүй.

NCAA.org/course list вэбсайт руу орон нийт NCAA-с зөвшөөрөгдсөн хичээлүүдийг харна уу.

Уламжлалт Бус ба Онлайн Хичээлүүд

Уламжлалт бус хичээлүүдэд онлайнгаар эсвэл зайнаас, кредит нөхөн сурах, бие даан суралцах, ганцаарчилсан сургалт эсвэл захидал харилцааны аргаар заадаг хичээлүүд орно.

Уламжлалт бус хичээлүүд NCAA-аас батлагдсан үндсэн хичээлд тооцогдохын тулд:

- Энэхүү сургалт нь уламжлалт танхимын нөхцөлд заадаг хичээлтэй харьцуулахуйц хугацаа, агуулга, хүчин чармайлт шаардагддаг байх бөгөөд коллежийн дөрвөн жилийн бэлтгэл хичээлд багтсан байх ёстой
- Бүх хичээлүүдэд багш, сурагчдын хооронд, заах, шалгах, туслалцаа үзүүлэх зорилгоор тогтмол болон байнгын харилцаа байна.
- Хичээл тодорхой тогтсон хугацаанд үргэлжлэнэ.
- Уламжлалт бус хичээлүүд нь ахлах сургуулийн аттестат дээр уламжлалт бус хичээл гэж тодорхой ялгагдсан байна.

Академик Гэрчилгээ Олгох Эрт Үе Шат

Хэрэв сурагч эхний зургаан улирлын дараа тодорхой шалгуурыг хангасан бол түүнийг I хэсгийн академик шаардлагыг хангасан гэж үзэн элссэн эхний жилдээ бэлтгэл хийж, тэмцээнд оролцож, спортын тэтгэлэг авах боломжийг олгоно.

I хэсэг: Хамгийн багадаа SAT шалгалтын (математик ба уншлага) оноо нь 900 эсвэл ACT шалгалтын оноо 75 байх

Хамгийн багадаа 14 хичээлийн голч дүн нь 3.0-с доошгүй байна

- 3 – Англи хэл
- 2 – Математик
- 2 – Шинжлэх Ухаан
- 2 – Нэмэлт Англи хэл, Математик, ШИНжлэх Ухаан
- 2 – Аль нэг салбарын үндсэн хичээл

II хэсэг: Хамгийн багадаа SAT шалгалтын (математик ба уншлага) оноо нь 1000 эсвэл ACT шалгалтын оноо 85 байх

Хамгийн багадаа 12 хичээлийн голч дүн нь 3.0-с доошгүй байна

- 3 – Англи хэл
- 2 – Математик
- 2 – Шинжлэх Ухаан
- 5 – Аль нэг салбарын үндсэн хичээл

Үсгэн Дүн	Хувь	Чанарын Оноо	Коллеж Хичээл, ОУБ, Хос Элсэлтийн Чанарын Оноо
A	90, 91, 92, 93, 94, 95, 96, 97, 98, 99, 100	4.0	5.0
B+	87, 88, 89	3.5	4.5
B	80, 81, 82, 83, 84, 85, 86	3.0	4.0
C+	77, 78, 79	2.5	3.5
C	70, 71, 72, 73, 74, 75, 76	2.0	3.0
D+	67, 68, 69	1.5	2.5
D	60, 61, 62, 63, 64, 65, 66	1.0	2.0
E	0 – 59	0.0	0.0

Коллежид элсэхдээ ихэнх материалыг ахлах сургуулийн жилийн эхээр шуудангаар илгээх шаардлагатай байдаг тул сурагчийн голч дүнг ахлах сургуулийн 3-р жилийн эцсээр тооцоолдог. Голч дүн эцсийн байдлаар ахлах сургуулийн сүүлийн жилийн эхний улирлын эцэст бэлэн болдог. Коллежийн Хөтөлбөрт хамрагдсан сурагчдын дүнгийн үнэлгээ (сурагч Коллежийн Хөтөлбөрийн шалгалтандаа орсон бол) жирийн хичээлээс авсан дүнгийн үнэлгээнээс илүү байна. Голч оноог тооцоолохдоо Коллежийн Хөтөлбөр, Олон Улсын Бакалавр, Хос Элсэлтийн дүнг сурагчийн тухайн үед элсэн байгаа хичээлийн дүнд тооцно.

Коллежийн Хөтөлбөр

Коллежийн хөтөлбөр (AP) ба Олон Улсын Бакалаврын (ОУБ) хичээлүүдэд хамрагдсан сурагчид холбогдох шалгалтуудыг өгөх ёстой. Эдгээр шалгалтыг өгснөөр сурагчид коллежийн кредит авах боломжтой бөгөөд шаардлага хангасан дүн авсан тохиолдолд сурагчдын эрэмбэ жагсаалтад нөлөөлнө. Коллежийн Хөтөлбөр, Олон Улсын Бакалаврын шалгалтын төлбөрийг Арлингтоны Улсын Сургуулиуд сурагч тухайн ангид элссэн л бол төлнө.

Хос Элсэлт

Хос элсэлт нь сурагчдад ахлах сургуульд суралцах хугацаандаа өөрийн сонирхолд нийцсэн AP хөтөлбөрийн коллеж, AP хичээлийг үзэх боломжийг олгодог. Хос элсэлтэнд амжилттай суралцсаны дараа сурагчид ахлах сургууль болон коллежийн кредиттэй төгсдөг. Сурагчид эдгээр ангиудад элсэхээсээ өмнө коллежийн тогтоосон элсэлтийн шаардлаганд тэнцсэн байх ёстой. Цуглуулсан коллежийн кредитийг бусад коллежид шилжүүлж болно.

Анги тус бүрт тогтоосон шалгуурыг хангасан ахлах сургуулийн 3-р болон 4-р жилийн сурагчид Хойд Виржиниа Олон Нийтийн Коллеж (NOVA) -аар дамжуулан санал болгож буй хос элсэлтийн хичээлүүдийг авах боломжтой. Ахлах сургуулийн 1-р болон 2-р жилийн сурагчдын нөхцөл байдлыг харгалзан хос элсэлтэнд хамрагдахыг зөвшөөрч болно. NOVA-ийн хос элсэлт хичээлд хамрагдах хүсэлтэй сурагчид тогтоосон шалгуурыг олон аргаар хангаж болно (Виржиниа Мужийн Түвшин Тогтоох Шалгалт эсвэл SAT, PSAT, ACT, AP эсвэл SOL -н хангалттай өндөр оноотой байх). Хос элсэлтийн хичээлд хамрагдах шаардлага, боломж, Хос Элсэлтээр авсан чанарын оноо, шилжүүлэх боломжийн талаархи мэдээллийг зөвлөгчөөсөө авна уу. Хос Элсэлтийн хичээлд хамрагдсан сурагчдад зохих ёсны байгууллагаас дүнгийн хуулбарыг авдаг. Түвшин Тогтоох Шалгалт, Шалгуулах өөр хувилбарууд, хаврын шалгалтын огноо, шалгалтын газрын талаар дэлгэрэнгүй мэдээллийг дараахь онлайн холбоосоор орж авна уу: www.apsva.us/dualenrollment.

Сургалтын Стандарт Үнэлгээ

Виржиниа мужийн сургалтын стандарт (SOL) дээр суурилсан тестийг муж даяар явуулдаг Хичээлийн жилийн эцэст. Бүх сурагчид 3, 4, 5, 6, 7, 8-р ангийн төгсгөлд SOL шалгалт өгнө. Мөн дараах хичээлд хамрагдсан бүх сурагчид хичээлийн төгсгөлд SOL шалгалт өгнө.

- | | |
|---------------------------------|---------------|
| Англи Хэл 11: Уншлага | Алгебр I |
| Англи Хэл 11: Бичиг | Геометр |
| 1500 AD он хүртэлх Дэлхийн Түүх | Алгебр II |
| 1500 AD он хүртэлх Дэлхийн Түүх | Дэлхий Судлал |
| Дэлхийн Газарзүй | Биологи |
| АНУ-н Түүх | Хими |

Бүх сурагчид Стандарт диплом авах болзол хангахын тулд 5 төгсгөлийн шалгалтанд (ЕОС) тэнцэх ёстой ба Гүнзгийрүүлсэн Сургалтын Диплом авах болзол хангахын тулд 9 төгсгөлийн шалгалтанд тэнцэх ёстой. Дээрхийг харна уу. Диплом авахын тулд шалгалт өгөх шаардлагатай сурагчдад эдгээр шалгалтын аль нэгэнд нь тэнцээгүй тохиолдолд дахин шалгалт өгөх нэмэлт боломж олгоно. Шалгалтыг 1, 6, 8-р саруудад явуулна.

Виржиниа мужийн сургалтын стандартын шаардлагууд

9-р Анги

- Бүх сурагчид Хичээлийн Төгсгөлийн Математикийн Стандартын Сурлагын Амжилт Тодорхойлох Шалгалт өгнө
- Бүх сурагчид Хичээлийн Төгсгөлийн Шинжлэх Ухааны Стандартын Сурлагын Амжилт Тодорхойлох Шалгалт өгнө (Биологи эсвэл Хичээлийн Төгсгөлийн Шинжлэх Ухааны)

10-р Анги

- Сурлагын Амжилт Тодорхойлох Стандарт зөвхөн дараах тохиолдолд байна
 - Сурагчдад Математик, Шинжлэх Ухаан, эсвэл Түүхийн хичээлд баталгаажсан кредит хэрэг болсон бол
 - Хэрэв сурагч Биологийн хичээл үзээгүй бол

11-р Анги

- Бүх сурагчид Хичээлийн Төгсгөлийн Уншлага ба Бичгийн Стандартын Сурлагын Амжилт Тодорхойлох Шалгалт өгнө
- Математик, Шинжлэх ухаан, Түүхийн чиглэлээр баталгаажсан кредитгүй (Сурлагын Амжилт Тодорхойлох Стандартад 400 ба түүнээс дээш оноотой) сурагчид

12-р Анги

- Шаардлагатай 4 хичээлийн салбард Баталгаажсан Кредит хэрэгтэй сурагчид (Сурлагын Амжилт Тодорхойлох Стандартад 400 ба түүнээс дээш оноотой)

Виржиниа мужийн Боловсролын зөвлөлөөс баталгаажсан кредит оноонд шилжиж болох шалгалт болон босго оноог баталсан. Орлуулах шалгалтын жагсаалтыг ахлах сургууль бүрийн Зөвлөх үйлчилгээний газрын даргаас дараах хаягаар үзэх боломжтой http://www.doe.virginia.gov/testing/substitute_tests/index.shtml

Төгсөхийн тулд баталгаажсан кредит хэрэгтэй сурагчид хэрвээ хичээлдэй амжилттай суралцсан ч Шинжлэх Ухаан Ба Нийгмийн Ухааны хичээлийн Төгсгөлийн Шалгалтанд унасан бол өргөдөл гаргах боломжтой ба өргөдөл гаргах талаархи мэдээллийг Зөвлөх үйлчилгээний хэлтсээс авах боломжтой.

Шалгалтын Дүн

Сурагчдын өгсөн шалгалтын үр дүнг шалгалтын дараа эцэг эхчүүдэд шуудангаар илгээнэ. Коллежийн Хөтөлбөрийн шалгалтын дүнг зөвхөн Суралцагчид шууд илгээх болно. Арлингтоны сургуулиудын үр дүн Арлингтон Улсын Сургуулийн дараах вэбсайтад шууд тавигдана <http://www.apsva.us>.

Дэмжих Ажиллагааны Удирдамж


Ихэвчлэн, ахлах сургуулийн сурагчийн хамрагдсан англи хэлний хичээл нь тухайн ангийн түвшинг тодорхойлно. Тиймээс Англи Хэл 9-д элссэн сурагчийг 9-р ангийн сурагч гэж үзнэ. 12-р ангийн сурагч гэж тооцогдохын тулд сурагч тухайн жилийн хөтөлбөртөө хичээлийн жилийн эцэс гэхэд эсвэл зуны сургалтын төгсгөлд төгсөх шаардлагыг хангах хичээлийг сонгосон байх ёстой.

Жич: Хэрэв Стандарт Диплом горилж буй сурагч 10-р ангийг дор хаяж 4 баталгаажсан кредит авахгүйгээр төгссөн бол тухайн сурагч хэрэв шаардлагатай хичээл болон төгсгөлийн шалгалтанд (SOL) тэнцээгүй бол зуны сургалтанд хамрагдан тухайн хичээлийг давтан үзэн эсвэл хичээлд амжилттай суралцсан ч төгсгөлийн шалгалтанд тэнцээгүй бол зөвхөн төгсгөлийн шалгалтанд бэлдэх сургалтанд хамрагдана. Хэрэв сурагч шаардлагатай зуны сургалтанд хамрагдаагүй бол 11-р ангидаа төгсгөлийн шалгалтанд бэлдэх Хичээлийг сонгох судлах хичээлээр тооцуулан сурж болно.

Төлбөр

Зарим хичээлүүд Арлингтон Улсын сургуулиудаас хангамжинд өгдөггүй материалуудын төлбөр шаарддаг. Шаардлагатай төлбөрийг хичээлийн тайлбарт оруулдаг. Сурагчийн гэр бүл холбогдох төлбөрийг төлөх боломжгүй тохиолдолд төлбөрийг бууруулах эсвэл чөлөөлөх хүсэлтийг сургуульд гаргаж болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг ахлах сургуулийн зөвлөгөө өгөх албанаас авна уу.



СУРАГЧДАД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ, ТУСГАЙ БОЛОВСРОЛ

Гэрээсээ Сурах Сургалт

Гэрийн сургалт нь эрүүл мэндийн биеийн/сэтгэлзүйн байдлаас шалтгаалан тодорхой сургуулийн орчинд суралцаж чадахгүй сурагчдад зориулсан болно. Гэрийн сургалт нь мөн эрүүл мэндийн байдлаас (жишээлбэл, диализ, туяа/химийн эмчилгээ хийлгэж буй сурагчид эсвэл эрүүл мэндийн бусад хүнд өвчтэй сурагчид) шалтгаалан өдөр тутмын хичээлд тасралтгүй суралцаж чадахгүй сурагчдын сурлагыг дэмжих зорилгоор хэрэгжүүлж болно. Гэрийн сургалтанд хамрагдах бүртгэлийн хуудсыг дараах Арлингтон Улсын Сургуулиудын вэбсайт дээр байрлуулсан болно <https://www.apsva.us/homebound-instruction>. Мөн бүртгэлийн хуудсыг сургуулиас авж болно. Бүртгэлийн хуудсыг сурагч өөрийн сургуульд эхлээд танилцуулсны дараа хүсэлтийг Тусгай Боловсролын Ажилтан батлана. Ганцаарчилсан Боловсролын Хөтөлбөр (IEP) шаардлагатай сурагчдын хүсэлтийг Ганцаарчилсан Боловсролын Хөтөлбөрийн баг хуралдан сургалтын хэрэгцээ болон түвшинг тодорхойлсоны дараа батлана. Гэрийн сургалтын хэрэгцээтэй байдлыг есөн долоо хоног тутам нягтлан шалгана.

Сурагчдад Үзүүлэх Үйлчилгээ

Сургуулиудад сэтгэлзүйн үйлчилгээ тогтмол явагддаг. Сургуулийн сэтгэл зүйчид шаардлагатай үед сурагчдын оюуны, нийгэм, сэтгэл зүйн хөгжлийн талаар эцэг эх, багш нартай зөвлөлддөг ба хувь хүний сэтгэл зүйн үнэлгээ мөн өгдөг. Сургуулийн нийгмийн ажилтнууд сургууль ба гэр эсвэл олон нийтийн хоорондын холбоо болж ажилладаг. Сургуулийн сэтгэлзүйчид мөн нийгмийн болон сэтгэл санааны асуудал, санхүүгийн хэрэгцээ, хичээлийн ирц эсвэл сурлагын амжилтанд саад болж болзошгүй бусад бэрхшээлтэй тулгарсан сурагч болон сурагчийн гэр бүлд туслах нөөц боломжийг тодорхойлдог. Сэтгэл судлаачид болон нийгмийн ажилтнууд сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой олон нийтийн байгууллагуудтай нягт харилцаатай байдаг.

Эрүүл Мэнд

Сургуулийн Хүний Үйлчилгээ болон Эрүүл Мэндийн хэлтэс нь сурагчид болон тэдний гэр бүлд урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх замаар сурагчдад өөрт буй хамгийн сайн нөөц бололцоогоороо сурах боломжийг олгодог.

504-р Хэсэг

1973 оны Нөхөн Сэргээх тухай хуулийн 504-р хэсэгт төрөөс санхүүгийн туслалцаа авж буй аль нэг хөтөлбөрт хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхахыг хориглодог. Арлингтон Улсын Сургуулиуд боловсрол олгохдоо ялгаварлан гадуурхалаас зайлсхийх, засан залруулах бодлогыг баримтлан хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад хөгжлийн бэрхшээлгүй хүмүүстэй адил боловсролын үйлчилгээ боломж авах эрхийг баталгаажуулна. 504-р хэсэгт зааснаар, хүн хэрэв (а) хувь хүний амьдралын нэг буюу хэд хэдэн томоохон үйл ажиллагааг ноцтой хязгаарладаг бие бялдар, сэтгэцийн бэрхшээлтэй бол (өөрийгөө асрах, энгийн хөдөлгөөн хийх, алхах, харах, сонсох, ярих гэх мэт үйлдэлд саад болох), (б) өмнө нь хөгжлийн бэрхшээлтэй байсан гэсэн бүртгэлтэй эсвэл (в) дээр дурдагдсан бэрхшээлтэй бол хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж тооцогдоно. Хөгжлийн бэрхшээл болон амьдралын үндсэн үйл ажиллагааг нэг бүрчлэн заах боломжгүй. Мөн хүний үйл ажиллагааг ноцтой хязгаарладаг гэдгийг өргөн утгаар ойлгоно.

Арлингтон Улсын Сургуулиуд хөгжлийн бэрхшээлтэй бүх сурагчдад үнэ төлбөргүй тохирсон боловсрол олгох болно. Эцэг эхчүүд 504-р хэсэгт заасан сурагчдад хамааралтай бүх уулзалтуудад оролцох нь нэн чухал. Эцэг эхчүүд 504-р хэсгийн талаархи асуулт, санал бодлын талаар Зөвлөх Үйлчилгээний Захирал эсвэл сургуулийн захиралд хандах хэрэгтэй. Эцэг эхчүүд хүүхдүүдээ хөгжлийн бэрхшээлтэй хэмээн сургуульд тооцуулах талаар Багшлах, Сурлагын Тэнхимийн 504 Хэсгийн Асуудал Эрхэлсэн Ажилтантай (Суралцагчийн Үйлчилгээ) 703-228-6061 утсаар холбоо барин асуудлаа хүргүүлж болно.

Мансууруулах Бодис Хэрэглээний Талаар Зөвлөх Үйлчилгээ

Арлингтон Улсын сургуулиуд Эрүүл Мэндийн Хөтөлбөрөөр дамжуулан сурагчдад мансууруулах бодисын талаархи мэдээллийг өгдөг. Арлингтон Сургуулиудын сурагчдад Багшлах, Сургалтын алба нь Хүний Үйлчилгээний албатай хамтран мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх, урьдчилан таслан зогсоох үйлчилгээ үзүүлэх чиглэлээр. Зарим нөхцөл байдалд мансууруулах бодисны хэрэглээний үнэлгээг авах хувь хүний нэрийг нууцлан өгөх боломжтой. Сурагчид ба эцэг эхчүүдэд мансууруулах бодисны эмчилгээний үзүүлэх байгууллагыг санал болгон тусламж үзүүлж болно.

НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Сургуулийн номын сан нь багшлах болон суралцах ажиллагааны төв юм. Номын санч нь суралцагчдын бие даан унших, нийт сурагчдын оюуны, сэтгэл хөдлөл, нийгмийн хөгжлийг дэмжих зорилготой хэвлэмэл, дижитал эх сурвалжуудыг хариуцан ажиллана. Суралцагчид энд эргэцүүлэх, бүтээлч сэтгэлгээ, харилцаа холбоо, хамтын ажиллагааны ур чадварыг эзэмшин, насан туршийн амьдралдаа амжилттай мэдээлэл үйлдвэрлэгч болон хэрэглэгч болдог. Номын санч нь хамгийн сүүлийн үеийн цувралуудыг хөтлөн явуулдаг бөгөөд үүнийг сургуульд болон гэрээр олж авах боломжтой. Энэхүү нийт цуглуулга нь сургалтын хөтөлбөр, хөгжлийн хэрэгцээ, нийт суралцагчдын нийгэм, соёл, угсаатны олон янз байдлыг тусгасан болно.

Сургуулийн номын санчид багш нартай хамтран сурагчдад мэдэлийг олох, нягтлах болон олон төрлийн салбарт ашиглахад зааварчилгаа өгнө. Сурагчид мэдэлийг олох, цэгцлэх, баримтжуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэх, нэгтгэх, танилцуулах зорилгоор хэвлэмэл болон дижитал номын сангийн материалыг ашиглана. Мэдэлийг зохистой ашиглахын тулд сурагчдад Зөвшөөрөгдсөн Хэрэглээний Дүрмийг дагаж мөрдөнө. Номын санчид сургалтын хичээл, тусгай хөтөлбөрийг бүтээхэд ажилтнуудтай хамтарч ажиллана. Сургуулийн номын сангууд сурах орчинг сайжруулахын тулд уртасгасан цагаар ажилладаг. Сурагчид болон сурагчдын гэр бүлийхэн сургуулийнхаа номын сангийн вэбсайтад нэвтрэн, мөн Canvas дээрх Номын сангийн үйлчилгээгээр номын сангийн материалуудыг сургууль дээр болон гэртээ ашиглахыг номын сангаас дэмждэг.

НЭМЭЛТ ХӨТӨЛБӨРҮҮД

Н-В Woodlawn Дээд Боловсрол

Сурагчид сонголт бол Н-В Woodlawn-ийн дээд боловсролын хөтөлбөрийн гол чиглэл юм. Сурагчид хамрагдах болзлыг биелүүлэхийн тулд цагаа хэрхэн зөв төлөвлөн шийдэх хэрэгтэй. Сурагчдын чөлөөт цагийг хянах нь 6-р ангиас 12-р анги хүртэл аажмаар буурдаг. Энэхүү нэмэгдсэн хувийн эрх чөлөөг сургуулийн зүгээс сурагчдын хувийн хариуцлагад үлдээдэг бөгөөд үр дүнд нь сурагчид хувьдаа хариуцлагатай цагаа ашиглаж сурдаг.

Бүх сурагчид Н-В Woodlawn -ий хөтөлбөрт ялгаатай хувийн бие даасан байдал ба сурах сэдэлтэй элсдэг. Хөтөлбөрийн багш, ажилчид нь сурагчидтай бие даан, жижиг бүлгээр болон ангийн түвшинд ажиллаж, сурагчдад хөтөлбөрт үр дүнтэй суралцахад тусалдаг. Үүний дагуу сурагчид өөрсдийн үйлдлийг хариуцах болно. 1971 онд "ухаалаг хүмүүст хэлэх үг хангалттай" гэсэн үг нь сургуулийн уриа болж, эрх чөлөөний болон хариуцлагын холбогдлыг тусгасан болно.

Н-В Woodlawn хөтөлбөр нь халамжтай хамт олон, өөрийгөө удирдах чадвар, ба бие даан удирдсан сургалт гэсэн гурван тулгуур баганатай. Сурагчдын удирдсан хурал, сурагчдын санаачилсан сургалт болон клуб, болон долоо хоног болгон зохион байгуулагддаг нийт сурагчид, багш нар болон эцэг эхчүүд тэгш дуу хоолойтоогоор оролцдог "Хотын Хуралд"-р дамжуулан, хөтөлбөрийн нийт бүрэлдэхүүн сурагчдад сурч боловсрон, боловсролын зорилгоо хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор хамтран ажилладаг.

Өсвөр Насны Эцэг Эхчүүдэд Зориулсан Хөтөлбөр

Өсвөр насны эцэг эхчүүдэд зориулсан хөтөлбөрүүд нь Арлингтон хотын жирэмсэн болон эцэг эх болсон өсвөр насныхны өвөрмөц хэрэгцээг хангахад зориулагдсан болно.

Энэхүү хөтөлбөр нь Ажил Мэргэжлийн Төв, Арлингтоний Ахлах Сургууль, Лангстон эсвэл гэр сургуулиудын сурагчдад дэмжлэг үзүүлдэг. Хөтөлбөр нь өсвөр насны эцэг эхчүүдэд бие даан амьдрах чадварыг хөгжүүлэхийн сацуу тэд өөрсдийн хэрэгцээг хангахад дэмжлэг үзүүлэх найрсаг орчинг бүрдүүлдэг. Дэмжлэгт хүнс, орон байр, санхүү, өсвөр насны хүүхдийн эрүүл мэнд, жирэмслэлт, хөхүүл хүүхдээ хөхүүлэхэд өгөх зөвлөгөө, хүүхдийн асрамж, эрүүл мэндийг дэмжих материал зэрэг багтана. Дэмжлэгт мөн аюулгүй байдлын хэрэгцээ, хөдөлмөр эрхлэх ур чадварыг хөгжүүлэх, сурагчдын тээврийн хэрэгслийн асуудлыг тусгадаг. Хөтөлбөр нь нийгмийн, сэтгэлзүйн, эрүүл гэр бүлийн харилцаа, бага насны хүүхдүүдтэй харилцах арга, эцэг эхийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгддэг. Хөтөлбөр нь тухайн сургуулийн орчинд байрлан ажиллан тусгай зөвшөөрөлтэй Хүүхэд Харах Үйлчилгээний Төв, нялх, нярай хүүхдийн үзлэг, лавлагаа, мэдлэгийг санал болгодог.

Сурагчид академик дэмжлэг, сургуульд элсэхэд тусламж, болон сургуулиа төгсөх хүртлээ сургуульдаа үлдэхэд туслалцаа авдаг. Илүү мэдээллийг, 703-228-5818, 5819 or 5767 утсаар лавлан асууна.

**Ахлах Сургуулиа
Үргэлжлүүлэх
Хөтөлбөр**

Лангстон -д хэрэгжиж буй Ахлах Сургуулиа Үргэлжлүүлэх хөтөлбөр нь 16 болон дээш насны сурагчдад зориулсан найрсаг бага хэмжээний орчинд ахлах сургуулийн кредит авах боломжийг олгодог. Лангстон -д ахлах сургуулийн Диплом горилж буй Арлингтоны Улсын Сургуулиудын сурагчдад зориулан англи хэлний хичээлийг санал болгодог. Бидний харьцангуй жижиг үйл ажиллагаа нь сурагчид дунд сургуулийн дипломоо авах зорилготой суралцах зуур үүсч болох зарим асуудлыг уян хатнаар шийдэх тус болдог. Сурагчид энэ хөтөлбөрт олон шалтгааны улмаас орох шаардлага гардаг. Хөтөлбөр нь сурагчдад улирал тутамд нэг, хоёр, гурав, дөрвөн хичээлийг шахан үзэх боломжийг олгодог. Сурагчид нийт дөрвөн хичээлийг нэг улиралд судлан 8 кредит оноог авах боломжтой. Мөн сурагчид хос элсэлт, онлайн сургалт, NOVA-ээр дамжуулан хос элсэлтэнд хамрагдах замаар кредит авах боломжтой. Сурагчид Ажил Мэргэжлийн төв дээр хичээл заалган, гэрийн сургуулийнхаа үйл ажиллагаанд оролцож болно.

**Арлингтоны Ажил
Мэргэжлийн Төв**

Арлингтоны Ажил Мэргэжлийн Төвийн Арлингтон Тек

Арлингтон Тек бол сурагчдыг коллежид амжилттай суралцах, ажлын байран дахь бэрхшээлийг шийдвэрлэхэд бэлтгэх, ахисан шатны төсөлд суурилсан сургалтын хөтөлбөр юм. Сурагчид олон салбараас олж авсан академик мэдлэг болон Карьерын Техникийн Боловсрол (СТЕ) хичээл дээр олж аван ур чадвараа ашиглан бодит амьдралын асуудлыг шийдэн өөрийн орон нутгийн иргэдэд үйлчилгээ үзүүлэх талаар суралцдаг.

Арлингтон Тек нь сурагчдад СТЕ-ийн янз бүрийн чиглэлээр мэргэшиж, Хойд Виржиниа Мужийн Коллежид давхар элсэн Урьдчилсан Коллежийн Кредит аван коллежийн боловсролоо эрт тавих боломжийг олгодог. Төсөлд суурилсан сургалтын туршлагын оргил үе болох Арлингтон Текийн сурагчид дадлагажигч, зөвлөх, бие даасан судлаачаар ажиллан жилийн хугацаанд ахлан сургуулийн сүүлийн жилийн төсөл хэрэгжүүлдэг. Арлингтон Тек дээр суралцах нь идэвхитэй (асуултаар удирдуулсан), бодит (төслүүдээр дамжуулан) бөгөөд Суралцагчдын сонирхолд тулгуурладаг.

Өргөдөл гаргах хугацаа нь шилжин ирэх өргөдөл гаргах үйл явцтай адил цагт байна.

Ажил Мэргэжлийн Хөтөлбөрийн тухай нэмэлт мэдээллийг 73-р хуудаснаас үзнэ үү.

**Олон Улсын
Бакалаврын
Хөтөлбөр**

Олон улсын бакалаврын хөтөлбөр нь голдуу ОУБ хөтөлбөр гэж нэрлэгддэг бөгөөд Вашингтон-Либерти ахлах сургуулийн өндөр сурах эрмэлзэлтэй коллежид бэлтгэгдэж буй 11, 12-р ангийн сурагчдад зориулсан олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр юм. Арлингтоны аль ч сурагч сургуулийн системийн бодлого, үйл явцыг дагаж хөтөлбөрт хамрагдах боломжтой. Энэхүү хөтөлбөр нь сурах өндөр сэдэлтэй сурагчдад эрчимжүүлсэн, бүтэцтэй Хичээлийг өгдөг. ОУБ хөтөлбөр нь сурагчдын оюун ухаан, үзэл бодол, нийгмийн хөгжлийг анхаарсан цогц сургалтын агуулдаг.

ОУБ хөтөлбөр нь олон салбарыг хамарсан хоёр жилийн хөтөлбөр юм. Хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдэд 6 ялгаатай салбарын академик Хичээлийг амжилттай дүүргэх, чиглэл тус бүрээр хөндлөнгийн шалгалт өгөх, CAS (бүтээлч байдал, үйл ажиллагаа, үйлчилгээ) -д хамрагдах, Мэдлэгийн Онолын Тусгай ангид элсэх, сурагч өөрийн сонирхсон чиглэлээр бие даасан судалгааны ажил бичин илгээх зэрэг багтана Сурагч ОУБ-ийн бүрэн хэмжээний диплом авахгүйгээр ОУБ-ийн тодорхой хичээлүүдийг үзэж болно. Гүнзгийрүүлсэн Сургалтын Диплом авахад тавигдах шаардлагыг 7-8-р хуудаснаас үзнэ үү. Энэхүү хөтөлбөрийн талаар илүү их мэдээлэл авахыг хүсвэл гэр бүлүүд ОУБ програмын албатай 703-228-6234 утсаар холбогдоорой.

Шинэ Чиглэл Ахлах Сургуулийн Хөтөлбөр

"Шинэ Чиглэл" ахлах сургуулийн хөтөлбөр нь 14 болон дээш насны шүүхэд холбогдсон эрсдэлтэй сурагчдад найрсаг орчинд академик болон мэргэжлийн боломжоор хангаж өгдөг. Хөтөлбөр нь сурагчдад төгсөхөд шаардагдах ахлах сургуулийн кредитийг олж авах боломжийг олгодог тодорхой бүтэцтэй, дэмжлэг сайтай академик хөтөлбөр юм. Хөтөлбөрийн удирдлага, ажилтнууд гэр бүлүүдтэй амжилтанд хүрэхийн тулд хамтран ажиллах болон сурагчдад ахиц дэвшил гаргах, нийгмийн хувь нэмэр оруулагч болох боломжийг олгохуйц академик, зан үйл, гэр бүлийн дэмжлэгийг үзүүлэхэд бэлэн байдаг. Ажилтнууд амжилтанд хүрэх боломжийг нэмэгдүүлэхийн тулд бүх оролцогч талуудтай нягт хамтран ажилладаг.

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ СУДЛАХ СОНГОЛТУУД

Виртуал Хичээлүүд

2013-14 оны хичээлийн жилээс эхлэн 9-р ангид элсэн орж буй сурагчид Виржиниа Мужийн Хуулийн дагуу нэг виртуал хичээлийг амжилттай үзэх ёстой. Хичээл нь кредит өгөхгүй хичээл байж болох бөгөөд үүнд Нүүр Будалт, Бие Бялдар Хүчирхэгжүүлэх хичээлүүд багтана.

Сурагчид сургуулиас гадуурх этгээдийн хичээлд хамрагдах боломжтой. Сурагчид сургуулийнхаа зөвлөхтэй ярихгүйгээр ямар ч сургалтанд хамрагдах ёсгүй гэдгийг анхаарах нь чухал. Дүрэм I-7.2.8 Хичээл Явуулах Сонголтууд нь дараах зүйлсийг заана:

Виртуал Хичээлийг Сонгох Шалгуур

Төгсөлтийн шаардлагыг хангахад ашиглагдсан хичээлүүд эсвэл голч дүнгийн тооцоололд багтах аливаа виртуал хичээл нь дараах шаардлагын аль нэгийг хангасан байна:

1. Арлингтон Улсын Сургуулиудын виртуал орчинд санал болгогддог сургалтын хөтөлбөрт хамрагдсан байх эсвэл
2. Хэрэв Арлингтоны Улсын Сургуулиудаас санал болгоогүй хичээл бол, (эсвэл сурагчийн сурч байгаа сургууль зөвшөөрж баталгаажуулсан шалтгаанаар Арлингтон Улсын Сургуулиудад суралцах боломжгүй бол) хичээл нь
 - a. Сургуулийн Нэгдсэн Холбооны Захирлын томилсон ажилтнаар урьдчилан зөвшөөрөгдсөн байх
 - b. Магадлан итгэмжлэгдсэн байгууллагаас санал болгодог эсвэл Виржиниа мужийн Боловсролын газраас батлагдсан үйлчилгээ үзүүлэгчдэд тавих шалгуурыг хангасан үйлчилгээг үзүүлэгчээс санал болгодог байх
 - c. Виржиниа Мужийн Сургалтын хамааралтай стандарттай нийцсэн байх;
 - d. Бүх сурагчдад хүртээмжтэй, Арлингтоны Улсын Сургуулиудын ижил агуулгатай сургалттай чанар зэргийн хувьд адил түвшнийх байх ба Олон улсын K-12 онлайн сургалтын нийгэмлэг (iNACOL) -д заасны дагуу сургалтын дизайны шилдэг туршлагыг хангасан байх

Хичээлийн сонголтыг сурагч ба эцэг эх/асран хамгаалагч сургуулийн зөвлөхийн хамт ярилцах хэрэгтэй. Сургуулийн зөвлөхүүд сургуулийн Зөвлөлийн Дүрмийн I-7.2.8-д заасны дагуу урьдчилж батлуулах хүсэлтийг сурагчийн өмнөөс илгээх үүрэгтэй.

*Виртуал @ APS-ээр дамжуулж дунд сургуульд байх хугацаанд ахлах сургуулийн кредиттэй хичээлийг амжилттай үзсэн тохиолдолд төгсөлтийн шаардлагыг биелүүлэхэд ашиглаж болно. Дэлгэрэнгүй мэдээллийг зөвлөхөөсөө авна уу.

Хичээлийн тодорхойлолтыг энэ баримтны зохих агуулгын хэсгээс үзнэ үү.

Виртуал @ APS-тай холбоотой нэмэлт мэдээллийг <https://www.apsva.us/virtual-instruction/> хаягаар авах боломжтой.

ОНЦГОЙ АВЬЯСТАЙ СУРАГЧДАД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хамтран Ажиллах Загвар нь онцгой авьяастай сурагчдад зориулсан үйл ажиллагааг явуулах загвар юм. Ахлах сургууль бүрт онцгой авьяастай сурагчдад зориулсан орон тооны багш (RTG) ажилладаг. Хамтран Ажиллах Загварын хүрээнд RTG ба бусад багш нар өдөр бүрийн үйл ажиллагааг өвөрмөц болгон дараах аргуудыг ашиглан ажилладаг: онцгой авьяастай суралцагчдад зориулж бэлдсэн хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх; Бүтээлч, Олон Талыг бодох Загварын дагуу тодорхойлсон аргуудыг хичээлд болон сурлагын үйл ажиллагаанд тогтмол, сурагчдын нөөц бололцоог гарган, хүндрүүлэн, эрчимжүүлэх; урьдчилсан үнэлгээ гаргах, сургалтын хөтөлбөрийг шахах, уян хатнаар хуваарилах, сурагчдын саналыг сонсох, сонголт олгох, хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн даалгавар оруулах, асуудал ба төсөлд суурилсан сургалт, хувь хүнд тааруулан сургах, бие даан суралцах болон/эсвэл судалгааны төслүүдийг ашигласнаар хичээлийг тохируулах.

Агуулгын ялгаатай байдлыг ахлах сургуульд хичээл сонголтоор тохируулна. Академикийн эсвэл урлагийн чиглэлээр онцгой авьяастай гэж тодорхойлогдсон ахлах ангийн сурагчдад тодорхой нэг ахлах сургуульд ОУБ хөтөлбөр, нийт ахлах, дунд боловсролын дөрвөн сургуульд санал болгодог коллежийн хөтөлбөр (AP) зэрэг олон дэвшилтэт/эрчимжүүлсэн сургалтуудыг санал болгодог. Мөн сурагчид бие даан коллежийн хичээл хичээл болон/эсвэл хос элсэлтэнд хамрагдан кредит авж болно. Сурагчид мөн Ажил Мэргэжлийн төвийн дэвшилтэт техникийн сургалтанд хамрагдаж болно. Арлингтоны Улсын Сургууль нь онцгой авьяастай хэмээн тооцогдох сурагчдад Засаг Даргын сургууль (Томас Жефферсоны нэрэмжит Шинжлэх Ухаан, Технологийн Ахлах Сургууль) - д хичээлийн нэг жил сурах бүрэн санхүүжилтийг олгодог.

Онцгой Авьяастай Сурагчдыг Дэмжих Багш (RTG) нь онцгой авьяастай сурагчдыг дэмжих хөтөлбөрт өмнө нь тодорхойлогдоогүй байсан, өөрсдийн чадварт тохиромжгүй ангиудад хамрагдаж байсан сурагчдад зориулсан нийгмийн, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх мэргэжлийн семинар зохион байгуулах, зааварчилгаа өгөх замаар сурагчдыг дэмжиж болно. Онцгой Авьяастай Сурагчдыг Дэмжих Багш нь Засаг Даргын Сургуулийн Зуны Хөтөлбөр, PRIME болон сурагчдын сонирхлыг дэмжих бусад баяжуулах хөтөлбөрт хамрагдахаар бүртгүүлэх үйл явцад туслах үүрэгтэй.

Онцгой Авьяастай Сурагчдыг Дэмжих Багш бүр гэр бүлүүдтэй харилцах олон арга хэрэгслийг ашигладаг бөгөөд үүнд эцэг эхчүүдэд зориулсан мэдээлэл өгөх оройн арга хэмжээ, мужийн хэмжээнд зохион байгуулагдах арга хэмжээ, болон Naviance, Canvas, listervs-ээр мөн Твиттер зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан хэрэгцээтэй мэдээлэл болон зарыг түгээх зэргээр сурагчдын гэр бүлд хүрэн ажилладаг.

ЕБС Сурагчдад Нээлттэй Мужийн Хүрээний Хөтөлбөрүүд

Дараах хөтөлбөрүүд нь академ болон урлагийн чиглэлээр онцгой авьяастай хэмээн тодорхойлогдсон сурагчдад зориулсан хөтөлбөрүүд юм. Эдгээр хөтөлбөрүүд нь сургуулийн үйл ажиллагааг өргөжүүлэх болон сурагчдад өөрсдийн сонирхолд тохирсон зүйлийг олоход тус болох зорилготой юм. Нийт дараах боломжууд багтана:

Академик:

- Ажил Мэргэжлийн төвийн хичээлүүд (4–12-р анги)
- Томас Жефферсоны Нэрэмжит Шинжлэх Ухаан ба Технологийн Ахлах Сургууль (9–12-р анги)
- Бие даан гүйцэтгэсэн судалгааг сонгон судлах хичээлийн кредитэд дүйцүүлэх (10–12-р анги)
- P.R.I.M.E (Мэргэжлийн Холбоотой Дадалаг/Дагалдан) (11 ба 12-р ангид орох сурагчдад)
- Засаг Даргын Сургуулийн Зуны Академик/Дагалдан Хөтөлбөр (11 ба 12-р ангид орох сурагчдад)
- Засаг Даргын Сургуулийн Зуны Гадаад Хэлний Академик Хөтөлбөр (11 ба 12-р ангид орох сурагчдад)
- Сургуулийн Нэгдсэн Холбооны Захирлын Зуны Семинар (11 ба 12-р ангид орох сурагчдад)

Урлаг:

- Дүрслэх Урлагийн Дагалдан Хөтөлбөр (10-12-р анги-р анги)
- Бие даан гүйцэтгэсэн судалгааг сонгон судлах хичээлийн кредитэд дүйцүүлэх (10–12-р анги)
- Засаг Даргын Сургуулийн Зуны Дүрслэх ба Жүжиглэх урлагийн сургууль (11 ба 12-р ангид орох сурагчдад)
- Сургуулийн Нэгдсэн Холбооны Захирлын Зуны Семинар (11 ба 12-р ангид орох сурагчдад)
- Reflections (1-12-р анги), Scholastic Arts Awards (9-12-р анги), эсвэл XII Дүүргийн Соло/Ансамбль (7-12-р анги) зэрэг орон нутгийн, мужийн, үндэсний тэмцээнд (1-12-р анги) оролцох

**АРЛИНГТОНЫ НИЙГЭМЛЭГ*, ВЭЙКФИЛД,
ВАШИНГТОН-ЛИБЕРТИ, ИОРКТАУН-д
санал болгож буй сургалтууд.**

*Арлингтон нийгэмлэг нь сурагчдын хэрэгцээнээс хамаарч эдгээр хичээлийн хэсгийг мөн санал болгодог. Хуваарь төлөвлөлтийг сургуулийн зөвлөхтэй хэлэлцэнэ үү.

УРЛАГИЙН БОЛОВСРОЛ ХИЧЭЭЛҮҮД

Ахлах сургуулиудын Урлагийн боловсрол олгох хөтөлбөр нь сурагчдад хөгжим, дүрслэх урлаг, театрын урлагийн чиглэлээр хичээлүүдийг гүнзгийрүүлэн судлах боломжийг олгох зорилготой юм. Урлагийн бүх салбарын хичээлд салбарт ерөнхий анхан шатны, өндөр түвшний, мэргэшсэн сонголтууд байдаг. Сурагчдын бүтээлч үйлдлийг хөгжүүлэхий тулд шаардлагатай техникийн ур чадварын талаар сургалт явуулдаг. Эдгээр хичээлийг үзэн цуглуулсан кредит нь Технологийн/Дүрслэх Урлагт шаардлагатай кредитийг нөхнө.

Жич: 15-аас цөөн Суралцагчтай хичээлийг сурагчдын сонирхол, төсвийн асуудлыг харгалзан үзэж сурагчдад заах боломжгүй. Зарим тохиолдолд төсвийн нэмэлт асуудлыг харгалзан тухайн жилд хичээл явуулахгүй байх шаардлагатай бөгөөд энэ шалтгаанаас үүдэн хичээлд хамрагдаагүй сурагчид өөр хичээл сонгох хэрэгтэй. Мөн элсэлт хангалтгүй Хичээлийг зайнаас болон онлайн сургалтаар санал болгож болно.

Хөгжим

Танхимын Найрал Дуу (29252)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Өмнө нь найрал дуу дуулж байсан туршлага, найрал дууны ахлагчийн шалгалт

Танхимы Найрал Дууны ансамбль нь өндөр ур чадвартай, туршлагатай дуулаачдад зориулагдсан танхимын хөгжмийн түргэвчилсэн Хичээлийг олгодог. Судлах материал нь гүнзгийрүүлсэн хэд хэдэн эрин үе, төрөл жанрыг хамаарна. Дуулах, хөгжмийн онол, нот унших зэрэг чадварыг эрчимтэйгээр бэлдэнэ. Олон тооны сургууль, олон нийтийн болон аялалын тоглолтонд оролцох шаардлагатай.

Концертийн Найрал Дуу(29260)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Энэхүү хичээл нь хөгжим тоглох ур чадвар, зөв дууны өнгө гаргах, ансамбльд дуулах болон нот унших чадвар олгох зорилготой юм. Төрөл бүрийн хэв маяг, цаг үе, алдартай, магтан дуу, чөлөөт гэх мэт өргөн хүрээний хөгжмий судлана. Сурагчид бүх тоглолтонд оролцох шаардлагатай.

Ахисан Шатны Найрал Дуу (29289)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Сургууль эсвэл сургуулиас гадна найрал дуунд урьд өмнө дуулж байсан туршлагатай бол давуу тал болох ч шаардлагагүй. Найрал дууны ахлагчийн шалгалт ба/эсвэл зөвшөөрөл шаардлагатай.

Найрал дууны баг нь магтан дуу болон нийтийн болон бусад олон төрлийн хэв маягийн төлөөлөл болсон дуунуудийг бэлдгээд болон концертод дуулна. Нот унших, дууны өнгө гаргах болон дуулах техник, хөгжмийн анхан шатны олгох сургалт мөн багтана. Тоглолтонд сургуулийн урлагийн тоглолт, олон нийтийн ажиллагаанд зориулсан тоглолтууд, дүүргийн фестивалд болон бусад албан ёсны тоглолтууд багтана. Бүх тоглолтонд оролцох шаардлагатай.

Сопрано Найрал Дуу (29263)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Энэхүү хичээл нь сопрано, альт хоолойнуудад зориулагдсан хөгжим тоглох, дуулах чадварыг хөгжүүлэхэд зориулагдсан болно. Сопрано, альт хоолойтой холбоотой найрал дууны материал судалсан, ансамбльд дуулсан туршлага болон нот уншиж чадах чадвараас үл хамааран бүх сурагчдад нээлттэй. Сопрано хоолойгоор дуулах чадвар, найрал дууны өнгийг хөгжүүлэхэд онцгой анхаарал тавин хөгжүүлнэ. Нийтийн, магтан дуу, чөлөөт гэх мэт ялгаатай цаг үеийн олон төрлийн хөгжмийг судлан үзнэ. Бүх тоглолтонд оролцох шаардлагатай.

Басс Найрал Дуу (29266)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Энэхүү хичээл нь эрэгтэй хүний хоолойд зориулагдсан дуулах ба хөгжим тоглох чадварыг хөгжүүлэхэд зориулагдсан болно. Эрэгтэй хүний найрал дууны материал судалсан туршлага болон судлах чадвар, ансамбльд дуулсан туршлага болон нот унших чадварыг үл харгалзан бүх эрэгтэй сурагчдад нээлттэй. Дуу хоолой өөрчлөх, дуулах дадал, найрал дууны өнгө гаргах чадварыг хөгжүүлэхэд сургалт онцгой анхаарал хандуулах болно. Нийтийн, магтан дуу, чөлөөт гэх мэт ялгаатай цаг үеийн олон төрлийн хөгжмийг судлан үзнэ. Бүх тоглолтонд оролцох шаардлагатай.

Дунд Шатны Найрал Хөгжим (29233)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Найрал хөгжмийн ахлагчийн шалгалт эсвэл зөвшөөрөл

Дунд Шатны Хөгжмийн Баг анги нь орчин үеийн концертын хамтлагийн үлээвэр болон цохилтот хөгжмийн хамтлагт урьд өмнө тоглож байсан туршлагатай (сургууль ба/эсвэл хувиараа) бүх Суралцагчид нээлттэй. Сургалтанд дунд зэргийн бэрхшээлтэй, янз бүрийн хэв маягийн хөгжмийг ашиглан тоглох үндсэн ур чадварыг хөгжүүлэх хичээл орно. Нот унших, хийгээд хөгжмийн онол талаар мөн суралцана. Марш алхааны багт оролцох болон хамтлагийн ахлагчийн төлөвлөсөн концертууд дээр тоглолт хийх шаардлагатай болно. Сургуулийн эзэмшлийн цөөн тооны хэрэгслийг түрээслэх боломжтой.

Ахисан Шатны Найрал Хөгжим (29234)

1 жил, 1 кредит**Анги/Ангиуд: 9-12**

Элсэхийн өмнөх шаардлага: Өмнө нь хамтлагт тоглож байсан туршлага болон найрал хөгжмийн ахлагчийн шалгалт

Ахисан Шатны Найрал Хөгжим нь нь найрал хөгжмийн ахлагчийн тогтоосон симфони найрал хөгжмийн дунд зэргээс хүнд репертуарын хөгжмийг давтаж бэлтгэл хийдэг. Сургуулийн болон олон нийтийн үйл ажиллагааны тоглолт, концерт, дүүргийн баяр наадам, хамтлагийн аяллууд, хөлбөмбөгийн тэмцээн, парадын өмнөх арга хэмжээнд оролцох шаардлага үүснэ. Марш Алхааны багт хамрагдах нь энэ ангийн зайлшгүй шаардлагатай хэсэг юм. Найрал дууны ахлагчийн заасны дагуу тоглолтуудад болон бусад багийн үйл ажиллагаанд оролцох шаардлагатай.

Марш Алхааны Баг (29254)**Хагас жил, хагас кредит****Анги/Ангиуд: 9-12**

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Вэйкфилд, Йорктаун, Вашингтон-Либерти зэрэгт хичээлийн дараа тогтмол хуваарьт хамрагдахыг шаарддаг. Бэлтгэл болон тоглолтуудад оролцох шаардлагатай.

Сурагчид хөлбөмбөгийн хагас цагийн арга хэмжээ жагсаалд оролцоходоо цэргийн корпус хэлбэрийн алхах техникийг сурна. Нарийвчлалтай хөдөлгөөн, формац, бүжгийн алхам, тоглолт зэргийг хөгжим, шоу урлагт тохируулан заадаг. Марш алхааны багийн туслах ангиудад Бэлтгэлийн Баг, Мажорет, Туг, Өнгөт Харуул, Урт Буу, Торгуудыг баталгаа болгон орж болно. Тоглолтуудад оролцох шаардлагатай.

Ансамбль (29250)**Хагас жил, нэг хагас кредит****Анги/Ангиуд: 9-12**

Элсэхийн өмнөх шаардлага: Ансамблийн баг, оркестр, эсвэл найрал дууны ахлагчийн зөвшөөрөл

Үлээвэр, чавхдаст хөгжим, цохилуур хөгжим, /эсвэл дууны ангийн сурагчдад зориулагдсан жааз ансамбль, трио, дөрвөл, Өвлийн Хамгаалагч гэх мэт тусгай сонирхлын ансамбль сургуулийн цагийн дараа болон оройн бэлтгэлийн тогтмол хуваарьтай байдаг. Тоглолтуудад оролцох шаардлагатай.

Анхан Инструментал Хөгжим (29200)**1 жил, 1 кредит****Анги/Ангиуд: 9-12**

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Энэхүү хичээл нь оркестрын хөгжмийн зэмсэг (чавхдаст, гуулин, модон, үлээвэр хөгжим, цохилтот, даралтат) дээр урьд өмнө тоглож байгаагүй эсвэл бага зэргийн зааварчилгаа авсан сурагчдад зориулагдсан болно. Хөгжмийн зэмсэг тоглох техникийг анхаарч тоглолтын хүлээлт байхгүй. Хөгжмийн зэмсгийг сонгоходоо баг эсвэл найрал хөгжмийн багштай ярилцах хэрэгтэй. Сургууль эзэмшдэг хязгаарлагдмал тооны хэрэгслийг түрээслэх боломжтой.

Чавхдаст Хөгжмийн Оркестр (29244)**1 жил, 1 кредит****Анги/Ангиуд: 9-12**

Элсэхийн өмнөх шаардлага: Чавхдаст хөгжмийн зэмсэг дээр ажиллаж байсан туршилагатай болон оркестрийн ахлагчийн зөвшөөрөл

Сонгодог болон нийтийн төрөлд утсан, танхим, студи, симфони хөгжмийн янз бүрийн сурах материал ашиглах замаар сурагчдыг техникийн болон хөгжмийн хувьд хөгжүүлнэ. Сургууль, олон нийтийн үйл ажиллагаа, концерт, дүүргийн баяр наадамд олон нийтийн тоглолт хийх шаардлагатай. Оркестрын аялалд хамрагдах шаардлага үүсч болно. Сургуулийн эзэмшлийн цөөн тооны хэрэгслийг түрээслэх боломжтой.

Танхимийн Оркестр (29242)**1 жил, 1 кредит****Анги/Ангиуд: 9-12**

Элсэхийн өмнөх шаардлага: Өмнө нь оркестр-д тоглож байсан туршлага эсвэл багшийн зөвшөөрөл

Танхимийн Оркестр нь өндөр ур чадвартай, мэргэжлийн түвшний хөгжимчдөд түргэвчилсэн оркестрийн Хичээлийг олгодог. Судлах материал нь хөгжмийн зохиолчдийн эх хувилбараар бичигдсэн ялгаатай эрин үе, төрөл зүйлийг хамарсан гүнзгий түвшинд байна. Инструментал хөгжмийн дэвшилтэт техник, ансамблийн тоглолт, нот унших зэрэг өргөн хүрээний Хичээлийг давтлагад агуулгын онол, түүхэн мэдээллийн хамт оруулна. Олон тооны сургууль, олон нийтийн болон аялалын тоглолтод оролцох шаардлагатай.

Гитар хөгжим I (29245)**1 жил, 1 кредит****Анги/Ангиуд: 9-12**

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Энэхүү хичээл нь анхан болон дунд шатны түвшинд гитар тоглодог сурагчдад зориулагдсан болно. Ном, хэвлэмэл нотын хуудас, гитарын ансамбль хөгжмөөр дамжуулан техникийн хэв маяг ба хөгжмийн зохиол ашиглан төрөл бүрийн дамжуулан нот унших, ая ба утасны бүтцийг заахад хэрэглэнэ. Сургуулийн эзэмшлийн цөөн тооны хэрэгслийг түрээслэх боломжтой. Энэ дамжаанд суралцаж буй сурагчид багшийн зөвшөөрсний дагуу Гитарын Ансамбльд хамрагдах боломжтой.

Гитар хөгжим II (29247)**1 жил, 1 кредит****Анги/Ангиуд: 9-12**

Элсэхийн өмнөх шаардлага: Гитар I эсвэл багшийн зөвшөөрөл

Энэхүү хичээл нь гитарийг ахисан түвшинд эзэмшсэн сурагчдад зориулагдсан болно. Ном, хэвлэмэл нотын хуудас, гитарын ансамбль хөгжмөөр дамжуулан техникийн хэв маяг ба хөгжмийн зохиол ашиглан төрөл бүрийн дамжуулан нот унших, ая ба утасны бүтэц, хөгжмийн зохиолуудыг заахад хэрэглэнэ. Тоглолт болон ансамблийн бусад ажилд оролцохыг ахлагч, захирлын заасны дагуу шаардаж болно.

Дуу Бичлэг, Дижитал Аудио, Хөгжмийн Онол (29225)**1 жил, 1 кредит**

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Дуулах болон инструментал хөгжмийн мэдлэг

Дуу Бичлэг, Дижитал Аудио, Хөгжмийн Онол хөгжмийн бүтцийг электрон болон акустик орчинд судлах зорилготой сургалт юм. Сургалтад сурагчдын сонголын ур чадварыг хөгжүүлэхээс гадна онол, Суралцагчийн бүтээлч чадварыг хөгжмийн зохиол бичихэд хөгжүүлэх болон хөгжмийн онолыг хэрэглээнд шилжүүлэхэд анхаардаг. Сурагчид дижитал аудиог найруулах, өөрчлөх үйлдлээр дамжуулан дуу, хөгжмийн зохиолын талаар судлах болно. Сурагчид хөгжмийн үйлдвэрлэлийн үндэс суурийг сурах болно; зохих бичлэг хийх арга техник болон мөн дижитал аудио ажлын станц, найруулга, тэмдэглэгээний програм хангамжийг ашиглан төрөл бүрийн жанр, нөхцөлд хөгжим гаргахад суралцана

Хөгжмийн Онол, АР (39226)

1 жил, 1 кредит + 1.0 чанарын оноо

Анги/Ангиуд: 10-12-р анги

Элсэхийн өмнөх шаардлага: Төгөлдөр хуур, мөн дуулах болон инструментал хөгжмийн гүнзгий мэдлэг

АР Хөгжмийн Онол хичээл нь коллежийн түвшний хөгжмийн онолын ангитай адил хурд болон түвшинд ордог. Сургалт нь сурагчдын хөгжмийг зохиолд тэмдэглэгдсэн хөгжмийн үйл явц болон үндсэн материалыг таних, ойлгох, дүрслэх чадварыг хөгжүүлдэг. Сургалтын хөтөлбөр нь дүн шинжилгээ хийх, хөгжим зохиох ур чадвараас гадна чихний дасгал, нот уншин дуулах зэрэг олон төрлийн мэдлэгийг агуулдаг. Сургалтанд тохирох хөгийг аялгуунд уялдуулах, хоёр хоолойтой эсрэг цэгт хүргэх хөгжмийн басс нот бичих, эсвэл басс-тэмдэглэлийг хэрэгжүүлэх зэрэг бүтээлч сэтгэлгээ шаардсан даалгаврууд орно. Энэхүү хичээл нь сурагчдыг АР Хөгжмийн Онолын шалгалтанд бэлтгэх болно. АР Хөгжмийн Онолыг сонгосон сурагчид оны төгсгөлд АР шалгалт өгөх ёстой. Шалгалтанд хамрагдахгүй сурагчид нэмэлт чанарын оноо авахгүй (29226).

Инструментал Жазз Лаборатори/Ансамбль (29251)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Сурагчдыг симфони эсвэл концертын багаас сонгон шалгаруулалтаар элсүүлнэ

Инструментал Жазз Лаборатори/Ансамбль нь студийн ансамблийн орчинд ахисан шатны жазз тоглолт хийх чадвар олгоно. Жазз болон поп хэмнэлийн ансамблийн дуу, хоршил, хөгжим, стилист талыг онцлон үзэх болно. Ганцаарчилсан уран бүтээл хийх, чээжээр тоглох, орон нутгийн жазз уран бүтээлчидтэй үе үе тоглолт хийх боломжийг олгоно. Олон тооны сургууль, нийтээр хамрагдах болон аялалын тоглолтын ажилд оролцох шаардлагатай.

Жазз/Поп Дууны Лаборатори/Ансамбль (29280)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Өмнө нь найрал дууны багт оролцсон туршилагатай, сургууль даяар зохион байгуулагдах найрал дууны ахлагчийн сонгон шалгаруулалтад оролцох

Жазз/Поп Дууны Лаборатори/Ансамбль нь студийн

орчинд ахисан шатны жазз/поп чиглэлээр бодит чадвар олгодог. Ансамбль дуу, хоршуулалт, хөгжим, жазз ба поп хэмнэлийн хэв маягийн талыг онцлон судлана. Ганцаарчилсан уран бүтээл хийх, чээжээр тоглох, орон нутгийн жазз уран бүтээлчидтэй үе үе тоглолт хийх боломжийг олгоно. Олон тооны сургууль, нийтээр хамрагдах ажиллагаа болон аялалын тоглолтын ажилд оролцох шаардлагатай.

Дүрслэх Урлагийн Хичээлүүд

Урлаг I (29120)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Дизайн ба бүтээлчээр асуудлыг шийдвэрлэх ур чадварын урлагийн зарчмыг ашиглан сурагчид зурах техникийн дараалал, уран зураг, график, ба 3 хэмжээст урлагийн хэлбэрүүдийг судалж үздэг. Бүх төслүүд нь сурагч өөрийн ажлын явц болон эцсийн бүтээгдэхүүний талаархи хувийн саналаа оруулан өөрийн урын санд хадгалдаг. Энэхүү сургалт нь Art II, III, Студи, ба АР хичээлийн урьдчилсан нөхцөл юм.

Урлаг II (29130)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 10-12-р анги

Элсэхийн өмнөх шаардлага: Урлаг I буюу дүрслэх урлагийн багшийн зөвшөөрөл

Энэхүү хичээл нь Урлагийн I-ээс сурч мэдсэн ойлголт, арга техник дээр үндэслэсэн болно. Сурагчид хар зураг зурах, уран зураг зурах, хэвлэх, уран баримал хийх АР хөтөлбөрийн арга техникийг эзэмшдэг. Сурагчид үргэлжлүүлэн судалгаа хийн томоохон зураачдын бүтээлийг өөрсдийн бүтээлтэй холбон үздэг.

Урлаг III (29140)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 11-12-р анги

Элсэхийн өмнөх шаардлага: Урлаг II эсвэл Дүрслэх Урлагийн багшийн зөвшөөрөл

Энэхүү хичээл нь студи урлагийг нухацтай судлах хүсэл эрмэлзэлтэй, өндөр урам зоригтой сурагчдад зориулагдсан болно. Сурагчид уран зураг, хар зураг, график, ба уран баримал зэргийг багтаасан ба эдгээрээр хязгаарлагдахгүй бүтээлүүдийг гаргах болно. Ажлын чанар, уран сайхны тодорхой үзэл баримтлал дахь төвлөрөл, үзэл бодлоо илэрхийлэх өргөн цар хүрээ зэргийг онцолж үздэг.

Урлаг, Дизайн, АР (39149)

1 жил, 1 кредит + 1.0 чанарын оноо

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Урлаг III ба/эсвэл багшийн шийдвэр

Урлаг, Дизайны хичээл нь урлагийн гүнзгийрүүлсэн практик чадвар дээр суурилсан бөгөөд сурагчид нэмэлт чанарын оноо авахын тулд бүрэн урын санг бүтээх шаардлагатай. Сургалт нь дараах гурван үндсэн чиглэлийг хамардаг: сурагчийн урлагийн бүтээлийн өндөр чанар; сонирхолд нийцсэн тодорхой дүрслэл эсвэл асуудалд анхаарлаа төвлөрүүлэх; мөн уран зургийн мэргэжлийн, техникийн болон илэрхийлэх арга хэрэгслийг ашиглан урлаг бүтээх туршлагын цар хүрээ. Сурагчид мэргэжлийн болон хийсвэр асуудлыг бүтээлч, системтэй арга барилаар судалж, мэдлэгтэй судлан шинжлэн шийдвэр гаргадаг урлаг бүтээх тогтмол үргэлжилдэг үйл явцыг ойлгох, болон дүрслэх

элементүүдийн функцийн техникийн ур чадварт суралцан танин мэдэх чадвараа хөгжүүлнэ. Сурагчид энэхүү сургалтанд хамрагдахын тулд АР портфолио үзүүлэх шаардлагатай. Бүрэн багцыг ирүүлээгүй сурагчид нэмэлт чанарын оноо авах боломжгүй. (29149)

Урлагийн Түүх, АР (39151)

1 жил, 1 кредит + 1.0 чанарын оноо

Анги/Ангиуд: 10-12-р анги

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Энэ хичээл улс төр, шашин шүтлэг, ивээн тэтгэх, хүйс, функц, үндэс угсаа гэх мэт асуудлуудыг судлах замаар урлагийн бүтээлийн талаархи ойлголтыг түүхэн нөхцөл байдалтай нь холбон сурагчдад түүхийн суурь ойлголтыг өгдөг сургалт юм. Энэ хичээл нь сурагчдад урлагийн бүтээлийг харагдах байдлаар нь дүн шинжилгээ хийхийг заадаг. Энэ сургалтанд архитектур, уран баримал, уран зураг болон бусад урлагийн төрлийг хамааруулан судлах бөгөөд сурагчид дүн шинжилгээ хийхийн тулд эдгээр уран бүтээлийг шүүмжлэлтэй, ухаалаг, мэдрэмжтэй харж сурдаг. Энэ сургалт нь АР урлагийн түүхийн шалгалтыг амжилттай давахад сурагчдыг бэлтгэдэг. Сурагчид энэ хичээлтэй холбоотой АР шалгалт өгөх шаардлагатай. Шалгалтанд хамрагдахгүй байгаа сурагчид нэмэлт чанарын оноо авах боломжгүй болно. (29151)

Шавар Урлал I (29167)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Энэхүү хичээлд 3D шаврын хэлбэрийг хэрэглэнд болон чимэглэлийн хэлбэрээр бүтээх аргыг судлана. Сурагчид гараар бүтээх болон дугуй ашиглан бүтээх төрөл бүрийн арга техникийг ашиглах болно. Энэхүү сургалтанд сурагчид анх удаа шаврыг мэдрэх эсвэл илүү өндөр түвшний сурагчид ур чадвараа хөгжүүлэх боломжийг олгох болно. Сурагчдад янз бүрийн пааландах, өнгөлгөөний техник туршилт хийх чадварыг олгоно. Лабораторийн хураамж 55.00 долларт шавар, пааланг авахад хэрэглэдэг. Төлбөрийг бууруулах мэдээллийг 13-р хуудаснаас үзнэ үү.

Шавар Урлал II (29168)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Шавар Урлал I эсвэл багшийн зөвшөөрөл

Энэхүү хичээл нь 3D шавар хэлбэрийг хэрэглэнд болон чимэглэлийн зорилгод бүтээх аргыг судлана. Энэхүү сургалт нь сурагчдад гар аргаар болон дугуй ашиглах аргаар ур чадвараа дээшлүүлэх боломжийг олгоно. Энэ сургалт нь шаврыг 3D уран бүтээлчдийн урлагт хэрхэн ашиглаж болох боломжуудыг судлах эрэлхийлэх завшааныг сурагчдад олгоно. Сурагчид олон төрлийн пааландах болон өнгөлөх аргуудыг сурах болно. Шавар урлаачдын бүтээл, тэдгээрийн бүтээлийг судлах үйл явц сургалтанд багтана. Лабораторийн хураамж 55.00 долларт шавар, пааланг авахад хэрэглэдэг. Төлбөрийг бууруулах мэдээллийг 13-р хуудаснаас үзнэ үү.

Шавар Урлал III (29169)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 10-12-р анги

Элсэхийн өмнөх шаардлага: Шавар Урлал II эсвэл багшийн зөвшөөрөл

Энэхүү сургалт нь керамик материалыг гүнзгий судлах өндөр хүсэл эрмэлзэлтэй сурагчдад зориулагдсан болно. Сурагчид Шавар Урлал I ба II-д эзэмшсэн ур чадвар дээрээ тулгуурлан, мэдлэг ур чадвараа гүнзгийрүүлэх төвлөрөх болно. Лабораторийн хураамж 55.00 долларт шавар, пааланг авахад хэрэглэдэг. Төлбөрийг бууруулах мэдээллийг 13-р хуудаснаас үзнэ үү.

Гар Урлалын Суурь (29160)

1 улирал, хагас кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Сурагчид Уугуул Америк, Гватемал, Мексик, Ази, Колончлолын үеийн Америк гаралтай янз бүрийн соёл, үзэл бодол, хэв маягийг агуулсан шаазан эдлэл, сүлжмэл эдлэл, үнэт эдлэл, маск гэх мэт урлалыг бүтээж сурна.

Гар Урлал (29162)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Нэг жилийн турш үргэлжлэх энэхүү сургалтанд сурагчид нарийн хийцтэй боловч бодит хэрэглэгдэхүүнтэй гар урлалын баялаг өв уламжлалыг судлах болно. Олон соёлын гар урлалын төлөөлөл болсон бүтээлүүд шавар, эслэг, мод гэх мэт гэрийн даалгавруудыг биелүүлэхэд сурагчдад урам зориг өгөх болно. Гар урлалын хэрэгслүүдтэй ухаалаг, чадварлаг, бүтээлчээр ажиллахад шаардлагатай мэдлэгийг олгох болно. Дизайн ба гоо зүйн элемент болон зарчим, бичгийн ба/эсвэл аман дүн шинжилгээ, гар урлалын бүтээлийн түүхэн өвийг онцлон үзэх болно.

Уран Зураг, Хар Зураг (29163)

1 улирал, хагас кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Сурагч натюрморт, байгаль, биеийн дүрс, уран зөгнөл зэрэг янз бүрийн сэдвийн хүрээнд хар зураг гаргах болон уран зураг зурах үндсэн арга барилд суралцдаг. Шугам, орон зай, өнгөний бараан болон цайвар хэлбэрүүд, бүтэц, өнгөний хэв маягийн харагдах байдал болон зохион байгуулалтыг харуулж сурна. Төрөл бүрийн хэрэгслийг ашигладаг. Эдгээр хэрэгслүүдийг ашигласан томоохон зураачдын бүтээлийг судалж үздэг.

Компьютер График (29152)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Сурагчид асуудлыг бүтээлчээр шийдвэрлэх чадвар ашиглан бодит амьдралд тулгардаг зураг, лого дизайн, бүтээгдэхүүний байршуулалт, түүхийг зурагжуулах, хэвлэлийн эх болон хуудас бэлдэх чадварыг эзэмшинэ. Сурагчид компьютер ашиглан бүтээсэн график ашиглан бүтээлээ урлаж болно.

Компьютер График II (29153)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 10-12-р анги

Элсэхийн өмнөх шаардлага: Компьютер График I

Сурагчид бүтээгдэхүүний дүр төрх, брэнд, бүтээгдэхүүний үзүүлэн, түүх, чимэглэл, хуудас болон хэвлэлийн талбар зохион байгуулалт зэрэг бодит нийгэмд тохиолддог дизайны асуудлуудыг бүтээлч аргаар шийдвэрлэнэ.

Компьютер График III (29154)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 10-12-р анги

Элсэхийн өмнөх шаардлага: Компьютер График I, II

Энэ хичээл бол компьютерын графикийн гүнзгийрүүлсэн курс бөгөөд компьютер график I ба II дээр сурсан дижитал ур чадварыг цаашид өргөжүүлэх болно. Энэхүү сургалт нь сурагчдад дижитал дүрслэх урлаг, бизнэсийн салбарын урлагт төвлөрсөн загвар гаргах ур чадварыг эзэмшүүлдэг. Сурагчид дижитал урлагийн дэвшилтэт техникт суралцаж, дижитал аргаар хувийн бүтээлүүдийг урлах аргад суралцана. Энэхүү сурагчдийн хувийн бүтээлүүд нь 2D дижитал AP бүтээлүүд гаргахаар зорьж буй сурагчдад сайн үндэс суурь тавьж өгнө.

Дижитал Фотограф I (29193)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Сурагчид гэрэл зургийг урлагийн түвшинд ойлгоно. Сурагчид дижитал технологийг ашиглахын тулд нэг линзтэй рефлекс камер ашиглан олон төрлийн аргаар хэвлэж сурна. Сэдвийн хүрээнд гэрэл зургийн түүх, дизайны элемент, зарчмууд, гэрэлтүүлэг, болон камерын функцтэй танилцана. Хэвлэлийн зардалд лабораторийн хураамж \$ 50.00 төлөх шаардлагатай. Төлбөрийг бууруулах/төлбөрөөс чөлөөлөх тухай мэдээллийг 13-р хуудаснаас үзнэ үү. Сурагчдаас боломжтой бол өөрсдийн камераа ашиглахыг хүсч байгаа бөгөөд сурагчид хувийн зүгээс гэрэл зургийн цаас бэлдэх шаардлагатай. Хязгаарлагдмал тооны камерыг хэрэгцээнд ашиглах боломжтой. Камер алдагдах, хулгайд алга болох эсвэл ихээхэн эвдэрсэн бол сурагчид хариуцна.

Дижитал Фотограф II (29194)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 10-12-р анги

Элсэхийн өмнөх шаардлага: Дижитал Фотограф I эсвэл гэрэл зургийн багшийн зөвшөөрөл

Энэхүү дэвшилтэт сургалтанд Дижитал Фотограф I хичээлд сурсан үндсэн ойлголт ба техникийг дэлгэрүүлсэн хэд хэдэн төрлийн гэрэл зургийн асуудлыг уран сайхны аргаар болон илэрхийллийн техник онцлон судалдаг. Хичээлд хамааралтай асуудлуудыг судлахдаа гэрэл зургийн томоохон уран бүтээлчдийн бүтээлийг судалдаг. **Хэвлэлийн зардалд лабораторийн хураамж \$ 50.00 төлөх шаардлагатай. Төлбөрийг бууруулах/төлбөрөөс чөлөөлөх тухай мэдээллийг 13-р хуудаснаас үзнэ үү. Сурагчдаас боломжтой бол өөрсдийн камераа ашиглахыг хүсч байгаа бөгөөд сурагчид хувийн зүгээс гэрэл зургийн цаас бэлдэх шаардлагатай. Хязгаарлагдмал тооны камерыг хэрэгцээнд ашиглах боломжтой. Камер алдагдах, хулгайд алга болох эсвэл ихээхэн эвдэрсэн бол сурагчид хариуцна.**

Дижитал гэрэл зураг III (29195) (98610W)

1 жил, 1 кредит, +1 чанарын оноо

Анги/Ангиуд: 11-12-р анги

Элсэхийн өмнөх шаардлага: Дижитал Гэрэл Зураг I, II

Тус хичээл нь зураг авах туйлын хүсэлтэй суралцагч залууст зориулсан гэрэл зургийн ахисан шатны хичээл юм. Суралцагчид мэргэжлийн гэрэл зургийн хийх, хичээлийн I, II түвшинд сурсан гэрэл зурагт сурсан ур чадвараа дээшлүүлэхийн тулд нэг жилийг зарцуулах болно. Хэвлэлийн зардалд лабораторийн хураамж \$50.00 төлөх хэрэгтэй. Төлбөрийг бууруулах/чөлөөлөх талаархи мэдээллийг 13-р хуудаснаас уншина уу. Суралцагчдаас боломжтой бол камераа өөрсдөө авчрахыг хүсэх боломж, өөрсдөө гэрэл зургийн хэвлэхэд шаардлагатай чухал бэлтгэсэн байх ёстой. Фото камерын тоо хязгаартай байдаг. Алга болгосон, хулгайд алдсан эсвэл эвдэрсэн камерыг ашигласан суралцагчид өөрсдөө хариуцна.

- **Коллежийн кредит:** Энэ хичээлийг Хойд Виржиниа мужийн олон нийтийн коллежид Хос элсэлт авах боломжтой. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх хэрэгтэй. Илүү дэлгэрэнгүйг сургуулийнхаа зөвлөхөөс лавлана уу.

Уран баримлын үндэс хичээл (29165)

1 улирал, хагас кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй..

Энэхүү анги нь гурван хэмжээст урлаг сонирхдог суралцагчдад зориулсан хөтөлбөр юм. Суралцагчид уран баримал бүтээх үндсэн зарчмуудыг сурч, материал, багаж хэрэгсэл, аюулгүй ажиллагааны журмын талаар суурь мэдлэгтэй болж төгсөнө. Суралцагчид хэд хэдэн баримал барьж, шавар, гипсэнд ашигладаг төрөл бүрийн арга техникийг сурах юм. Мөн уран баримлын түүхэн ач холбогдлыг судлана.

Уран баримал (29166)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Уран баримлын үндэс, Гар урлал хийх үндэс хичээлийг судалсан эсвэл дүрслэх урлагийн багшийн зөвшөөрөлтэй байх шаардлагатай. шаардлагатай.

Энэхүү хичээл нь шавар, гипс, мод, утас гэх мэт төрөл бүрийн материал, техник хэрэгсэлээр өөрийгөө илэрхийлэх уран баримлын зүйлийг бүтээх сонирхолтой суралцагчдад зориулагдсан хөтөлбөр болно. Сэдвийн асуудалд бодитой, хийсвэр, бодит бус тайлбарлах замаар ханддаг. Орчин үеийн уран барималчдын үлгэр жишээг мөн судална.

Театрын урлаг

Театрын урлаг I (21400)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Энэхүү хичээл нь жүжиг, театрын төрөл бүрийн салбарыг харилцаа холбооны хэрэгсэл болгон судлах хүсэлтэй суралцагч залууст зориулагдсан жүжиг, театрын техник технологийн үндэсийг зааж сургана. Оролцогчид пантомимо, импровизаци, үзэгдэл судлал

зэргээр жүжиглэх үндсэн арга техникт суралцана. Дуу хоолойг сайжруулах, асуудал шийдвэрлэх чадвар, тоглох унших, жүжиглэх авьяас чадварыг багаар ажиллаж дадлагажуулдаг. Театрын түүх, театрын үйлдвэрлэлийн техникийн тал, драмын бүтцийн шинжилгээ, нэг жүжигчилсэн жүжгийн дизайн, найруулгыг судлах үйл ажиллагаа орно.

Театрын урлаг II (21415)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 10-12-р анги

Элсэхийн өмнөх шаардлага: Театр Урлагийн I эсвэл Театрын Урлагийн Багшийн зөвшөөрөл

Энэхүү хичээл нь театрын урлагт олж авсан драмын техник, жүжиглэх ур чадварыг үргэлжлүүлэн судлах зорилготой. Дүрийн хөгжил, нүүр хувиргалт, хувцаслалт, жүжиглэх онол, тайзны техникт анхаарлаа хандуулна. Суралцагчид төрөл бүрийн үзэгчдэд зориулж шоу, жүжиг тоглуулж, тайзнаа тавьдаг. Театрын түүхийг мөн үргэлжлүүлэн судална. Эдгээрийг дуусгахын тулд ангиас гадуурх бэлтгэл хийх шаардлагатай юм.

Театрын урлаг III (21425)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 11-12-р анги

Элсэхийн өмнөх шаардлага: Театрын урлага II эсвэл Театр Урлагийн багшийн зөвшөөрөлтэй байх шаардлагатай.

Энэхүү хичээл нь театрын урлагийн бүтээлд идэвхтэй оролцохыг шаарддаг драмын урлагийн семинар хичээл билээ. Суралцагчид кино драм, продакшны чиглэлээр суралцаж, кино урлагийн бүтээлийн чиглэлээр ажиллаж байхдаа продакшны гишүүдийн хувьд туршлага судалж, бүрэн хэмжээний бүтээл хийх боломж бүрдэнэ. Суралцагч бүр анги үйлдвэрлэлийн ажилтай холбоотой хоёр нарийвчилсан төсөл, түүний дотор дор хаяж гурван ангиллын хоёроос доошгүй хэсэгт оролцох даалгаврыг гүйцэтгэх шаардлагатай: (1)гүйцэтгэл; 2) хэл найруулга, менежмент, түүх, судалгаа; эсвэл (3) дизайн/гэрэл, хувцас, иж бүрдэл, таяг багтана. Театрын түүхийг судлах ажил үргэлжилж байна. Эдгээр үйл ажиллагааг дуусгахын тулд ангиас гадуурх бэлтгэл хийх шаардлагатай болно.

АР хөтөлбөрийн театр урлаг IV (21430)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 11-12-р анги

Элсэхийн өмнөх шаардлага: Театр урлаг III судалсан эсвэл театр урлагийн багшийн зөвшөөрөлтэй байх шаардлагатай.

Театрын урлаг IV-т суралцагчид хэд хэдэн театрын арга хэмжээнүүдийн бүхий л үйлдвэрлэлийн явцыг төсөөлж, хянана. Театрын урлаг IV ангийн суралцагчид жүжиг, шоу найруулах, гаргах, удирдах замаар урьд сурч мэдсэн бүх техникийн элементүүд, жүжиглэх, найруулах арга техник, бүлгүүдийн динамик ур чадварыг нэгтгэж, хэрэгжүүлдэг. Эдгээр үйл ажиллагааг дуусгахын тулд ангиас гадуурх бэлтгэл хийх шаардлагатай болно.

Техникийн театр (21435)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Театр Урлагийн I эсвэл Театрын Урлагийн Багшийн зөвшөөрөлтэй байх шаардлагатай.

Суралцагчид улирал бүр олон төрлийн театрын арга хэмжээнд техникийн дэмжлэг үзүүлэх ажилд идэвхитэй хамрагдсанаар гэрэлтүүлгийн үндсэн элементүүд, барилгын хийц, хувцас, нүүр будалт, таяг зэргийг сурдаг. Суралцагч бүр гэрэлтүүлэг, иж бүрдэл, костюм, нүүр будалт, таяг гэх мэт үйлдвэрлэлийн хэрэгцээтэй холбоотой хоёр нарийвчилсан төслийг хэрэгжүүлэх шаардлагатай. Хичээлийн дараа зарим нь оролцох шаардлага үүсч болно.

Онцгойлон анхаарах зүйлс

Бакалаврын түвшинд театр урлагт суралцах сонирхолтой суралцагчдад сургалтын дарааллыг баримтлахыг зөвлөж байна (өөрөөр хэлбэл Урлаг I, II, III, AP; Театр урлаг I, II, III, IV). Багшийн зөвшөөрлөөр суралцагчид AP Визил урлаг хичээлд хамрагдах боломжтой, хоёр жилийн хугацаанд урлаг III, ахлах ангид AP урлагийн хичээлд элсэх замаар суралцаж болно. Сургуулиа төгсөөд хөгжмийн чиглэлээр үргэлжлүүлэн суралцах сонирхолтой суралцагчдад Хөгжмийн онолын хичээлд хамрагдахыг ихэд зөвлөж байна.

Дагалдагч, Дүрслэх урлаг

Бүтэн жил, хагас кредит

Дүрслэх урлаг I (29290), Анги/Ангиуд: 10-11

Дүрслэх урлаг II (29291), Анги/Ангиуд: 11-12-р анги

Элсэхийн өмнөх шаардлага: Дүрслэх урлаг I эсвэл багшийн зөвшөөрөлтэй байх шаардлагатай.

Дүрслэх урлаг III (29292), Анги/Ангиуд: 12

Элсэхийн өмнөх шаардлага: Дүрслэх урлаг II эсвэл Багшийн зөвшөөрөлтэй байх шаардлагатай.

Урлагийн боловсролын ал, нь онцгой авьяаслаг, дүрслэх урлаг, хөгжим, театр эсвэл бүжгийн чиглэлээр тууштай хичээллэдэг 10-12-р ангийн сурагчдад зориулсан Дагалдангийн хөтөлбөрийг оруулдаг. Энэ нь тодорхой суралцагчдад зориулж ганцаарчилсан болон жижиг бүлгүүдийн урлагийн туршлагыг зохион байгуулна. Суралцагчийг хавар бичгээр өргөдөл, ярилцлага, сонсгол/портфолио сонгон шалгаруулна. Гоц авьяаслаг сурагчдын өргөдлийг ахлах сургуулийн урлаг, хөгжмийн ажилтнууд, зөвлөхүүд, хүний нөөц хариуцсан багш нараар дамжуулан авн

МЭРГЭЖЛИЙН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ

Ажил мэргэжлийн болон техникийн боловсролын давтлага хичээл нь суралцагчдад дээд боловсрол эзэмших эсвэл ажилд орох анхан шатны бэлтгэлээ хийх явцдаа олон мэргэжлийн техникийн хэрэглээнд суралцахад нь тусална. Ажил мэргэжлийн болон техникийн боловсрол (СТЕ) хичээлийг Бизнес, мэдээллийн технологи, Компьютерийн шинжлэх ухаан, Гэр бүл, хэрэглэгчийн шинжлэх ухаан, Маркетинг, худалдаа, үйлдвэрлэлийн боловсрол, Технологийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд бүрэн дунд сургуулиудад явуулна. Эдгээр чиглэлээр СТЕ хичээлийг Уэйкфилд, Вашингтон-Либерти, Йорктаун, Арлингтон хотын Мэргэжил боловсролын төв/Арлингтонын Технологи(Тек/Tech) болон бусад СТЕ сургалтад суурилсан хөтөлбөрүүдийн хүрээнд явуулна. Сургуулийн хаяг, байршил, хичээлүүдийн талаарх мэдээллийн Хос элсэлтийн зөвлөх тусламж хэсгээс үзнэ үү.

Ажил мэргэжлийн болон техникийн давтлага хичээл тус бүр нь Стандарт гэрчилгээний төгсөлтийн шаардлагад шаардагдах ажил мэргэжлийн болон техникийн үнэмлэх авах боломжийг олгоно. Сургалтын зөвлөхөөсөө Дэлгэрэнгүй мэдээллийг тодруулна уу.

Уэйкфилд, Вашингтон-Либерти, Йорктаун ахлах сургууль, Арлингтон дахь Ажил мэргэжлийн төвийн Хичээл сонголтын дараалал			
Стандарт гэрчилгээний төгсөлтийн шаардлагад дор хаяг хоёр дараалсан сонгон хичээлтэй. СТЕ-д энэ шаардлагыг дор жагсаасан сонголтуудын аль нэгийг ашиглан хийж болно. Илүү дэлгэрэнгүйг зөвлөхөөсөө тодруулна уу.			
I. Бизнес, харилцаа холбоо			
Урлаг, A/V технологи, харилцаа холбоо	Хичээл сонголтын дараалал 1: Мэдээллийн технологийн танилцуулга (26116) болон Компьютерийн мэдээллийн систем (26614)	Хичээл сонголтын дараалал 2: Мэдээллийн технологийн танилцуулга (26116) болон Вэб хуудасны дизайн мультимедиа (26646)	Хичээл сонголтын дараалал Sequence Option Хичээл сонголтын дараалал 3:
Бизнес, Удирдлага, Захиргаа	Хичээл сонголтын дараалал 1: QuickBooks-тай нягтлан бодох бүртгэл (26320) Компьютерийн мэдээллийн систем (26614)	Хичээл сонголтын дараалал 2: Бизнес, маркетингийн танилцуулга (26112), ОУБ бизнесийн менежмент (36114)	Хичээл сонголтын дараалал 3: Мэдээллийн технологийн удиртгал (26116) & ОУБ Олон улсын нийгмийн мэдээллийн технологи (36613)
Мэдээллийн технологи	Хичээл сонголтын дараалал 1: Мэдээллийн технологийн танилцуулга (26116) Вэб хуудасны дизайн, мультимедиа (26646)	Хичээл сонголтын дараалал 2: Мэдээллийн технологийн танилцуулга (26116) болон Мэдээллийн сангийн дизайн, менежмент DE (96660W)	Хичээл сонголтын дараалал 3: Цахим хуудасны дизайн, мультимедиа DE (96646W); Мэдээллийн сангийн дизайн, менежмент
Компьютерийн шинжлэх ухаан	Хичээл сонголтын дараалал 1: Компьютерийн шинжлэх ухаан (26639) болон Компьютерийн програмчлал, дэвшилтэт (26643)	Хичээл сонголтын дараалал 2: Компьютерийн шинжлэх ухааны зарчим, AP (33186) болон Компьютерийн шинжлэх ухаан хэсэг, AP (33185) эсвэл ОУБ Компьютерийн шинжлэх ухаан хэсэг I (36560) болон Part II (36570)	Хичээл сонголтын дараалал 3: Компьютер програмчлал, DE (96638W), Компьютер програмчлал, Эрчимжүүлсэн сургалт (96644W) Компьютер програмчлал, ACC-гийн Ахисан түвшин DE (96643W)
Маркетинг	Хичээл сонголтын дараалал 1: Бизнес эрхлэлт (99094W) DE болон Бизнес эрхлэлт, Дэвшилтэт (99095), DE	Хичээл сонголтын дараалал 2: Спорт, үзвэр үйлчилгээ, амралт (28123) болон Бизнес, маркетингийн танилцуулга (26112)	Хичээл сонголтын дараалал 3: Загварын ертөнцийн удиртгал (28147) & Бизнес эрхлэлт (99094W) DE
II. Аж үйлдвэр, инженерчлэл			
Шинжлэх ухаан, технологи, инженер математик	Хичээл сонголтын дараалал 1: Инженерийн I: Инженерийн дизайны танилцуулга (28491) болон Инженерийн II: Инженерийн зарчим (28492)	Хичээл сонголтын дараалал 2: Инженерийн I: Инженерийн дизайны танилцуулга (28491) болон Инженерийн II: Инженерийн зарчим (28492) Инженерийн Capstone: Дизайн, хөгжил (28494)	Хичээл сонголтын дараалал 3: Компьютерт суурилсан Техникийн ажлын зураг (98439W) DE, Компьютерт суурилсан Архитектурын ажлын зураг (98408W) DE
Шинжлэх ухаан, технологи, инженер математик	Хичээл сонголтын дараалал 4: Компьютерийн дэмжлэгтэйгээр техникийн зураг (28439) (98439W) болон Компьютерийн дэмжлэгтэйгээр инженерийн зураг бүтээх (28438)		
III. Эрүүл мэнд, хүний үйлчилгээ			
Хөдөө аж ахуй, хүнс, байгалийн нөөц	Хичээл сонголтын дараалал 1: Хоол хүнс, фитнес (28274) болон Хүүхдийн хөгжил, эцэг эх (28232)		
Хүний үйлчилгээ	Хичээл сонголтын дараалал 1: Хүүхдийн хөгжил, эцэг эх (28232) болон Бага насны боловсрол I (28235)	Хичээл сонголтын дараалал 2: Хүүхдийн хөгжил, эцэг эх (28232), маргаашийн багш нар I (99062W) DE	Хичээл сонголтын дараалал 3: Ирээдүй багш сурган хүмүүжүүлэгч бэлтгэх хөтөлбөр I (99062W) DE, Ирээдүй багш сурган хүмүүжүүлэгч бэлтгэх хөтөлбөр II (29063)

DE - Хичээлийн хөтөлбөр нь мэргэшсэн суралцагчдад коллежийн давхар кредит авах боломж олгоно. Хичээлийн тайлбар хэсгээс нэмэлт мэдээллийг харах боломжтой.

* ОУБ хичээлийг зөвхөн Вашингтон-Либерти ахлах сургуульд явуулна.

** Зарим нэмэлт түвшинг бүрэн дунд сургуульд суралцах боломжтой. СТЕ-ийн бусад хичээлүүдийг Арлингтон хотын мэргэжил боловсролын төвд авах юм. Дэлгэрэнгүй мэдээллийг 74-р хуудаснаас харна уу.

- Суралцагчид СТЕ хичээлийг төлөвлөгөөний дагуу дуусасны дараа тухайн мужийн батлагдсан журмын дагуу баталгаажуулж сонгосон хичээлийн кредит авах болно.
- СТЕ давтлага хичээл бүр нь 2013-2014 онд болон түүнээс хойш ахлах сургуульд элсэн орж буй суралцагчдад Стандарт гэрчилгээний төгсөлтийн шаардлагад шаардагдах мэргэжлийн болон техникийн баталгаажуулалт хийх боломжтой.

БИЗНЕС болон МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ (МТ)

Бүх хичээлүүд нь Мэргэжил боловсрол, Техникийн/Дүрслэх Урлагийн кредит цагт тооцогдоно.

Суралцагчдаас сонгосон баталгаажсан кредитийг тухайн салбарын гэрчилгээг дамжуулж авах боломжтой.

Бүтэн жилийн хоёр хичээлийн сонголт нь даралсан шаардлагыг хангах болно.

Бизнес, мэдээллийн технологийн хөтөлбөр нь суралцагчдад нягтлан бодох бүртгэл, мэдээллийн технологи, мэдээллийн баазын удирдлага, компьютерийн сүлжээ, санхүү, захиргаа, эдийн засаг, бизнес эрхлэлт, вэбсайтын дизайн, компьютерын хэрэглээ, олон улсын бизнес, кибер аюулгүй байдал, ажлын байранд бэлэн байх чадвар, Компьютерийн програмчлал (кодчилал), Компьютерийн шинжлэх ухаан гэсэн хичээлүүдийг багтаасан байна. Хичээлүүд нь коллежид цаашид суралцахаар төлөвлөж байгаа, коллеж, ажил эрхлэлтийг хослуулахаар төлөвлөж байгаа, эсвэл бүрэн дунд боловсрол эзэмшсэнийхээ дараа бүрэн цагийн ажил хийхээр төлөвлөж буй суралцагчдад илүүтэй тохиромжтой. Сонгосон хичээлүүд нь суралцагчдад тухайн чиглэлийн гэрчилгээ олгох эсвэл коллежийн кредит цагийг тооцуулах боломжтой.

Тайлбар: 15-аас цөөн суралцагчтай хичээлийг суралцагчийн сонирхол, санхүүгийн асуудлыг харгалзан үзэх боломжтой. Зарим тохиолдолд төсвийн нэмэлт асуудлыг харгалзан тухайн жилд хичээл явуулахгүй байхыг шаарддаг бөгөөд энэ тохиолдолд суралцагчид өөр хичээлийн хөтөлбөр сонгох хэрэгтэй болно. Мөн элсэлт хангалтгүй хичээлийг зайны болон онлайн сургалтаар явуулна.

QuickBooks-тай нягтлан бодох бүртгэлийн хичээл (26320)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр суралцаж буй суралцагчид үйлчилгээний бизнес, худалдааны бизнесийн нягтлан бодох бүртгэлийн мөчлөгийн үндсэн зарчим, үзэл баримтлал, дадлыг заана. Ажил гүйлгээнд дүн шинжилгээ хийх, бичилт хийх, бичлэг хийх, цалингийн бүртгэл, санхүүгийн тайлан гаргах, бэлэн мөнгөний хяналтын системийг удирдах зэрэг сэдвүүд багтана. Бизнесийн ёс зүй, мэргэжлийн зан үйлийг чухалчилдаг. Суралцагчид нягтлан бодох бүртгэлийн үндсэн процедурыг гарын авлага, цахим систем ашиглан суралцна. Суралцагчид нягтлан бодох бүртгэлийн компьютержүүлсэн програм, QuickBooks эсвэл түүнтэй ижил төстэй компьютержүүлсэн бүртгэлийн системийг ашиглаж сурна.

Хамтарсан “Соор” Боловсрол, ажлын мэргэжлийн дадлага хичээл

Бүтэн жил, хувьсах хэмжигдэхүүн (1-3 хүртэлх кредит) ажилласан цагаасаа хамаарч кредит тооцно.

1 кредит (28951), 2 кредит (28953), 3 кредит (28954)

Элсэхийн өмнөх шаардлага: Ажил мэргэжлээр сонгон шалгаруулах (СТЕ) сонгон шалгаруулах сургалтанд нэгэн зэрэг элссэн байх.

Хамтарсан боловсрол хичээл нь суралцагчдад мэргэжлийн

зорилгоо биелүүлэхэд нь бэлтгэх эсвэл судлахад туслах зорилгоор анги танхимд суурилсан зааварчилгаа, ажлын байран дахь хичээлийг хослуулсан сургалтын зохион байгуулалт хөтөлбөр билээ. Энэ нь цалинтай дадлагаар ажил эрхлэлт гэж үзнэ. Суралцагчид долоо хоногт дунджаар 11-15 цаг ажиллана. Күүпийн хамтарсан хөтөлбөрийн суралцагчдад суралцагчийн ажлын туршлагыг тодорхойлсон албан ёсны, хувь хүний, бичгийн сургалтын төлөвлөгөөг удирдан чиглэл болгож явуулна. Суралцагчдыг хичээл зохицуулах багш, ажил олгогчийн ахлагч нараар үнэлүүлж, тухайн хичээл, ажлын туршлагын үсгийн үнэлгээ авна. Суралцагч Хичээлийн хөтөлбөрийн кредит, ажлын туршлагын кредит авахын тулд Мэргэжил боловсрол, техникийн боловсрол (СТЕ) зэрэгтэй тэнцэх ёстой. Сургалтын кредитээс гадна суралцагчид ажлын туршлагаасаа 1-3 кредит авах боломжтой. Суралцагчид 1 кредитэд 280 цаг, 2 кредитэд 560 цаг, эсвэл энэ хичээлийн жилд 3 кредитэд хамгийн багадаа 840 цаг байна. Зуны турш ажилласан ажлын туршлагын цаг нь суралцагчийн СТЕ хичээлд үргэлжлүүлэн элссэн тохиолдолд дараагийн хичээлийн жилийн ажлын кредитэд тооцогдоно. Суралцагчийн хөдөлмөр эрхлэлт нь холбооны, муж, орон нутгийн хүүхдийн хөдөлмөрийн тухай хууль тогтоомж, дүрэм журамд нийцнэ. СТЕ-ийн зэрэгцээ хичээлүүд нь 10-12-р ангиудад орно. Бизнес, Мэдээллийн Технологи, Компьютерийн шинжлэх ухаан, Худалдаа, үйлдвэрлэлийн боловсрол, Технологийн боловсрол, Гэр бүл, Хэрэглэгчийн шинжлэх ухааны хөтөлбөрийн аливаа хичээл юм. Хичээлийн нэмэлт мэдээллийг Судалгааны хөтөлбөрөөс харах боломжтой. Суралцагчийн хөдөлмөр эрхлэлт нь холбооны, муж, орон нутгийн хүүхдийн хөдөлмөрийн тухай хууль тогтоомж, дүрэм журамд нийцэж байх шаардлагатай. СТЕ-ийн зэрэгцээ хичээлүүд нь 10-12-р ангиудад санал болгодог Бизнес, Мэдээллийн Технологи, Компьютерийн шинжлэх ухаан, Худалдаа, үйлдвэрлэлийн боловсрол, Технологийн боловсрол, Гэр бүл, Хэрэглэгчийн шинжлэх ухааны хөтөлбөрийн аливаа хичээл юм. Хичээлийн нэмэлт мэдээллийг Судалгааны хөтөлбөрөөс харах боломжтой байна. Суралцагчийн хөдөлмөр эрхлэлт нь холбооны, муж, орон нутгийн хүүхдийн хөдөлмөр эрхлэх тухай хууль тогтоомж, дүрэм журамд нийцэж байх шаардлагатай. СТЕ-ийн зэрэгцээ хичээлүүд нь 10-12-р ангиудад санал болгодог Бизнес, Мэдээллийн Технологи, Компьютерийн шинжлэх ухаан, Худалдаа, үйлдвэрлэлийн боловсрол, Технологийн боловсрол, Гэр бүл, Хэрэглэгчийн шинжлэх ухааны хөтөлбөрийн аливаа хичээл юм. Хичээлийн нэмэлт мэдээллийг Судалгааны хөтөлбөрөөс хэсгээс тодруулна уу.

Компьютер мэдээллийн систем (26614) (96614W)

1 жил, 1 кредит, + 1.0 чанарын оноо

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

шүүмжлэлтэй дүн шинжилгээ хийхэд суралцагчийг татан оролцуулах зорилготой юм. Сонгосон эх бичвэрүүдийг сайтар уншиж судалснаар суралцагчид зохиолчдыг хэлээ ашиглан уншигчиддаа утга санаа, таашаал өгөх арга хэлбэрийн талаархи ойлголтоо гүнзгийрүүлж чадна. Уншихдаа суралцагчид бүтээлийн бүтэц, хэв маяг, хүүрнэх өнцөг, тохиргоо, сэдэв, уран зохиолын хэл, дүрслэл, бэлгэдэл, яруу найргийн тоолуур, синтакс, өнгө аяс зэрэг утга зохиолын илүү нарийн элементүүдийг суралцагчид мэддэг олгоно. Хичээлийн үнэлгээ нь суралцагчийг Коллежийн зөвлөлийн хоёр хэсгээс бүрдэх, үнэ төлбөргүй, олон сонголттой, эссэ бичих шалгалтаас бүрдэх шалгалтанд бэлтгэнэ. Суралцагчид энэ хичээлтэй холбоотой AP шалгалт өгөх шаардлагатай. Шалгалтанд хамрагдахгүй байгаа суралцагчид нэмэлт чанарын оноо тооцохгүй. (21195)

Англи хэл 12, (Коллежийн бүрэлдэхүүн) Хос элсэлт (91160W)

1 жил, 1 кредит, + 1.0 чанарын оноо

Анги: 12

Элсэхээс өмнөх шаардлага: Англи хэлний өмнөх ангиудад сурлагын түвшин өндөр эсвэл багшийн зөвшөөрлөөр суралцах. Бүртгүүлэхээс өмнө NVCC элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой.

Энэхүү хичээл нь 12-р ангийн Англи хэлний сургалтын Виржиниа стандартыг судалж, суралцагчдад шүүмжлэлт сэтгэлгээ, академик бичгийн үндэс суурийг таниулах болно. Бичих явцад суралцагчид сэдвийг сайжруулах болно; санаануудыг боловсруулж, дэмжих; зохих нөөцийг судлах, үнэлэх, нэгтгэх; үр дүнтэй хэв маяг, хэрэглээнд зориулж засах; төрөл бүрийн нөхцөл байдал, үзэгчид, зорилгод тохирсон хандлагыг тодорхойлох. Бичгийн үйл ажиллагаанд Суралцагчдаас эх сурвалжийг олох, үнэлэх, нэгтгэх, баримтжуулах, хэв маяг, хэрэглээнд зориулж үр дүнтэй засварлахыг шаардсан дор хаяж нэг судлагдсан эссэ бүхий илтгэл, мэтгэлцээн гэсэн агуулга багтана.

- **Коллежийн кредит:** Энэхүү хичээлийг Хойд Виржиниа мужийн ENG 111/ENG 112 коллежид давхар бүртгэж болно. Бүртгүүлэхийн өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүйг сургуулийнхаа зөвлөхөөс тодруулна уу.

Англи хэл 12, (Их Британи, Дэлхийн уран зохиол) Хос элсэлт (91161W)

1 жил, 1 кредит, + 1.0 чанарын оноо

Анги: 12

Элсэхээс өмнөх шаардлага: Англи хэлний 11, College Composition, DE (91150W) эсвэл Англи хэлний 12, Коллежийн түвшин найруулан бичих чадвар, DE (91160W) -г амжилттай дүүргэсэн. NOVA ENG 111 болон ENG 112.

Энэхүү хичээл нь 12-р ангийн англи хэлний сургалтын Виржиниа стандартыг судлах, Англи болон дэлхийн уран зохиолын томоохон бүтээлүүдийг судлах болно. Суралцагчид Англо-Саксоны үеэс өнөөг хүртэл Британийн утга зохиолын уламжлалын үзэл санаа, онцлог шинж чанарыг онцолсон Английн томоохон бүтээлүүдийг судлах болно. Суралцагчид орчин үеийн дэлхийн уран зохиолын томоохон бүтээлүүдийг судлах юм. Энэхүү хичээл нь бүхэлдээ унших, бичих чадварыг хөгжүүлэх болно.

- **Коллежийн кредит:** Энэхүү хичээлийг Хойд Виржиниа мужийн ENG 251/ENG 243 коллежид давхар бүртгүүлж болно. Бүртгүүлэхийн өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүйг сургуулийнхаа зөвлөхөөс тодруулна уу.

АНГЛИ ХЭЛНИЙ СОНГОЛТТОЙ ХЭЛ УРЛАГИЙН ХИЧЭЭЛҮҮД

Суралцагчдаа баяжуулах, амжилтаа ахиулах, эсвэл сонирхсон зүйлээ хэрэгжүүлэхийн тулд суралцагчид шаардлагатай англи хэлний урлагийн үндсэн хичээлээс гадна дор дурдсан хичээлүүдэд хамрагдаж болно.

Унших ур чадвар, стратегиуд (21180)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: Сургуульд TBD

Элсэхээс өмнөх шаардлага: Байхгүй.

Хичээл нь фоник, фонемик ойлголт, чөлөөтэй, үгсийн сан, эсвэл ойлголтын үндсэн үндсийг унших нэмэлт дэмжлэгийг авах боломжтой суралцагчдад маш тохирох агуулга болно. Сургалтын явцад суралцагчдын унших түвшинд тохирсон зөгнөлт болон уран зохиолын текстүүдийг бүх нийтийн скрининг хийх хэрэгсэлээр тодорхойлсон байхаас гадна SOL тест бэлтгэхэд тохирсон богино хэсгүүдийг оруулж өгсөн болно.

Англи хэл 11 нэмэлт (21185)

Бүтэн жил, нэг сонгосон кредит

Анги/Ангиуд: 11-12-р анги

Элсэхээс өмнөх шаардлага: Англи хэлний 11 суралцагч, зэрэг сурж байгаа суралцагч байх.

Энэхүү хичээл нь Англи хэлний суралцагчдын хөтөлбөрт ороод удаагүй шинэ агуулга бөгөөд англи хэлний анги, ЕОС англо хэлний шалгалтанд амжилттай тэнцэхэд унших, бичих чадварыг хөгжүүлэх нэмэлт хичээлийн бэлтгэх суралцагчдад зориулагдсан хөтөлбөр болно. Ахлах сургууль болон бусад сургуульд амжилтанд суралцахад шаардлагатай дүн шинжилгээ хийх унших, бичих чадварыг хөгжүүлэхэд суралцагчид туслалцаа үзүүлнэ.

Кино урлага (21446)

1 улирал, хагас кредит

Анги/Ангиуд: Сургуульд TBD

Элсэхийн өмнөх шаардлага:

Энэхүү хичээл нь суралцагчдад киноны шүүмж үнэлгээ, бүтээл, кино урлагийн түүхийн мэдлэгийг олж авах суурь агуулга юм. Суралцагчдад кино бүтээгчид киноны зураг авахад ашигладаг томоохон ойлголт, арга техникийг заах болно. Киноны техникийн талыг сурч мэдсэний дараа суралцагчид сонгодог кинонуудтай танилцаж, тэдний урлагийн бүтээл болох ач холбогдлыг харуулах юм. Хичээл нь суралцагчийн аман болон бичгийн харилцааны чадварыг дээшлүүлэх бөгөөд эдгээр нь кинонд дүн шинжилгээ хийх түлхүүр билээ. Энэ сургалтанд хамрагдсан кредит нь төгсөх мэргэжлийн Мэргэжил боловсрол, техникийн/дүрслэх урлагийн кредитийн шаардлагыг хангасан хичээлийн хөтөлбөр.

Динамик харилцаа холбоо (21517)

1 улирал, хагас кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Энэ хичээл нь харилцааны үйл явцын динамикийг онцлон ярих, сонсох, харилцан ярилцах чадварыг хөгжүүлнэ. Дуу хоолой хөгжүүлэх, дохио зангаа ашиглан ойлголцох, үзэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх нь энэхүү хичээлийн үндсэн агуулгад багтах юм. Суралцагчид үр дүнтэй хэлэлцүүлэг, танилцуулга, илтгэл, ярилцлага болон бусад нийгэм/бизнесийн яриаг хөгжүүлэх арга техникийг заан сургах болно.

Сэтгүүл зүй: Нэвтрүүлэх (21218)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Англи хэлний багийн тодорхойлолтоор анкет бөглөж, багштай ярилцлагад орсон байх.

Энэ ангийн сурагчид тогтмол дамжуулдаг сургуулийн онцлог мэдээ, нэвтрүүлэг хийхээр ажилд оролцдог. Энэ ангийн сурагчид радио, телевиз, интернет, видео/кино мэдээллийн хэрэгсэлээр мэдээ, мэдээллийн хөтөлбөрийг мэдээлэх, гаргах, хүргэх арга, арга техникийг судлах, тэдгээрийг ашиглахад суралцах болно. Мэргэжлийн өргөн нэвтрүүлгийн сэтгүүлч, редактор, продюсер, найруулагч, менежерийн үүрэг хариуцлагыг судлах болно. Суралцагчид өргөн нэвтрүүлгийн технологийн зарчмуудын талаар практик туршлагатай болно; нэвтрүүлгийн талаар мэдээлэх; хөтөлбөр, дуу чимээ, видео/кино засварлах; хөтөлбөр боловсруулах, үйлдвэрлэх; мэргэжлийн стандарт, ёс зүй зэрэг агуулгыг хамруулна судална. Тус хичээлийн үр дүнд ахлах сургуулиас хамаарч өөр өөр байж болно; дэлгэрэнгүй багштай зөвлөх боломжтой.

Сэтгүүл зүй: Утга зохиолын сэтгүүлзүй (21207)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Англи хэлний багийн тодорхойлолтоор анкет бөглөж, багштай ярилцлагад орсон байх.

Энэ ангийн суралцагчид суралцагчийн уран зохиолын болон дагалдах уран бүтээлийн сэтгүүл хэвлэн гаргах ажилд оролцоно. Уран зөгнөлт, уран зохиол, яруу найраг, жүжиг, хөгжмийн оноог нийтлэх мөчлөгийн туршид зохиож/эсвэл засварладаг. Дүрслэх урлаг, гэрэл зураг, зохион байгуулалтын загварыг дижитал хэлбэрээр боловсруулж, нийтлэх агуулгыг хамруулан судална. Тус хичээлийн үр дүнд ахлах сургуулиас хамаарч өөр өөр байж болно; дэлгэрэнгүй багштай зөвлөх боломжтой.

Сэтгүүл зүй: Сонин (21205)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Англи хэлний багийн тодорхойлолтоор анкет бөглөж, багштай ярилцлагад орсон байх.

Энэ ангийн сурагчид тогтмол хэвлэгддэг сургуулийн тусгай хэвлэлийн сонин, вэбсайт гаргахаар ажилладаг. Тайлбар бичих нь энэ хичээлийн гол ач холбогдол юм. Бичвэрт мэдээ, онцлог, редактор, спорт, сонин ярилцлагын булан, шүүмж бичих зэрэг багтдаг боловч үүгээр хязгаарлагдахгүй. Эх бичвэрийг бэлтгэхэд ярилцлага, судалгааны арга техник ашиглаж гүйцэтгэнэ. Энэ дагуу сонингийн зураг төсөл зохиох, хэвлэх, гарчиг бичих, гэрэл зураг, дижитал зураг засварлах зэрэг сонин хэвлэлийн механик, хэвлэн нийтлэх төрөл бүрийн арга техникийг заах болно. Тус хичээлийн үр

дүнд ахлах сургуулиас хамаарч өөр өөр байж болно; дэлгэрэнгүйг багштай зөвлөх боломжтой.

Сэтгүүл зүй: жилийн эмхэтгэл (21209)

1 жил, 1 кредит

Анги/Ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Англи хэлний багийн тодорхойлолтоор анкет бөглөж, багштай ярилцлагад орсон байх.

Энэ хичээлийн онцлог нь хамрагдсан сурагчид хичээлийн жилийн сургуулийн эмхэтгэл сонинг хэвлүүлэхээр ажилд гар бие оролцоно. Суралцагчид бүтээлийн тайлбар, гарчиг, тайлбар бичих зэрэг ажлын ихэнх хэсэгт тайлбар бичих чадварыг олж авна. Суралцагчид сэтгүүл бэлтгэн гаргах, механик ажилбар, бүтэц, хэв маяг, гол сэдэв, эх агуулга, ноорог эх бичвэр бичих, хэвлэх, гэрэл зураг авах, зураг засварлах, байрлуулах, хэвлэх арга техникийг сурч, дадлага туршлага олж авна. Тус хичээлийн үр дүнд ахлах сургуулиас хамаарч өөр өөр байж болно; дэлгэрэнгүйг багштай зөвлөх боломжтой.

ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ,БИЕЙН ТАМИРЫН ХИЧЭЭЛ

Ерөнхий боловсролын сургууль төгсөхөд эрүүл мэндийн боловсрол болон биеийн тамирын хичээлийн хоёр жилийн боловсролыг эзэмшсэн байх шаардлагатай. Энэхүү шаардлагыг хангахын тулд сурагчдад 9,10-р ангид нь эрүүл мэнд,биеийн тамирын хичээл орох хуваарьтай байдаг. 11,12-р ангийнхан биеийн тамирын хичээлийг нэг улирал эсвэл бүтэн жилээр орохоор сонгох боломжтой. Нэмэлт хөтөлбөртэй биеийн тамирын хичээлийг 9-12-р ангид сонгох боломжтой.

Тайлбар: 15-аас цөөн сурагчтай хичээлийг сурагчдын сонирхол,төсвийн асуудлаас шалтгаалан орохгүй байх боломжтой. Зарим тохиолдолд төсвийн асуудлаас шалтгаалан тухайн жилд хичээл орохгүй байх магадлалтай бөгөөд энэ хичээлд хамрагдах сурагчид нь өөр хичээл сонгох хэрэгтэй. Мөн сурагчдын тоо хангалтгүй хичээл нь зайнаас буюу онлайнгаар хичээл орох магадлалтай болох юм.

Эрүүл мэнд I(27320)

Нэг улирал,хагас кредит

Орох ангиуд:9

Энэхүү хичээл нь эрүүл мэндийн мэдлэг болон,шинж чанарын талаархи янз бүрийн мэдлэгийг заах болно. Сурагчид нь эрүүл мэндийн талаар сурч ойлгосноор,өөрсдөдөө болон гэр бүлийнхэндээ, олон нийтийн амьдралын эрүүл хэв маягт эерэгээр нөлөөлөх болно. Сурагчид яаралтай анхны тусламж үзүүлэх мэдлэг, зүрхний хэмнэлийг сайжруулах хэрэгсэл ашиглах болон хиймэл амьсгал хийхэд шаардлагатай ур чадварыг өөрсдийн биеээр хийж дадлагажин сурах болно. Орох хичээлийн чиглэлүүд нь сэтгэл зүй, нийгмийн болон,хүрээлэн буй орчны эрүүл мэнд, аюулгүй байдал мөн яаралтай үеийн бэлэн байдал,харилцаа холбоо,мансууруулах бодис хэрэглэхээс болон өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гэр бүлийн эрүүл амьдралын талаар байх болно.

Эрүүл мэндийн боловсрол,биеийн тамирын хичээл (27330)

Зөвхөн Вашингтон-Либерти болон Уэйкфилд мужид

орно

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд:9

Элсэхийн өмнөх шаардлага: Англи хэл хөгжүүлэх ангид мөн бүртгүүлсэн байх ёстой

Энэхүү хичээл нь англиар ярих чадвар муутай сурагчдыг бие бялдар хөгжүүлэх/эрүүл мэндийн боловсролын хөтөлбөрт хамрагдах боломжийг олгох зорилготой юм.. Орох хичээлийн чиглэлүүд нь сэтгэл зүй, нийгмийн болон,хүрээлэн буй орчны эрүүл мэнд ,аюулгүй байдал мөн яаралтай үеийн бэлэн байдал,харилцаа холбоо, мансууруулах бодис хэрэглэхээс болон өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гэр бүлийн эрүүл амьдралын талаар байх болно.

Эрүүл мэндийн боловсрол,биеийн тамирын хичээл I (27300)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд:9

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Энэхүү хичээл нь эрүүл мэндийн талаархи олон янзын мэдлэг болон зан үйлийн байдлыг зааж,сурагчдын насан туршийн янз бүрийн нөхцөлд хэрэглэгдэх мэдлэг болон ур чадварыг биеээр нь хийлгэн дадлагажуулах боломжийг олгох болно. Сурагчид нь эрүүл мэндийн талаар сурч ойлгосноор,өөрсдөдөө болон гэр бүлийнхэндээ,олон нийтийн амьдралын эрүүл хэв маягт эерэгээр нөлөөлөх болно. Сурагчид яаралтай анхны тусламж үзүүлэх мэдлэг,зүрхний хэмнэлийг сайжруулах хэрэгсэл ашиглах болон хиймэл амьсгал хийхэд шаардлагатай ур чадварыг өөрсдийн биеээр хийж дадлагажин сурах болно. Орох хичээлийн чиглэлүүд нь сэтгэл зүй, нийгмийн болон,хүрээлэн буй орчны эрүүл мэнд ,аюулгүй байдал мөн яаралтай үеийн бэлэн байдал,харилцаа холбоо,мансууруулах бодис хэрэглэхээс болон өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ,гэр бүлийн эрүүл амьдралын талаар байх болно. Хичээл дээр энергийн болон амин дэмийн тогтвортой байдлын ашгийг харуулах болно. Сурагчид бие бялдын чийрэгжилтээ сайжруулахын тулд дасгалын хуваарь төлөвлөн гаргаж,биеийн дасгалжилтын ашгийг ойлгон, биомеханик, анатомийн талаар сурах болно.

Эрүүл мэндийн боловсрол,биеийн тамирын хичээл II (27400)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд:9

Элсэхийн өмнөх шаардлага: Эрүүл мэндийн боловсрол, биеийн тамирын хичээл I –г судалсан байх

Сурагчид эрүүл мэндийн болон,эрүүл байх талаархи мэдлэг,ур чадвараа харуулах болно. Орох хичээлийн чиглэлүүд нь сэтгэл зүй, нийгмийн болон,хүрээлэн буй орчны эрүүл мэнд ,аюулгүй байдал мөн яаралтай үеийн бэлэн байдал,харилцаа холбоо, мансууруулах бодис хэрэглэхээс болон өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ,гэр бүлийн эрүүл амьдрал,эрүүл мэнд болон анагаах ухааны мэргэжлийн талаар сурах болно. Сурагчид биеийн дасгалжилтын ашгийг,биомеханик,анатомийн талаар насан туршид хэрэглэх янз бүрийн үйл ажиллагаанд оролцох замаар ойлгох болно. Энэхүү хичээл нь хувь хүний,бүлгийн насан туршийн бие бялдын чийрэгжилтийг,бүжиг болон,чөлөөт цагаа өнгөрөөх дасгалын замаар онцлон заадаг. Энэ нь хувийн бие бялдын чийрэгжилтийг төлөвлөгөө боловсруулах,хэрэгжүүлэх,өөрийгөө үнэлэх, төлөвлөгөөгөө өөрчлөх замаар сайжруулан

дэмждэг.

**Нэмэлт хөтөлбөртэй биеийн тамирын хичээл (27670)
9-р анги**
**Нэмэлт хөтөлбөртэй биеийн тамирын хичээл (27680)
10-р анги**
**Нэмэлт хөтөлбөртэй биеийн тамирын хичээл (27690)
11-р анги**
**Нэмэлт хөтөлбөртэй биеийн тамирын хичээл (27700)
12-р анги**

Сурагчдыг эцэг эх, мэргэжлийн болон өрхийн эмчийн, сувилагчийн тодорхойлолтын дагуу сургуулийн нэмэлт хөтөлбөртэй биеийн тамирын хичээлд хамруулж болно. Тухайн сурагчийн биеийн тамирын дасгал хөдөлгөөнийг эцэг эх, сургуулийн сувилагч, өрхийн эмч, багшийн туслалцаатайгаар боловсруулан зохиодог. Өрхийн эмч нь сурагчийн хөгжлийн бэрхшээлтэй холбоотой сөрөг үйл ажиллагааг тодорхойлох ёстой.

БИЕИЙН ТАМИРЫН СОНГОЛТТОЙ ХИЧЭЭЛҮҮД

Биеийн тамир III (27510)
Эхний улирал; (27515) Хоёрдугаар улирал
Нэг улирал, хагас кредит
Орох ангиуд: 11-12
Биеийн тамир IV (27610)
Эхний улирал; (27615) Хоёрдугаар улирал
Нэг улирал, хагас кредит
Орох ангиуд: 11-12

Элсэхийн өмнөх шаардлага: Биеийн тамир I, II – г судалсан байх

Энэхүү хичээл нь сурагчдад тодорхой зорилгоор биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийх боломжийг олгодог. Хичээлд орох тодорхой дасгал хөдөлгөөнийг сурагчийн хэрэгцээнд тохируулан сонгох болно. Сурагчид дараахь жишээнээс өөрсдийн сурах сэдвийг сонгох боломжтой.

- Аэробик
- Усан спорт (усан сэлэлт, сэлүүрт завиар явах, аврагчаар сурах)
- Бүжиглэх
- Бие даасан спорт/үйл ажиллагаа
- Гадуур аялах
- Бие бялдараа хөгжүүлэх ахисан дасгалууд
- Уран гулгалт
- Өөрийгөө хамгаалах урлаг

АНГЛИ ХЭЛ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Англи хэл сурах (EL) хичээл нь Англи хэлний түвшин муу гэж тодорхойлогдсон сурагчдад ордог хичээл юм. Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр (ELD) нь Олон улсын Англи хэлний хичээл заах арга барилын стандарт ба Виржиния мужийн сургалтын стандарттай нийцдэг.

Англи хэлний мэдлэг тааруу (ELP) 1-р түвшин эсвэл 2-р түвшинтэй гэж тогтоогдсон сурагчид Англи хэл заах сургуулийн гэрчилгээтэй багштай унших болон хэлний урлаг (хоёр хичээлийн цаг) сурах болно. Сурагчид шинжлэх ухаан болон нийгмийн ухааны чиглэлээр Англи хэл заах сургуулийн гэрчилгээтэй багштай эсвэл өөр ангитай хамтран, ерөнхий боловсролын хичээл, биеийн тамирын

хичээлийг сурдаг. Сурагчидын бэлэн байдлаас шалтгаалан математикийн хичээлийг сурах эсэхийг тодорхойлдог. Англи хэлний кредитийг Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр 1, Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр 2, Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөрийн Англи хэл 9-р анги, Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөрийн Англи хэл 10-р анги-аас авах боломжтой бөгөөд энэ нь төгсөхөд шаардлагтай англи хэлний тодорхой нөхцөлийг хангаж өгдөг. Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөрийн нэмэлт ангиуд нь дор дурдсан Тайлбарээс хамааран ордог.

Тайлбар: 15-аас цөөн сурагчтай хичээлийг сурагчдын сонирхол, төсвийн асуудлаас шалтгаалан орохгүй байх боломжтой. Зарим тохиолдолд төсвийн асуудлаас шалтгаалан тухайн жилд хичээл орохгүй байх магадлалтай бөгөөд энэ хичээлийн сурагчид нь өөр хичээл сонгох хэрэгтэй. Мөн сурагчдын тоо хангалтгүй хичээл нь зайнаас буюу онлайн аргаар хичээл орох магадлалтай болох юм.

Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр (ELD)-ийн санал болгох хичээлүүд

Бүтэн жил

Англи хэлний мэдлэгийн түвшинд үндэслэн байрлуулах

20775 Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр 1/Бүрэн бус ерөнхий боловсролын мэдлэгтэй сурагчдын бичиг үсгийг хөгжүүлэх хөтөлбөр (сонгох кредит).
Шаардлагатай тохиолдолд эх хэлний дэмжлэг үзүүлж болно.

20776 Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр 1/Бүрэн бус ерөнхий боловсролын мэдлэгтэй сурагчдын унших чадварыг хөгжлүүлэх хөтөлбөр (сонгох кредит)

20780 Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр 1 шинжлэх ухаан (сонгох кредит: төгсөхөд шаардлагатай шинжлэх ухааны тодорхой нөхцөлийг хангадаггүй)

20781 Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр 2 шинжлэх ухаан (сонгох кредит: төгсөхөд шаардлагатай шинжлэх ухааны тодорхой нөхцөлийг хангадаггүй)

24317 Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр Биологи (Шинжлэх ухааны кредит)

24362 Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр Байгаль орчны шинжлэх ухаан (Шинжлэх ухааны кредит)

24501 Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр Физик (Шинжлэх ухааны кредит)

20786 Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр 1 Англи хэл (Англи хэлний кредит)

20787 Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр 1 Унших (сонгох кредит)

20788 Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр 1 Ярих/Бичих (сонгох кредит)

2B20789 Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр 1 Нийгмийн судалгаа (сонгох кредит)

22446 Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр Виржиния болон АНУ-ын засгийн газар (Нийгмийн ухааны кредит)

B20790 Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр 2 Англи хэл (Англи хэлний кредит)

B20791 Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр 2 Унших (сонгох кредит)

B20793 Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр 2 Нийгмийн судалгаа (сонгох кредит)

20794 Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр 3 Унших 9-р анги (сонгох кредит)

20796 Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр 3 Англи хэл 9-

- р анги** (*Англи хэлний кредит*)
20797 Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр 4 Унших 10-р анги (*сонгох кредит*)
20799 Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр 4 Англи хэл 10-р анги (*Англи хэлний кредит*)
22345 Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр 3-4 Дэлхийн түүх ба газар зүй: Манай Эриний өмнөх зуун 1500 он хүртэл (*Нийгмийн ухааны кредит*)
22213 Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр Эдийн засаг ба хувийн санхүү (*Нийгмийн ухааны кредит*)

МАТЕМАТИК

Арлингтон дахь математикийн хичээл нь математикийн чиглэлээр суралцаж буй сурагчиддаа ахлах сургуулиас гадна суралцах, мэргэжилээ дээшлүүлэх, үр дүнтэй иргэн байх тал дээр анхааран хичээлээ ордог. Бүх сурагчдыг сургуульд сурч байхдаа жил бүр математикаар хичээллэхийг уриалж байна. Хичээлийн сонголтууд нь сурагчидын чадварынхаа хэмжээгээр ахиц дэвшил гаргах боломжийг олгодог. Хичээлд Элсэхийн өмнөх шаардлага, математикийн нэмэлт хичээлд давхар элсэхээс чөлөөлөгдөхийг хүсч буй сурагч, гэр бүлийнхэн Хичээлд Элсэхийн өмнөх шаардлагаас чөлөөлөгдөх зүйлийг 2-р хуудаснаас үзнэ үү. Эдгээр сурагчид математикийн багштайгаа ярилцах хэрэгтэй.

Тайлбар: 15-аас цөөн сурагчтай хичээлийг сурагчдын сонирхол, төсвийн асуудлаас шалтгаалан орохгүй байх боломжтой. Зарим тохиолдолд төсвийн асуудлаас шалтгаалан тухайн жилд хичээл орохгүй байх магадлалтай бөгөөд энэ хичээлийн сурагчид нь өөр хичээл сонгох хэрэгтэй. Мөн сурагчдын тоо хангалтгүй хичээл нь зайнаас буюу онлайнаар хичээл орох магадлалтай болох юм.

Ахлах сургуулийн ерөнхий математик (23120)

Бүтэн жил, нэг сонгох кредит

Орох ангиуд: 9-11

Элсэхийн өмнөх шаардлага: 8-р ангийн сурагчдын анхан шатны алгебр

Сурагчид энэ хичээлд бүхэл тоо, бутархай, аравтын бутархай, хувьлах тооцоо, тооцооллын талаархи ойлголтоо хөгжүүлэх болно. Эдгээр ойлголтыг хэмжилт, магадлал, статистик, геометрийн чиглэлийн асуудал дээр ашиглан хэрэглэх болно. Сурагчид анхан шатны алгебр, рационал тоо, хувь ба харьцаа, бүхэл тоо, хувьсагчийн илэрхийлэл ба тэгшитгэл, график зураглал зэргийг сурах болно. **Энэ хичээл нь математикийн кредит шаардлагыг хангахгүй боловч, энэ нь сонгох кредит өгдөг.**

Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр/Бүрэн бус ерөнхий боловсролын мэдлэгтэй сурагчдын Математикийн үндсэн суурь (23111)

Бүтэн жил, нэг сонгох кредит

Орох ангиуд: 9-11

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Энэхүү хичээл нь Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөрт хамрагдсан, Бүрэн бус ерөнхий боловсролын мэдлэгтэй сурагчдад зориулагдсан болно. Сурагчид бүхэл тоо, бутархай, аравтын бутархай, хувьлах тооцоо, тооцооллын талаархи ойлголтоо хөгжүүлэх болно.

Эдгээр ойлголтыг хэмжилт, магадлал, статистик, геометрийн чиглэлийн асуудал дээр ашиглан хэрэглэх болно. **Энэ хичээл нь математикийн кредит шаардлагыг хангахгүй боловч, энэ нь сонгох кредит өгдөг.**

Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр/Бүрэн бус ерөнхий боловсролын мэдлэгтэй сурагчдын анхан шатны алгебр (23113)

Бүтэн жил, нэг сонгох кредит

Орох ангиуд: 9-11

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Энэхүү хичээл нь Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөрт хамрагдсан, Бүрэн бус ерөнхий боловсролын мэдлэгтэй сурагчдад зориулагдсан болно. Сурагчид анхан шатны алгебр, рационал тоо, хувь ба харьцаа, бүхэл тоо, хувьсагчийн илэрхийлэл ба тэгшитгэл, график зураглал зэргийг сурах болно. Агуулга, үйл явц, хэлний хөгжлийг сайжруулах олон янзын аргыг ашиглах болно. **Сурагчид энэ хичээлийг төгссөний дараа Алгебр I эсвэл Алгебр I-ийн 1-р бүлэгд элсэн орох хэрэгтэй. Энэ хичээл нь математикийн кредит шаардлагыг хангахгүй боловч, энэ нь сонгох кредит өгдөг.**

Алгебр I-ийн 1-р бүлэг (23131)

Бүтэн жил, 23132 эсвэл 23130-ийг амжилттай төгссөний дараа нэг кредит

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Энэхүү бүтэн жилийн нэг хичээлийн цагийн хичээл нь бодит тоон системийн шинж чанар, координатын хавтгай, шугаман тэгшитгэл ба тэгш бус байдал, тэгшитгэлийн систем, функцууд, бодлого бодох чадварыг заах болно. Сурагчид стандарт диплом авахыг хүсээгүй тохиолдолд энэ хичээлийн сонгох кредитийг авах боломжтой, эс бөгөөс энэ хичээл нь стандарт дипломын математикийн кредитэд тооцогддог. Энэ хичээлийн дараа сурагчид Алгебр I-ийн 2-р бүлэгт сурах ёстой. Сурагчид энэ хичээлийн төгсгөлд ерөнхий боловсролын шалгалт өгөхгүй, гэхдээ энэ хичээлийн агуулга нь Алгебр I-ийн 2-р бүлэг дуусах үеийн Алгебр I ерөнхий боловсролын шалгалтанд гарч ирнэ.

Алгебр I-ийн 2-р бүлэг (23132)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 9-11

Элсэхийн өмнөх шаардлага: Өмнөх математикийн хичээлийн "C" буюу түүнээс дээш үнэлгээ, багийн тодорхойлолт

Энэхүү бүтэн жилийн нэг хичээлийн цагийн хичээл нь Алгебр I-ийн 1-р бүлгийн хичээлийг тоймлон оруулаад дараахь сэдвүүдийг нэмж оруулна үүнд: зэрэгт дэвшүүлэгч, радикалууд, олон гишүүнтүүд, квадрат тэгшитгэлийг шийдвэрлэх, графикчлах, статистик, асуудал шийдвэрлэх зэрэг орно. Энэхүү хичээл нь бүх сурагчдад математикийн кредит болон тооцогддог. Энэ хичээлээс өмнө сурагчид Алгебр I-ийн 1-р бүлгийг төгссөн байх ёстой. **Энэ хичээлийн төгсгөлд сурагчид Алгебр I ерөнхий боловсролын шалгалт өгдөг. Шалгалтыг амжилттай өгснөөр төгсөхөд шаардлагтай математикийн кредитийг авдаг.**

Алгебр I (23130)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд:9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Өмнөх математикийн хичээлийн "C" буюу түүнээс дээш үнэлгээ, багийн Тодорхойлолт

Энэ хичээлд бодит тоон системийн шинж чанарууд, шугаман тэгшитгэл ба тэгш бус байдал, тэгшитгэл ба тэгш бус байдлын систем, илэрхийлэгч, радикал, рационал илэрхийлэл ба тэгшитгэл, олон гишүүнт, үржүүлэх болон хуваах,квадрат тэгшитгэлийг шийдвэрлэх, графикчлах, функц,статистик асуудал шийдвэрлэх зэрэг орох болно. Энэ хичээлийн төгсгөлд сурагчид Алгебр I ерөнхий боловсролын шалгалт өгдөг. *Шалгалтыг амжилттай өгсөнөөр төгсөхөд шаардлагтай математикийн кредитийг авдаг.*

Алгебр I-ийн стратеги хичээл (23124)

Бүтэн жил, нэг сонгох кредит

Орох ангиуд:10-12

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй..

Алгебр I-ийн стратеги хичээл нь Алгебрийн I-д нэмэлт дэмжлэг хэрэгтэй байгаа сурагчдад зориулсан сонгон суралцах хичээл юм. Элссэн сурагчид суурь мэдлэгийг дээшлүүлж,агуулгын талаар илүү ойлгомжтой аргаар сурч,үндсэн хичээлийн агуулгыг илүү нарийн үзэх болно. Энэ хичээлд орохын тулд Алгебр I (23130)-д элссэн байх шаардлагатай.

Алгебр,функц ба өгөдлийн задаргаа (23145)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд:10-12

Элсэхийн өмнөх шаардлага: Алгебр I хичээлийг судалсан байх

Энэхүү хичээл нь Алгебр I-ийн ойлголтуудыг Математик загварчлал ба өгөгдөлийн задаргаа хийх аргаар Алгебр II сэдвүүдийн агуулгын тойм руу ойртуулах зорилготой юм. Энэ хичээлд сурагчид функцийн өргөн шинж чанар, зан үйлийг судалж, шугаман,квадрат, экспоненциал,логарифм тэгшитгэл эсвэл тэгшитгэл,тэгш бус байдлын системийг томъёолох шаардлагатай асуудлуудыг шийдвэрлэх болно. Сурагчдад эдгээр чиг сэдвийн талаархи ерөнхий ойлголтыг олж авч,дараагийн хичээлд илүү нарийвчлан сурахад нь туслах болно. Магадлал,туршилтын зураг төсөл,хэрэгжилт, өгөгдлийн задаргаа зэрэг сэдвүүдийн функцийг судлах хичээлд нэгтгэх бөгөөд бодит амьдралын асуудлууд дээрээс үүдэлтэй практик хэрэглээний өгөгдлүүд дээр ажиллах болно.

Алгебр II (23135)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд:9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Алгебр I (эсвэл Алгебр I Түргэвчилсэн сургалттай) ба Геометрийн (эсвэл Геометр Түргэвчилсэн сургалттай) хичээлийн "C" эсвэл түүнээс дээш үнэлгээ.

Энэ хичээл нь Алгебр I ба Геометрийн өргөтгөл юм. Алгебр II хичээлийн хөтөлбөрт квадрат,олон гишүүнт,хүч,язгуур, радикал,гэх мэт эдгээр сэдэвтэй холбоотой функцуудыг нарийвчлан заах болно. Энэ хичээлд конус, логарифм,экспоненциал функц,комплекс тоо,дараалал,өөрчлөлт, хамтатгал,магадлал, статистикийг

заах болно. Технологийн хэрэглээ нь энэ хичээлийн салшгүй хэсэг юм. *Алгебр II хичээлийн төгсгөлд ерөнхий боловсролын шалгалтыг Холбооны шаардлагыг хангахын тулд өгөх хэрэгтэй байдаг бөгөөд төгсөхөд шаардлагтай математикийн кредитийг авдаг.*

Алгебр II/ Тригонометр,Түргэвчилсэн сургалттай (23136)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд:9-12

Элсэхийн өмнөх шаардлага:Геометрийн түргэвчилсэн сургалттай хичээл дээр "B" ба түүнээс дээш, багийн тодорхойлолт, эсвэл Алгебр I ба Геометрийн аль алинд нь "B" ба багийн Тодорхойлолт

Алгебр II (23135)-ийн агуулгыг илүү гүнзгий үзэхээс гадна тригонометр ба тригонометрийн функц гэсэн сэдвүүдийг энэхүү гүнзгийрүүлсэн хичээлд оруулсан болно. Технологийн хэрэглээ нь энэ хичээлийн салшгүй хэсэг юм. *Алгебр II хичээлийн төгсгөлд ерөнхий боловсролын шалгалтыг Холбооны шаардлагыг хангахын тулд өгөх хэрэгтэй байдаг бөгөөд төгсөхөд шаардлагтай математикийн кредитийг авдаг.*

Алгебр III(23155)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд:9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Алгебр II-ийн хичээл дээр "A" дүн,болон багийн тодорхойлолт; Алгебрийн II-т "C" буюу түүнээс дээш эсвэл Алгебр II-н Түргэвчилсэн сургалттай хичээлд "D" буюу түүнээс дээш ба багийн тодорхойлолт,геометрийн хичээл дээр "B" дүн ба багийн тодорхойлолт

Энэхүү хичээл нь тригонометр ба гүнзгийрүүлсэн алгебрийн сэдвүүдийг нарийвчлан заах болно. Энэ тригонометрийн 12-18 долоо хоногийн хичээлэнд гурвалжин ба нэгжийн тойргийн тригонометр ба тригонометрийн функцууд ба тэдгээрийн хэрэглээг багтаах болно. Алгебрын AP хөтөлбөрийн сэдвүүдэд өмнөх алгебрын мэдлэгийн өргөтгөл,экспоненциал ба логарифм функц гэх мэт хичээл орох болно. Нэмэлт сэдвүүдэд магадлал,дараалал ба цуврал,салангид математик орно. Технологийн хэрэглээ нь энэ хичээлийн салшгүй хэсэг юм.

Алгебр II-ийн стратеги (23126)

Бүтэн жил, нэг сонгох кредит

Орох ангиуд:9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Алгебр II-ийн стратеги хичээл нь Алгебрийн II-д нэмэлт дэмжлэг хэрэгтэй байгаа сурагчдад зориулсан сонгон суралцах хичээл юм. Элссэн сурагчид суурь мэдлэгийг дээшлүүлж,агуулгын талаар илүү ойлгомжтой аргаар сурч,үндсэн хичээлийн агуулгыг илүү нарийн үзэх болно. Энэ хичээлд орохын тулд Алгебр II (23135)-д элссэн байх шаардлагатай.

Геометр (23143)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд:9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Алгебр I болон,Алгебр I түргэвчилсэн сургалттай мөн Алгебр I-ийн II бүлэгт "C" буюу түүнээс дээш үнэлгээтэй байх

Геометр нь сурагчдад математикийн бүтцийг дедуктив үндэслэл,шууд ба шууд бус нотолгоог ашиглах замаар заан сургадаг. Энэ хичээл нь тойрог,олон өнцөгт,хатуу биетийн хувиргалт,конгруэнт чанар,параллелизм,ижил төстэй байдал ба перпендикуляр байдлын шинж чанаруудыг заах болно. Алгебр I сэдвүүдийг тоймлон оруулж,геометрт хавсарган бодох зорилгоор ашигладаг. Геометрийн хичээлийн төгсгөлд ерөнхий боловсролын шалгалтыг Холбооны шаардлагыг хангахын тулд өгөх хэрэгтэй байдаг бөгөөд төгсөхөд шаардлагтай математикийн кредитийг авдаг.

Геометр түргэвчилсэн сургалттай (23141)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд:9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Дунд сургуулийн түргэвчилсэн сургалттай алгебр I хичээлд "B" буюу түүнээс дээш үнэлгээ,эсвэл ахлах сургуулийн алгебр I хичээлийн "A" үнэлгээ болон багшийн тодорхойлолт

Түргэвчилсэн сургалттай геометр нь хавтгай ба хатуу дүрс,Алгебр I-ийн ойлголтуудыг ашиглан логик үндэслэлийг нарийвчлан сурах хичээл юм. Сурагчид шууд болон шууд бус,координатын нотолгоог ашиглан онолын хүрээнд дедуктив сэтгэлгээг харуулах ёстой. Энэхүү хичээл нь анги дэвшүүлэх хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй сурагчдад зориулагдсан болно. *Геометрийн хичээлийн төгсгөлд ерөнхий боловсролын шалгалтыг Холбооны шаардлагыг хангахын тулд өгөх хэрэгтэй байдаг бөгөөд төгсөхөд шаардлагтай математикийн кредитийг авдаг.*

Геометрийн зарчим (23142)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд:9-12

Элсэхийн өмнөх шаардлага:Алгебр I эсвэл Алгебрын I-ийн бүлэг II хичээлд "C" буюу түүнээс дээш үнэлгээ,эсвэл сурагч хоёр дахь удаагаа төгсөж,тэнцсэн бол Алгебр I,Алгебр I –ийн бүлэг II хичээлд "D" буюу түүнээс дээш үнэлгээ

Геометрийн зарчмууд нь сурагчдад геометрийг хэрэглээгээр дамжуулан харах боломжийг олгох зорилготой хичээл юм. Математикийн нэгдмэл байдлыг геометрийн зарчмуудыг боловсруулахад алгебрийг ашиглаж болох замаар харуулах болно. Энэ хичээлд өнцөг, конгруэнт чанар, ижил төстэй байдал,параллелизм, гурвалжин, хувиргалт, дөрвөн өнцөгт, тойрог зэрэг сэдвүүдийг багтаасан болно. Зохицуулалт болон дедуктив нотолгоонд Элсэхийн өмнөх шаардлага нь ердийн геометрийнхээс бага байдаг. *Геометрийн хичээлийн төгсгөлд ерөнхий боловсролын шалгалтыг Холбооны шаардлагыг хангахын тулд өгөх хэрэгтэй байдаг бөгөөд төгсөхөд шаардлагтай математикийн кредитийг авдаг.*

Геометрийн стратеги (23128)

Бүтэн жил, нэг сонгох кредит

Орох ангиуд:9-12

Элсэхийн өмнөх шаардлага:Байхгүй.

Геометрийн стратеги хичээл нь Геометрийн хичээлд нэмэлт дэмжлэг хэрэгтэй байгаа сурагчдад зориулсан сонгон суралцах хичээл юм Элссэн сурагчид суурь мэдлэгийг дээшлүүлж,агуулгын талаар илүү ойлгомжтой аргаар сурч,үндсэн хичээлийн агуулгыг илүү нарийн үзэх болно. Энэ хичээлд орохын тулд Геометр (23143) эсвэл Геометрийн зарчим (23142)-д элссэн байх шаардлагатай.

Бие даасан боловсролын хөтөлбөр (RISE) алгебр (20203) (RISE) Геометр (20204)

Нэг улирал,хагас сонгох кредит

Орох ангиуд:11-12

Элсэхийн өмнөх шаардлага:Сурагчид харгалзах ангидаа тэнцсэн боловч ерөнхий боловсролын шалгалтандаа тэнцээгүй тул төгсөхөд шаардлагатай кредит дутсан байх.

Сурагчид ангидаа тэнцсэн боловч ерөнхий боловсролын шалгалтандаа тэнцээгүй хичээлдээ сургалтын програм эсвэл онлайн програм ашиглан бие даалт/засах ажил гүйцэтгэдэг. Хийх бие даалтыг багшийн туслалцаатайгаар хийж болох ч бие даалтын ихэнх хувийг сурагч бие даан хийсэн байх ёстой. Дүн засаж болох хичээлүүд дотор англи хэл (бичих),англи хэл, унших/уран зохиол,судалгаа), Алгебр I,Геометр, Биологи, Байгалын шинжлэх ухаан,Дэлхийн газар зүй,Дэлхийн түүх.

Тайлбар: Сурагчид энэ ангид тэнцсэн/тэнцээгүй гэсэн үндэслэлээр орно.

Анхан шатны анализ/тригонометр (23162)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд:11-12

Элсэхийн өмнөх шаардлага:Алгебр III хичээл дээр "C" буюу түүнээс дээш үнэлгээ;Алгебр II түргэвчилсэн сургалттай хичээл эсвэл Алгебр II-т "A" үнэлгээ болон багшийн тодорхойлолт

Энэхүү хичээл нь олон гишүүнт, шугаман, экспоненциал, логарифм, тригонометр гэх мэт үндсэн функцуудын нэгдсэн тоймоос бүрдэнэ. Бусад томоохон сэдвүүдэнд нь аналитик геометр, параметрийн тэгшитгэл,туйлын координат, дараалал, салангид математик, вектор, матриц, хязгаар ба уламжлалын танилцуулга орох болно. Технологийн хэрэглээ нь энэ хичээлийн салшгүй хэсэг юм.

Анхан шатны анализ,түргэвчилсэн сургалттай (23164)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 10-12

Элсэхийн өмнөх шаардлага:Алгебр II/Тригонометрийн түргэвчилсэн сургалттай хичээлд "B" буюу түүнээс дээш үнэлгээ,болон багшийн Тодорхойлолт эсвэл Алгебр III-ийн "A" үнэлгээ, багшийн Тодорхойлолт .

Энэхүү хичээл сурагчдад анхан шатны анализ (23162)-тай ижил сэдвийн хичээл орох бөгөөд материалыг илүү гүнзгий авч,хийсвэр ойлголт,математикийн бүтцэд илүү анхаарч заах болно. Энэ хичээл нь сурагчдад дараа жил нь анализыг сурахад шаардагдах ур чадвар,ойлголтыг өгдөг. Мөн дараахь сэдвүүдийг нэмэх магадлалтай: вектор, огторгуйн геометр ба хавтгайн аналитик геометр, хавтгайн хувиргалт, дарааллын хязгаар, бодит тоон системийн бүрэн бүтэн байдал. Технологийн хэрэглээ нь энэ хичээлийн салшгүй хэсэг юм.

Магадлал ба статистик (23190)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 10-12

Элсэхийн өмнөх шаардлага: Алгебр II эсвэл Алгебр II-ийн түргэвчилсэн сургалттай хичээлд "C" буюу түүнээс дээш үнэлгээ.

Энэхүү хичээл нь орчин үеийн статистик, магадлалын талаар заах болно. Сурагчид магадлалын үндсэн санаануудыг сурч, үүгээрээ хичээлийн дараагийн хэсэгт статистикийг боловсруулахад ашиглах болно. Статистикийн хичээлд статистик график байгуулах, тайлбарлах, төв хандлага ба хэлбэлзлийн хэмжүүр, түүвэрлэх арга, хоёр гишүүнтэй ба хэвийн тархалт, таамаглалыг шалгах, интервал, бууралт, корреляц, магадлал, гэх мэт сэдвүүдийг оруулсан байх болно. Магадлалын туршилтыг дууриах, статистик ойлголтыг дүрслэн үзүүлэх, статистик шинжилгээ хийхэд компьютер ашиглах боломжтой.

Статистик, Гүнзгийрүүлсэн (33192)

Бүтэн жил, нэг кредит +1.0 чанарын оноо

Орох ангиуд: 11-12

Элсэхийн өмнөх шаардлага: Алгебр II, Алгебр II Түргэвчилсэн сургалттай эсвэл Алгебр III хичээл дээр "B" буюу түүнээс дээш үнэлгээ, багийн Тодорхойлолт

Математикийг гүнзгийрүүлэн сурж буй сурагчдад коллежийн элсэлтийн шалгалтын зөвлөлөөс өгсөн гүнзгийрүүлсэн статистикийн хөтөлбөрт орсон сэдвүүдийг судлах боломжийг энэ хичээлээр олгож байна. Энэ хичээлийн сэдвүүдэд нь магадлал ба магадлалын тархалтыг судлах, төвийн чиг хандлага ба тархалтын хэмжигдэхүүн, санамсаргүй тоо ба симуляци, интервал, нэг ба хоёр түүврийн өгөгдлийн таамаглалыг шалгах, хүснэгт, корреляци, бууралтын задаргаа зэрэг тодорхой статистикийг сурдаг. Өгөгдөлд дүн шинжилгээг технологи, компьютерийн програм хангамжийг хэрэглэн гүйцэтгэдэг. *Сурагчид энэ хичээлтэй холбоотой Гүнзгийрүүлсэн шалгалт өгөх шаардлагатай. Шалгалтанд ороогүй сурагчид чанарын оноо авахгүй. (23192)*

Анализ АВ, Гүнзгийрүүлсэн (33177)

Бүтэн жил, нэг кредит, +1.0 чанарын оноо

Орох ангиуд: 10-12

Элсэхийн өмнөх шаардлага: Анхан шатны анализ түргэвчилсэн сургалттай хичээл дээр "C" буюу түүнээс дээш үнэлгээ, болон багийн тодорхойлолт; Анхан шатны анализ хичээл дээр "B" буюу түүнээс дээш үнэлгээ ба багийн тодорхойлолт

Энэ хичээлд задлах шинжлэх талаар сурахад шаардлагатай ба эдгээр сэдвүүдийн тойм агуулгад: хязгаарын онол, дифференциал анализ ба түүний хэрэглээ; интеграл анализ ба түүний хэрэглээ, асуудлыг анализ ашиглан шийдвэрлэх; болон Коллежийн элсэлтийн шалгалтын зөвлөлөөс өгсөн гүнзгийрүүлсэн анализ АВ хөтөлбөрт орсон сэдвүүдийг заах болно. *Сурагчид энэ хичээлтэй холбоотой Гүнзгийрүүлсэн шалгалт өгөх шаардлагатай. Шалгалтанд ороогүй сурагчид чанарын оноо авахгүй. (23177)*

Анализ ВС, Гүнзгийрүүлсэн (33179)

Бүтэн жил, нэг кредит, +1.0 чанарын оноо

Орох ангиуд: 10-12

Элсэхийн өмнөх шаардлага: Анхан шатны анализ түргэвчилсэн сургалттай хичээлд "B" буюу түүнээс дээш үнэлгээ, болон багийн тодорхойлолт, эсвэл Анхан шатны анализ хичээлд "A" буюу түүнээс дээш үнэлгээ, болон багийн Тодорхойлолт

Анализ АВ-ийн сэдвүүдээс гадна векторын функцууд, туйлын талбар, хэмжээ, дараалал, цувралууд нэмж орох болно. Хязгаар, болон нотолгоонуудыг анализийн АВ-ээс илүү их ашиглах болно. Коллежийн элсэлтийн шалгалтын зөвлөлөөс гаргасан анализ ВС хөтөлбөрөөс дэлгэрэнгүй мэдээллийг олж болно. *Сурагчид энэ хичээлтэй холбоотой Гүнзгийрүүлсэн шалгалт өгөх шаардлагатай. Шалгалтанд ороогүй сурагчид чанарын оноо авахгүй. (23179)*

Дараах давхар элсэх хичээлийг зарим нөхцөлд бие даан суралцах, онлайн сургалтаар заах болно. Дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.

Олон хувьсах анализ (93178W)

Бүтэн жил, нэг кредит, +1.0 чанарын оноо

Орох ангиуд: 10-12

Элсэхийн өмнөх шаардлага: Анализ ВС-г амжилттай төгсөж, Хойд Виржиниа ерөнхий боловсролын коллежийн Хос элсэлтийн бүх шаардлагыг хангасан байх ёстой.

Олон хувьсах анализийг төгсөх ангиасаа өмнө Анализ ВС үзэж дуусгасан сурагчдад зориулж орох болно. Хичээлд үзэх зарим сэдвүүд нь гурван хэмжээст гадаргуугийн график зураглал, векторын функцуудын интегралчлал ба ялгаа, хоёр ба түүнээс дээш хувьсагчийн функцын хязгаар ба тасралтгүй байдал, хэсэгчилсэн дериватив, олон интеграл, вектор талбар, Грийны теорем, болон Стокийн теорем байх болно.

- **Коллежийн кредит:** Энэ хичээлд Хойд Виржиниагийн ерөнхий боловсролын коллежид давхар элсэж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүйг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.

Векторын анализ (93175W)

Нэг улирал,хагас кредит,+1.0 чанарын оноо

Орох ангиуд: 12

Элсэхийн өмнөх шаардлага: Анализ ВС-г амжилттай төгсөж,Хойд Виржиниа ерөнхий боловсролын коллежийн Хос элсэлтийн бүх шаардлагыг хангасан байх ёстой.

Векторын анализийг төгсөх ангиасаа өмнө Анализ ВС үзэж дуусгасан сурагчдад зориулж орох болно. Хичээлд үзэх зарим сэдвүүд нь гурван хэмжээст гадаргуугийн график зураглал,векторын функцуудын интегралчлал ба ялгаа,хоёр ба түүнээс дээш хувьсагчийн функцуудийн хязгаар ба тасралтгүй байдал,хэсэгчилсэн дериватив,олон интеграл,чиглэлтэй уламжлал ба градиент,векторын талбар,Грийны теорем байх болно. Энэ хичээлийг зөвхөн онлайннар бие даан суралцах замаар үзэх болно гэдгийг анхаарна уу.

- **Коллежийн кредит:** Энэ хичээлд Хойд Виржиниагийн ерөнхий боловсролын коллежид давхар элсэж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүйг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.

Шугаман алгебр (93165W)

Нэг улирал,хагас кредит,+1.0 чанарын оноо

Орох ангиуд: 12

Элсэхийн өмнөх шаардлага: Анализ ВС-г амжилттай төгсөж,Хойд Виржиниа ерөнхий боловсролын коллежийн Хос элсэлтийн бүх шаардлагыг хангасан байх ёстой.

Шугаман алгебрыг төгсөх ангиасаа өмнө Анализ ВС үзэж дуусгасан сурагчдад зориулж орох болно. Сурагчид шугаман тэгшитгэлийн систем,вектор огторгуй,шугаман хувиргалт,өвөрмөц утгын талаар сурах болно. Энэхүү хичээл нь сурагчидын тоон үндэслэлийг сайжруулж,дедуктив бодох чадварыг хөгжүүлэх болно. Энэ хичээлийг зөвхөн онлайннар бие даан суралцах замаар үзэх болно гэдгийг анхаарна уу.

- **Коллежийн кредит:** Энэ хичээлд Хойд Виржиниагийн ерөнхий боловсролын коллежид давхар элсэж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүйг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.

Дифференциал тэгшитгэл (93180W)

Нэг улирал,хагас кредит,+1.0 чанарын оноо

Орох ангиуд: 12

Элсэхийн өмнөх шаардлага: Анализ ВС-г амжилттай төгсөж,Хойд Виржиниа ерөнхий боловсролын коллежийн Хос элсэлтийн бүх шаардлагыг хангасан байх ёстой.

Дифференциал тэгшитгэлийг төгсөх ангиасаа өмнө Анализ ВС үзэж дуусгасан сурагчдад зориулж орох болно. Энэхүү хичээл нь эрэмбийн дифференциал тэгшитгэл,шугаман дифференциал тэгшитгэл,тоон арга,хэрэглээний талаар заах болно. Хичээлийн авч үзэх зарим сэдвүүд нь эрэмбийн дифференциал тэгшитгэл,тогтмол коэффициенттэй нэгэн төрлийн ба нэг төрлийн бус шугаман дифференциал тэгшитгэл,өвөрмөц утгыг ашиглан шугаман дифференциал тэгшитгэлийг шийдвэрлэх талаар байх болно. Энэ

хичээлийг зөвхөн онлайннар бие даан суралцах замаар үзэх болно гэдгийг анхаарна уу.

- **Коллежийн кредит:** Энэ хичээлд Хойд Виржиниагийн ерөнхий боловсролын коллежид давхар элсэж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүйг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.

Тоон анализ (93167W)

Бүтэн жил, нэг кредит,+1.0 чанарын оноо

Орох ангиуд: 11-12


Элсэхийн өмнөх шаардлага: NOVA шалгалтанд тэнцэх оноо;Алгебр I,Геометр,Функц болон өгөдлийн задаргаа,эсвэл Алгебр II-ийн "C" буюу түүнээс дээш үнэлгээ.

Энэхүү давхар элсэх хичээл нь пропорциональ үндэслэл,загварчлал,санхүүгийн мэдлэг,хүчин төгөлдөр байдлын судалгаа (логик ба олонлогийн онол) сэдвүүдийн талаар заах болно. Бодит нөхцөл байдлыг тодорхойлж,асуудлыг математикийн өгөгдөл болгон хувиргаж,түүнийгээ шийдвэрлэж,хариуг нь анхны нөхцөл байдалд хэрэгжүүлэх үйл явцад энэ хичээл анхаардаг.

- **Коллежийн кредит:** Энэ хичээлд Хойд Виржиниагийн ерөнхий боловсролын коллежид давхар элсэж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүйг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.

Арлингтон ерөнхий боловсролын сургуулийн математикийн сурах схем зураг Алгебр I ба түүнээс дээш

Сурагчид Алгебрийн I хичээлд хамрагдахдаа (өөр түвшинд явагдах болно) эдгээр замаар сурах болно. Бэлэн байдлаас шалтгаалан сурагчид сурч болох олон зам, хичээл байдаг. Тавигдах шаардлагын талаар хичээлийн тодорхойлолтноос үзнэ үү.



For specific IB and Dual Enrolled courses not mentioned here, please see the index of courses offered at individual high schools. Students needing additional support may be concurrently enrolled in Algebra I, Geometry, or Algebra II and a Strategies course.

*AFDA may be taken after Algebra I and before Geometry OR after Geometry and before Algebra II in high school only.

8-р анги Математикт үндэслэн коллежийн кредитэд хүрэх сонголтууд

(9-р ангидаа математикийн түргэвчилсэн сургалттай хичээлд хамрагдаагүй сурагчдад зориулсан)

8-р анги	9-р анги	10-р анги	11-р анги	12-р анги
8-р ангийн анхан шатны алгебр	Алгебр I	Геометр	Алгебр II	<i>Тоон анализ*</i> эсвэл <i>Статистик, Гүнзгийрүүлсэн **</i>
8-р ангийн анхан шатны алгебр	Алгебр I (9-р ангийн зун геометр)	Алгебр II	Анхан шатны анализ/ тригонометр***	<i>Анализ АВ эсвэл Тоон анализ эсвэл Статистик, Гүнзгийрүүлсэн</i>
Алгебр I (эсвэл Алгебр I түргэвчилсэн сургалттай)	Геометр	Алгебр II	Анхан шатны анализ/ тригонометр***	<i>Анализ АВ эсвэл Тоон анализ эсвэл Статистик, Гүнзгий рүүлсэн</i>
Алгебр I (эсвэл Алгебр I түргэвчилсэн сургалттай)	Геометр	Алгебр II	Алгебр III	<i>Тоон анализ* эсвэл Статистик, Гүнзгийрүүлсэн</i>
Геометр түргэвчилсэн сургалттай	Алгебр II	Анхан шатны анализ/ тригонометр***	<i>Анализ АВ эсвэл Статистик, Гүнзгийрүүлсэн</i>	<i>Анализ ВС эсвэл Статистик, Гүнзгийрүүлсэн</i>

* Тоон дүн анализид хамрагдахын тулд сурагч шалгуурыг хангасан байх ёстой. Энэ бол NVCC-тэй хосоор элсэх хичээл бөгөөд дүн нь NVCC-ийн хуулбар дээр тавигдах болно

** Алгебр II-ийн дараахь AP статистикт хамрагдахын тулд сурагчид Алгебр II-д B ба түүнээс дээш үнэлгээтэй байх шаардлагатай

*** Алгебр II-ийн дараахь Анхан шатны анализ/тригонометрийн хичээлд хамрагдахын тулд сурагчид Алгебр II-ийн A ба түүнээс дээш үнэлгээтэй байх болон багшийн тодорхойлолттой байх шаардлагатай.

(9-р ангидаа математикийн түргэвчилсэн сургалттай хичээлд хамрагдсан сурагчдад зориулсан)

8-р анги	9-р анги	10-р анги	11-р анги	12-р анги
Алгебр I түргэвчилсэн сургалттай	Геометр түргэвчилсэн сургалттай	Алгебр II/Тригонометр, Түргэвчилсэн сургалттай	Анхан шатны анализ, түргэвчилсэн сургалттай	<i>Анализ АВ эсвэл Анализ ВС эсвэл Статистик, Гүнзгийрүүлсэн</i>
Геометр түргэвчилсэн сургалттай	Алгебр II/Тригонометр, Түргэвчилсэн сургалттай	Анхан шатны анализ, түргэвчилсэн сургалттай	<i>Анализ ВС</i>	<i>Олон хувьсах анализ эсвэл Векторын анализ, Шугаман алгебр Эсвэл Статистик, Гүнзгийрүүлсэн</i>
Геометр түргэвчилсэн сургалттай	Алгебр II/Тригонометр, Түргэвчилсэн сургалттай	Анхан шатны анализ, түргэвчилсэн сургалттай	<i>Анализ АВ эсвэл Статистик, Гүнзгийрүүлсэн</i>	<i>Анализ ВС эсвэл Статистик, Гүнзгийрүүлсэн</i>

ШИНЖЛЭХ УХААН

Арлингтон хотын ерөнхий боловсрол сургуулиуд нь шинжлэх ухааны цогц хөтөлбөрийг заахаар зорьж байна. Шинжлэх ухааны хамгийн тохиромжтой сургалтын хөтөлбөр нь бүх сурагчдыг хамардаг байх бөгөөд эдгээр сурагчдад шинжлэх ухааны өндөр сонирхол,ур чадварыг эзэмшүүлдэг юм.

Шинжлэх ухааны олон салбаруудыг бүх сурагчдад сурах боломжтой байлгах болно. Мөн түргэвчилсэн шинжлэх ухааны хичээл, болон дэвшилтэт хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр шинжлэх ухааныг гүнзгийрүүлэн сурах болно.

Шинжлэх ухааны түргэвчилсэн сургалттай хичээл болон дэвшилтэт хөтөлбөрүүдийн дараагийн хичээлд сурахын тулд тавигдах шаардлагыг хангасан байх ёстойг анхаарна уу.

Тайлбар: 15-аас цөөн сурагчтай хичээлийг сурагчдын сонирхол,төсвийн асуудлаас шалтгаалан орохгүй байх боломжтой. Зарим тохиолдолд төсвийн асуудлаас шалтгаалан тухайн жилд хичээл орохгүй байх магадлалтай бөгөөд энэ хичээлийн сурагчид нь өөр хичээл сонгох хэрэгтэй. Мөн сурагчдын тоо хангалтгүй хичээл нь зайнаас буюу онлайнаар хичээл орох магадлалтай болох юм.

Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр Биологи (24317) Лабораторийн хичээл
Бүтэн жил, нэг кредит
Орох ангиуд: 10-12

Элсэхийн өмнөх шаардлага: Англи хэлний түвшинд үндэслэн хуваарилна

Энэхүү хичээл нь эс,ургамал,амьтан,хүний биологийн анхан шатны мэдлэгийг заах болно. Сурагчид лабораторийн судалгаа,сурах бичгийн материал ашиглан бие даан,хамтран сурах болно.

Хичээлийн төгсгөлд ерөнхий боловсролын шалгалт авах болно. Ерөнхий боловсролын шалгалтыг амжилттай өгснөөр хичээлийн кредит цаг тооцуулна.

Биологи (24310) Лабораторийн хичээл
Бүтэн жил, нэг кредит
Орох ангиуд:9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Байхгүй.

Энэхүү хичээл нь өдөр тутмын амьдралд хамааралтай биологийн мэдлэгийг заах болно. Хичээлийн агуулгад шинжлэх ухааны янз бүрийн арга ашиглан эс, микробиологи, ургамал, амьтан,генетик, физиологи, экологийг сурах болно. Сэтгэн бодох чадварыг лабораторийн хичээлээр сайжруулан хөгжүүлдэг. Янз бүрийн чадвартай сурагчдыг хөгжүүлэх, урамшуулах зорилгоор олон төрлийн нэмэлт материалыг ашигладаг. *Хичээлийн төгсгөлд ерөнхий боловсролын шалгалт авдаг. Ерөнхий боловсролын шалгалтыг амжилттай өгснөөр хичээлийн кредит цаг тооцуулна.*

Түргэвчилсэн сургалттай биологи (24315) Лабораторийн хичээл
Бүтэн жил, нэг кредит
Орох ангиуд:9

Энэхүү хичээл нь сурагчдыг биологийн чиглэлээр коллежийн түвшинд бэлтгэх зорилготой юм. Энэ хичээлд молекул биологи,цитологи,генетик,эсийн физиологи,экологи гэх мэт сэдвүүд орох болно. Лабораторийн ажиллагаа,туршилт,дүн шинжилгээг энэ хичээлд онцлон сурах болно. Мөн сурагчид бие даан туршилтын эсвэл инженерийн ажил хийх болно. *Хичээлийн төгсгөлд ерөнхий боловсролын шалгалт авдаг. Ерөнхий боловсролын шалгалтыг амжилттай өгснөөр хичээлийн кредит цаг тооцуулна.*

Гүнзгийрүүлсэн Биологи (34370) Лабораторийн хичээл
Бүтэн жил, нэг кредит ,кредит авах болон гүнзгийрүүлсэн шалгалт амжилттай өгсөний дараа +1.0 чанарын оноо,хичээлийн 2 цаг,(34371) хичээлтэй зэрэгцэн элсэнэ
Орох ангиуд:11-12

Элсэхийн өмнөх шаардлага:Шинжлэх ухааны эрчимжүүлсэн хөтөлбөрийг төгсөх эсвэл биологи,химийн чиглэлээр амжилттай төгсөх,багшийн тодорхойлолт.

Гүнзгийрүүлсэн биологи нь коллежийн түвшний биологийн хичээл бөгөөд сурагчдад биологийн бүхий л үндсэн сэдвийг нарийвчлан заах болно. Хичээлийн тоймыг коллежийн элсэлтийн шалгалтын зөвлөлөөс хийсэн судалгаан дээр үндэслэн боловсруулсан. Энэ хичээл нь сурагчиддаа коллежийн кредит өгдөг гүнзгийрүүлсэн биологийн шалгалтанд бэлдэхэд тусалдаг. Хичээлийн агуулга нь молекул олон эсүүд,удамшил ба эволюци,организм ба популяци гэсэн гурван үндсэн сэдэв байх болно. Лабораторийн үйл ажиллагааг гүнзгийрүүлсэн биологийн хөтөлбөрийн шаардлагын дагуу хийх болно. *Сурагчид гүнзгийрүүлсэн шалгалтанд хамрагдах хоёр хичээлийн шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалтыг өгөөгүй сурагчид аль ч хичээлийн чанарын оноог нэмж авахгүй. (24370) (24371)*

Биологийн сонгож үзэх сэдвүүд (34371)
Бүтэн жил, нэг кредит,хичээлийн 2 цаг
Орох ангиуд:11-12

Элсэхийн өмнөх шаардлага:Гүнзгийрүүлсэн биологийн ангид зэрэг элсэх (34370)

Лабораторийн туршлага нь энэ хичээлийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Сонгох боломжтой биологийн лабораторийн сэдвүүдэд тархалт ба осмос, ферментчлэл, эсийн хуваагдал ба мейоз, ургамлын пигмент ба фотосинтез,эсийн амьсгал, молекул биологи,организмын генетик, популяцийн генетик ба эволюци, цусны эргэлтийн системийн физиологи, амьтны зан байдал, ууссан хүчилтөрөгч зэрэг орох болно.

Экологи (24365)
Бүтэн жил, нэг кредит
Орох ангиуд:11-12

Элсэхийн өмнөх шаардлага:Биологийн хичээлийг амжилттай дүүргэх.

Энэхүү хичээл нь организм ба хүрээлэн буй орчны хоорондын биологийн холбоо,харилцан үйлчлэлийн талаар орох болно. Сэдвүүд нь экосистемийн амьд ба амьд бус бүрэлдэхүүн хэсгүүдийн бодис,энергийн урсгал,геохимийн процесс (нүүрстөрөгч, азот, фосфор, хүчилтөрөгчийн мөчлөг), амьдралд чухал шаардлагатай химийн ба биохимийн процессууд, усны амьдралд нөлөөлөх процесс байх болно.

Байгаль орчны шинжлэх ухаан (24361)
Бүтэн жил, нэг кредит
Орох ангиуд:9-12

Элсэхийн өмнөх шаардлага:Байхгүй.

Энэ бол хүрээлэн буй орчин,хүмүүсийн дэлхийд үзүүлж буй нөлөөлөлд анхаарсан салбар дундын хичээл юм. Хичээлийн сэдэв нь шинжлэх ухааны судалгаа,биет ертөнц,амьдрах орчин,нөөцийн хэмнэлт, хуулийн болон иргэний хариуцлага гэсэн агуулга багтана. Лабораторийн болон,практик туршлага нь энэхүү хичээлийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд энэ нь хичээлийн агуулгыг баяжуулах болно. Энэ хичээлийг Биологи эсвэл Дэлхийн Шинжлэх ухааны кредит гэж тооцож болно.

Англи хэлийг хөгжлүүлэх хөтөлбөр Байгаль орчны шинжлэх ухаан (24362)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 9-12

Элсэхийн өмнөх шаардлага: Англи хэлний түвшинд үндэслэн хуваарилна.

Энэ хичээл нь хүрээлэн буй орчны шинжлэх ухааны чухал сэдвүүдийг танилцуулах болно. Хичээлийн сэдэв нь шинжлэх ухааны судалгаа, биет ертөнц, амьдрах орчин, нөөцийн хэмнэлт, хуулийн болон иргэний хариуцлага зэрэг байх болно. Лабораторийн болон практик туршлага нь энэхүү хичээлийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд энэ нь хичээлийн агуулгыг баяжуулах болно. Энэ хичээлийг Биологи эсвэл Дэлхийн Шинжлэх ухааны кредит гэж тооцож болно.

Хими (24410) Лабораторийн хичээл

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 10-12

Элсэхийн өмнөх шаардлага: Алгебр I эсвэл түүнтэй адилтгах түвшний хичээлийг дүүргэсэн байх.

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 10-11

Элсэхээс өмнөх шаардлага: Байхгүй.

Сурагчдад хууль эрх зүйн үндэс, үйл явц, эрүүгийн эрх зүйн тогтолцооны хүрээнд ажил мэргэжлийг судлах зарчим, арга барил, дадлын талаар танилцуулна.

Эрүүгийн шүүх II (28703)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 11-12

Элсэхээс өмнөх шаардлага: Эрүүгийн шүүх I (28702)

Сурагчид хууль эрх зүйн үндэс, үйл явц, эрүүгийн эрх зүйн тогтолцооны хүрээнд карьераа судлах зарчим, дадал, АНУ дахь терроризмын түүхийг зааж сургана. Сурагчид хичээлийн жилийн туршид танхимын болон зааварчилгаа хослуулсан хяналттай практик туршлагаар суралцана.

Мэдээллийн технологийн танилцуулга (26116) (96116W)

Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо

Орох ангиуд: 9-12

Элсэхээс өмнөх шаардлага: Байхгүй.

Тус хичээл нь компьютер, сүлжээ, вэбэд суурилсан програм, програмчлалыг сонирхдог бүх Сурагчдад зориулсан суурь хичээл юм. Мэдээллийн технологи (МТ) эсвэл Кибер аюулгүй байдлын мэргэжлийг сонирхож, гэрийн компьютерийн сүлжээг бий болгох, эсвэл компьютер хэрхэн ажилладаг талаар суралцахыг хүсч буй сурагчид энэ сургалтанд хамрагдаж болно. Гэрийн компьютерийн сүлжээний тохиргоо, хувийн

болон бизнесийн үйл ажиллагаанд хэрэглэгддэг компьютерийн шийдлүүд зэргийг хөтөлбөрөөр суралцана. Сурагчид мөн салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн гэрчилгээ авахад бэлтгэгдэх боломжтой. Зөвшөөрөгдсөн сурагчид Хос элсэлтийн кредит авах боломжтой.

- *Коллежийн кредит: Хойд Виржиниа мужийн Нийтийн коллежид Тус хичээлийг давхар суралцаж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.*

Компьютерийн програмчлал (26638) (96638W)

Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Хос элсэлтийн хувьд: Алгебр II хичээлийг дүүргэсэн, Анхан шатны анализ DE хичээлд одоо суралцаж байгаа болон NOVA-гийн Математикийн Анхан шатны анализын шалгалтад тэнцсэн.

Элсэхээс өмнөх шаардлага: Хос бус элсэлтийн хувьд: Алгебр I хичээлийг амжилттай дүүргэсэн байх.

Сурагчид JAVA, Python програмчлалын хэлийг програм хангамжийг нээлттэй эх үүсвэр эсвэл Windows орчинд кодлох, хөрвүүлэхэд ашиглаж сурна. Хичээлийн агуулгад хөтөлбөрийн зураг төсөл боловсруулах, асуудал шийдвэрлэх, бүтцийн хяналт, функц, параметр дамжуулах, өгөгдлийн бүтэц, матриц, файл боловсруулах зэрэг орно. Хөтөлбөрийн дизайн дээр гол анхаарлаа хандуулж судалдаг.

- *Коллежийн кредит: Хойд Виржиниа мужийн Нийтийн коллежид Тус хичээлийг давхар суралцаж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.*

Компьютерийн Түргэвчилсэн хөтөлбөртэй програмчлал (96644W) (26637)

Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Хос элсэлтийн хувьд: Компьютерын програмчлал DE болон Анхан шатны анализ хичээлийг амжилттай дүүргэсэн ба NOVA-ийн Анализ DE хичээлийн шалгалтыг өгсөн; Анализ DE хичээлд одоо суралцаж байгаа;

Энэхүү дамжаа нь асуудлыг шийдвэрлэхэд компьютерын програмыг боловсруулан хөгжүүлэхэд төвлөрдөг. Сурагчид хөтөлбөрийн загварыг зохиох зарчмын талаар ойлголттой болж, ойлгомжтой, дасан зохицож, хувьсах чадамжтай, дахин ашиглах боломжтой програм бичих мэдлэгийг олж авах болно. Суралцагсад алгоритм боловсруулах, дүн шинжилгээ хийх, янз бүрийн програмчлалын хэл ашиглан үндсэн өгөгдлийн бүтцийг боловсруулах, ашиглах зэрэг компьютерийн шинжлэх ухааны бусад чухал ойлголт, протоколуудтай танилцах болно.

- *Коллежийн кредит: Хойд Виржиниа мужийн Нийтийн коллежид Тус хичээлийг давхар суралцаж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.*

Компьютерийн програмчлал, Ахисан түвшин (26643) (96643W)

Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Хос элсэлтийн хувьд: Компьютерийн Түргэвчилсэн хөтөлбөртэй програмчлал DE хичээлийг дүүргэсэн. Мөн Аналитик Геометрийн тоололол DE хичээлд суралцаж байх.

Элсэхээс өмнөх шаардлага: Хос бус элсэлтийн хувьд: Компьютерын програмчлал (26638) хичээлийг амжилттай дүүргэсэн байх.

Компьютерын ахисан түвшний програмчлал нь Програмчлалын ур чадварын үндэс дээр суурилдаг хичээл юм. Програмчлалын ахисан түвшний хичээлийн суралцагсад мэдээллийн баазын програмууд, тоглоомын програмууд, мобайл програмууд, вэб програмууд зэрэг интерактив мультимедиа програмуудыг хөгжүүлэхэд объектод чиглэсэн програмчлалын ойлголтууд, оролт гаралтын хяналтын бүтэц, функцууд ба арга хэрэглүүрүүд, өгөгдлийн хийсвэрлэл, өгөгдлийн бүтцийг ашиглаж сурна. Сургалтаар компьютерийн сүлжээний архитектур, компьютерийн техник хангамжийн үйл ажиллагаа, түүний дотор сүлжээ ба үйлдлийн систем, өгөгдлийн зохион байгуулалт, алгоритм, програм хангамжийн инженерийн талаар ярилцана. Мэдээллийн технологи, компьютерийн шинжлэх ухааны салбарт тасралтгүй боловсрол эзэмшиж, карьерынхаа замыг судалж, карьераа хөгжүүлэх олон төрлийн боломжтой тул сурагчид хөдөлмөр эрхлэх чадвараа үргэлжлүүлэн хөгжүүлсээр байна.

- *Коллежийн кредит: Хойд Виржиниа мужийн Нийтийн коллежид Тус хичээлийг давхар суралцаж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.*

Тогтвортой ба сэргээгдэх технологийн дараалал: 28512 ба 28460. Хоёр хичээлд зэрэг хамрагдсан байх ёстой.

Барилгын технологи (28512)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 9-12

Элсэхээс өмнөх шаардлага: Тогтвортой ба сэргээгдэх технологи (28460) хичээлд зэрэг суралцаж байх ёстой.

Энэ дамжаанд сурагчид архитектор, барилгын инженер, мужаан, цахилгаанчин, сантехникч, маркшейдер, гүйцэтгэгч, өрлөгчин, барилга, хүрээлэн буй орчны менежмент гэх мэт ажлын байрыг судлах бүтэц, түүнтэй холбоотой бүтээлийн талаар суралцдаг. Сурагчид мужааны ур чадвараа хөгжүүлж, загварт байгууламж барих, талбайг төлөвлөх, барилга байгууламж, дэд бүтцийн төслүүдийг төлөвлөх, компьютерийн програм хангамж болон бусад ийм салбарт ашигладаг бусад зохих хэрэгслийг ашиглахад суралцдаг.

Тогтвортой ба сэргээгдэх технологи (28460)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 9-12

Элсэхээс өмнөх шаардлага: Барилгын технологи (28512) хичээлд зэрэг хамрагдаж байх ёстой.

Тус хичээл нь Сурагчдад дэлхий нийт, түүний ирээдүйд нөлөөлөх түүхэн, эдийн засаг, улс төр, байгаль орчин, соёлын асуудлуудын тухай ерөнхий ойлголт өгнө. Сурагчид хүрээлэн буй орчны эрүүл мэндэд нөлөөлөх асуудлуудыг шийдвэрлэж, тогтвортой хөдөө аж ахуй, эрчим хүчний хэмнэлттэй барилгын зураг төсөл, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс санал болгож буй шийдлүүдийг судлах болно. Материал судлал, сэргээгдэх эрчим хүчний систем, тогтвортой технологи, холбогдох салбаруудад анхаарлаа хандуулж бүтцийн загвар ба прототайп загварыг сурч, бүтээнгээ сурагчид мужааны ур чадвараа дээшлүүлэх болно. Сурагчид архитектур, архитектурын инженерчлэл, барилгын инженер, мужаан, цахилгаан, сантехник, халаалт, агааржуулагч, маркшейдер, гэрээний менежмент, өрлөг, барилгын инженер ба барилгын менежмент, байгаль орчны менежмент зэрэг чиглэлийн холбогдох ажлын байрнуудыг судлах болно. Сурагчид масштабын загвар байгууламжийг барьж, туршиж үзэх, талбайг бэлтгэх, барилга байгууламж, дэд бүтцийн төслүүдийг төлөвлөх, эдгээр карьеруудад ашигласан компьютерийн програм хангамж болон бусад зохих хэрэгслийг ашиглаж сурна.

Косметологи I (28528)

Бүтэн жил, хоёр кредит

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Байхгүй.

Косметологи I хичээл нь тусгай зөвшөөрөлтэй гоо сайханч болох сонирхолтой Сурагчдад зориулагдсан болно. Сурагчид мэргэшсэн гоо сайхны мэргэжилтэн байх онол, урлагийн өнгөрсөн үеийг судалж, өнөө үед дүн шинжилгээ хийж, гоо сайхны нийт үр дүнгээр дүгнүүлдэг. Сурагчид мэргэжлийн ёс зүй, бактериологи, анатоми/физиологи, үндсэн хими/тог цахилгаан, үс ба хуйхны шинж чанар, үс засах зарчим, шампунь/агааржуулагч, үс тайралт, Үсчин, нүүрний маск, маникюр, педикюр зэрэг чиглэлээр мэдлэг олж авдаг. Энэхүү хичээл нь сурагчдыг Косметологи II (28529) хичээлд хамрагдах шаардлагыг хангахуйц

түвшинд бэлтгэхэд зориулагдсан болно. Гоо сайхны иж бүрдлийг сурагчийн хэрэгцээнд зориулж өгдөг ч хүсвэл өөрсдөө худалдаж авч болно (ойролцоогоор 170 доллар орчим болно).

Косметологи II (28529)

Бүтэн жил, хоёр цагаар, хоёр кредит

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Косметологи I.

Сурагчид Косметологи I хичээлээс авсан мэдлэг дээрээ тулгуурлан гоо сайхны урлагт шинжлэх ухааны үүднээс суралцдаг. Сурагчид нэмэлт үсээр сүлжих, хиймэл үс хийх, тогтмол хими хийх, үс тайвшруулах химийн тайвшруулагч, зөөлөн буржгар хими хийх, өнгө будгийн онол ба хэрэглээ, арьс арчилгаа, илүүдэл үс авах, нүүр будалт, хумсны арчилгаа, хумсны дэвшилтэт техник технологи, гоо сайхны бизнесийн чиглэлээр суралцдаг. Сургалтынхаа хүрээнд сурагчид лабораторид үйлчлүүлэгчидтэй хамтран ажиллаж, салоны бодит туршлага хуримтлуулах, гоо сайхны шоунд оролцох, орон нутгийн олон нийтийн төвүүдийн ахмад настнуудтай хамтран ажиллах болно. Гоо сайхны иж бүрдлийг сурагчийн хэрэгцээнд зориулж өгдөг ч хүсвэл өөрсдөө худалдаж авч болно (ойролцоогоор 170 доллар орчим болно).

Косметологи III (28530)

Бүтэн жил, хоёр цагаар, хоёр кредит

Орох ангиуд: 11-12

Элсэхээс өмнөх шаардлага: Косметологи II

Косметологи III нь Косметологи II-ийг амжилттай төгссөн Сурагчдад зориулсан гүнзгийрүүлсэн түвшний сургалт юм. Мэргэжлийн гоо сайханч болох талаар шинжлэх ухааны арга барилаар суралцагсад үргэлжлүүлэн суралцах болно. Сурагчид Виржиниа мужийн Үсчин, гоо сайханчдын зөвлөлийн шалгалтанд бэлдэж, практик дээр ур чадвараа дээшлүүлж, бэлтгэл сургуулилтаа чанд базаадаг. Түүнчлэн сурагчид сургуулийнхаа салоныг удирдаж, бизнесийн чиглэлээр мэдлэг чадвараа дээшлүүлдэг. Мөн түүнчлэн сурагчид энэ салбарт салоны дадлагажигчаар ажиллах болно. Хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа сурагчид Виржиниа мужийн Гоо сайхны зөвлөлийн шалгалтанд хамрагдах, салбарт үсчний туслах, стилистийн туслах, хүлээн авагч, худалдааны төлөөлөгч, эсвэл мужийн зөвлөлийн байцаагч зэрэг чиглэлээр ажиллах боломжтой болно. Энэ хичээлийн хангамж нь сурагчдын хэрэгцээнд нийцүүлэн хувийн зардлаар хийгдэх болно.

- *Гэрчилгээ: Виржиниа мужийн Үсчин, Шоо Сайхны Зөвлөлийн шалгалт (Косметологи I, II, III төгссөн сурагчид хамрагдана.)*

Хоолны урлаг ба Шинжлэх ухаан I (28522)

Бүтэн жил, хоёр цагаар, хоёр кредит

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Сурагчид цээжний рентген зураг авхуулж, сүрьеэгийн арьсны сорил өгөх шаардлагатай.

Энэ хичээлээр сурагчид хүнсний үйлчилгээний салбарт амжилтанд хүрэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн дадал хэвшлийг сурч эхлэх болно. Ажил мэргэжлийн төвийн гал тогоо, хоолны өрөөг ашиглан сурагч залуус хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны мэдлэг, мах, ногоог хуурч шарах, амтлан шарах зэрэг үндсэн хоол хийх арга техникт суралцана. Нэмж хэлэхэд сурагчид талх нарийн боовны талаархи мэдлэг, цагаан будаа, гоймон, шинэ салатыг хэрхэн зөв бэлтгэх тухай ойлголттой болно. Сурагчид мэргэжил сонгох шийдвэр гаргахад нь туслах уг салбарын бүтээлийн бодит нөхцөлтэй танилцах болно.

Хүнс бүтээл ба шинжлэх ухаан II (28523)

Бүтэн жил, хоёр кредит

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Хүнс бүтээл ба шинжлэх ухаан I хичээлд хамрагдсан байхаас гадна цээжний рентген зураг авхуулж, сүрьеэгийн арьсны сорил өгөх шаардлагатай.

Хүнс бүтээл ба шинжлэх ухаан II хичээл нь сурагчдыг дунд боловсролын дараахь боловсрол олгох эсвэл хүнсний үйлчилгээний салбарт анхан шатны түвшинд ажилд ороход бэлтгэх зорилготой сургалтын хөтөлбөр юм.

Тус хичээл нь дараахь зүйлийг голчлон анхаарч үздэг.

Захиалгын хоол хийх; мах, загас, хүнсний ногооны зөв технологиор хоол хийх; пицца, талх хийх; бизнес эрхлэх ойлголт; хүнсний шинжлэх ухаан ба хоол тэжээлийн тухай ойлголттой болно.

Сурагчид гал тогооны практик орчинд жинхэнэ үйлчлүүлэгчдэд зориулж хоол бэлтгэж ажилладаг. Түүнчлэн, нарийн боовны ур чадварыг бүтээлийн өртөг, ашиг, алдагдал, онол, жижиг бизнесийг амжилттай эрхлэхэд шаардагдах онолуудын хамтаар заадаг. Мэргэшсэн сурагчид тэтгэлэг болон бусад үнэ цэнэтэй шагнал авах боломжтой Skills USA тэмцээнд оролцож болно.

Хүнс бүтээл ба шинжлэх ухаан II хичээл нь амжилттай тогооч болоход шаардлагатай үндсэн хими, математик, технологийн ойлголтыг өгнө.

Сурагчид орц, жорыг хэмжээсжүүлэх дасгал хийх; цайллагын үйлчилгээний шаардлагыг суралцах; түүнчлэн эцсийн бүтээгдэхүүнд үзүүлэх нөлөөг хянахын тулд найрлага (хүчил, суурь, уураг, өөх тос)-ийн янз бүрийн чухал нэгдлүүдийн тухай ойлголттой болно.

Хүнс бүтээл III Мэргэжил (28524)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 11-12

Элсэхээс өмнөх шаардлага: Хүнсний бүтээл ба Шинжлэх ухаан I (28522) Ба II (28523) хичээлүүд

Хүнс бүтээлийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр нь Сурагчдад хүнсний үйлчилгээний салбарын талаархи цогц мэдлэгийг олж авах, хүнсний үйлчилгээний чиглэлээр техникийн ур чадвараа өргөжүүлэх тасралтгүй боломжийг олгодог. Сурагчид аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг хэрэгжүүлэх, хоол тэжээлийн зарчмуудыг хэрэгжүүлэх, цэс төлөвлөх, бизнесийн болон математикийн ур чадварыг ашиглах, хоолны үйлчилгээний тоног төхөөрөмжийг сонгох, засвар үйлчилгээ хийх чиглэлээр мэргэжлээ судалж, ур чадвараа дээшлүүлдэг.

Кибер аюулгүй байдлын I дараалал: 26659 ба 26667, дараагийн шатны сургалт 26657 ба 26662.

Кибер аюулгүй байдал I: Кибер аюулгүй байдлын үндэс

(26659) (96659W)

Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Кибер аюулгүй байдлын сүлжээний систем (26667) (96667W) -тай зэрэг суралцаж байх ёстой.

Сурагчид кибер аюулгүй байдлын зарчмуудтай танилцах, шинээр гарч ирж буй технологийг судлах, аюул заналхийлэл, хамгаалалтын арга хэмжээг судлах, кибер аюулгүй байдлын чиглэлээр өндөр ур чадвар, өндөр цалин, эрэлт хэрэгцээ ихтэй карьерын боломжуудыг судлах болно. Тус хичээл нь Сурагчдад сүлжээний дизайн, кибер аюулгүй байдлын үйл явц, хувийн болон аж ахуйн нэгжийн сүлжээний журамтай танилцах боломжийг олгоно. Сурагчид сүлжээнд өргөтгөл хийх, шинэчлэх стандарт төслийн үйл явцыг дагаж мөрддөг бөгөөд үүнд баталгааг бүрдүүлэх шаардлага, төслийн менежмент багтдаг.

Windows болон Linux үйлдлийн системийг суулгах, тохируулах, удирдах зааварчилгаа өгөх Linux програмыг сүлжээний клиент болон ажлын бааз болгон ашиглаж сурна. Тус хичээл нь сурагчийн сүлжээний техникч, компьютерийн техникч, интернетийн аюулгүй байдлын карьераа эхлүүлэхэд шаардагдах ур чадварыг хөгжүүлдэг. Тус хичээлийн агуулгань гэр, жижиг бизнесийн орчинд түгээмэл хэрэглэгддэг багаж хэрэгсэл, техник хэрэгслийг ашиглан сүлжээ, интернетийг суурилуулах наад захын ойлголтыг дадлага хийлгэх замаар заана.

- *Коллежийн кредит: Хойд Виржиниа мужийн Нийтийн коллежид Тус хичээлийг давхар суралцаж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.*

Кибер аюулгүй байдлын сүлжээний систем (26667) (96667W)

Бүтэн жил, нэг кредит, + 1.0 чанарын оноо

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Кибер аюулгүй байдал I хичээлтэй зэрэг суралцаж байх ёстой. Кибер аюулгүй байдлын үндэс (26659) (96659W).

Тус хичээл нь Сурагчдад сүлжээний дизайн, кибер аюулгүй байдлын үйл явц, хувийн болон аж ахуйн нэгжийн сүлжээний журамтай танилцах боломжийг олгоно. Сурагчид сүлжээнд өргөтгөл хийх, шинэчлэх стандарт төслийн үйл явцыг дагаж мөрддөг бөгөөд үүнд баталгааг бүрдүүлэх шаардлага, төслийн менежмент багтдаг. Windows болон Linux үйлдлийн системийг суулгах, тохируулах, удирдах зааварчилгаа өгөх Linux програмыг сүлжээний клиент болон ажлын бааз болгон ашиглаж сурна. Тус хичээл нь цахим аюулгүй байдлын мэргэжилтэн, систем администратор, сүлжээний техникчийн компьютерын техникч, кабель суурилуулагч, туслах ширээний техникч болоход хэрэглэгчдэд үйлчлэх төвийн ажилтан болох хүсэлтэй сурагчдын ур чадварыг хөгжүүлдэг. Тус хичээлийн агуулгань гэр, жижиг бизнесийн орчинд түгээмэл хэрэглэгддэг багаж хэрэгсэл, техник хэрэгслийг ашиглан сүлжээ, интернетийг суурилуулах наад захын ойлголтыг практиктайгаар өгнө. Компьютер суурилуулах, интернет холболт, утасгүй холболт, файл болон хэвлэх төхөөрөмж хуваалцах, тоглоомын консол, сканнер, камер суурилуулах зэрэг лаборатори хичээл орно. Мөн түүнчлэн сурагчид дижитал бичиг үсэг сурахад шаардагдах ур чадварыг эзэмшүүлэх текст боловсруулах, хүснэгтийн мэдээллийн сан дээр ажиллах, танилцуулгын програм хангамж бүхий Microsoft Office програмыг эзэмшсэн болно.

- *Коллежийн кредит: Хойд Виржиниа мужийн Нийтийн коллежид Тус хичээлийг давхар суралцаж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.*

Кибер аюулгүй байдал II: Кибер аюулгүй байдлын програм хангамжийн үйл ажиллагаа

Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Кибер аюулгүй байдал II хичээлд зэрэг суралцаж байх ёстой. Компьютерийн програм хангамжийн сүлжээний ажиллагаа (26657) (96657W).

Тус хичээл нь компьютерийн дэмжлэг, сүлжээний удирдлагын тухай ойлголтыг заах зорилготой юм. Сурагчид хэрэглээнээс эхлээд бүрэлдэхүүн хэсгүүд хүртэл сүлжээний ойлголтуудыг сурч, P2P сүлжээний систем, клиент серверийн сүлжээг бий болгож сурна. Сурагчид сүлжээний картыг хэрхэн суулгаж тохируулах, үйлдлийн систем суулгах сүлжээнд холбох; програм хангамж дээр суурилсан сүлжээний удирдлагыг ачаалах, аккаунт үүсгэх, тохируулах, удирдах зэрэгт суралцана. Тус хичээл нь Сурагчдад руут хийх, алсаас нэвтрэх, алсаас нэвтрэх, хаягжуулах, аюулгүй байдлын тухай

үндсэн ойлголтыг өгдөг. Түүнчлэн сурагчид имэйлийн үйлчилгээ, вэб орон зай, аюулгүй байдал, нэвтрэх эрх бүхий серверүүдтэй танилцдаг. Сурагчид системийн удирдлага, тоног төхөөрөмжийн үндсэн тохиргоонд шаардлагатай ур чадварын талаар суралцдаг. Сурагчид техник хангамж, програм хангамжийн тохиргоо, кибер аюулгүй байдлын талаархи анхан шатны мэдлэг, коллежийн кредитийг олгоход шаардлагатай хэмээн тусгайлан заасан зааврыг багтаасан болно.

- *Коллежийн кредит: Хойд Виржиниа мужийн Нийтийн коллежид Тус хичээлийг давхар суралцаж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.*

Кибер аюулгүй байдал II: Компьютерийн програм хангамжийн сүлжээний ажиллагаа (26657) (96657W)

Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Кибер аюулгүй байдал I хичээлд хамрагдсан байх, эсвэл багшийн зөвшөөрөлтэйгээр Кибер аюулгүй байдал II хичээлд зэрэг элссэн байх ёстой. Кибер аюулгүй байдлын програм хангамжийн үйл ажиллагаа (26662) (96662W).

Тус хичээл нь компьютерийн дэмжлэг, сүлжээний удирдлагын тухай ойлголтыг заах зорилготой юм. Сурагчид хэрэглээнээс эхлээд бүрэлдэхүүн хэсгүүд хүртэл сүлжээний ойлголтуудыг сурч, P2P сүлжээний систем, клиент серверийн сүлжээг бий болгож сурна. Сурагчид сүлжээний картыг суулгаж, сүлжээнд тохируулж холбож сурна. Сурагчид үйлдлийн систем суулгах, аккаунт нээх, удирдах, програм хангамжийг ачаалах, аюулгүй байдлын төлөвлөгөө бий болгох, цаашид хэрэгжүүлэх талаар суралцдаг. Тус хичээлийн агуулгань Windows Server эсвэл Linux зэрэг програм хангамж дээр суурилсан сүлжээний үйлдлийн систем дээр явагдаж болно.

- *Коллежийн кредит: Хойд Виржиниа мужийн Нийтийн коллежид Тус хичээлийг давхар суралцаж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.*

Кибер аюулгүй байдал III: Компьютерийн програм хангамжийн сүлжээний ажиллагаа (26658) (96658W)

Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо

Орох ангиуд: 10-12

Кибер аюулгүй байдал II: Кибер аюулгүй байдлын програм хангамжийн үйл ажиллагаа (26662) (96662W); Кибер аюулгүй байдал II: Компьютерийн програм хангамжийн сүлжээний ажиллагаа (26657) (96657W) ба

Кибер аюулгүй байдал III-т зэрэг элссэн байх. Эсвэл багшийн зөвшөөрөлтэйгээр Кибер аюулгүй байдлын програм хангамжийн үйл ажиллагаа, Ахисан түвшин(26663) (96663W) хичээлд элссэн байх.

Тус хичээл нь сүлжээний аюулгүй байдалтай холбоотой

үндсэн ойлголт, бүтэц, протоколыг заадаг. Сурагчид сүлжээний удирдлага, сүлжээний хэрэглэгчид болон системийн удирдлага, тэдэнд хэрхэн дэмжлэг үзүүлэх тал дээр анхаарлаа төвлөрүүлж сурах болно. Сурагчид харилцааны протокол, систем, клиент-серверийн сүлжээнд гарсан алдааг олж засварлах арга техник, вэб сайтын менежмент болон бусад сүлжээний дэвшилтэт сэдвүүдийг сурна. Хичээлийн эдвийн хүрээнд дараахь ойлголтуудыг заана. Үүнд сүлжээний аюулгүй байдлын тойм; криптологи ба шифрлэлтийн үндэс; халдлагын загвар, баталгаажуулалт, зөвшөөрлийн механизм, стандарт; нийтийн сүлжээний түлхүүр дэд бүтэц; цахим шуудангийн аюулгүй байдал; транспорт давхарга ба вэб аюулгүй байдал; пакет шүүлтүүр, файер волл, халдлага илрүүлэх, виртуал үйлдлийн систем, аккаунт тохируулах, удирдах, програм хангамж ачаалах, аюулгүй байдлын төлөвлөгөө бий болгох зэрэг багтана. Тус хичээлийн агуулганы Windows Server эсвэл Linux зэрэг програм хангамж дээр суурилсан сүлжээний үйлдлийн систем дээр явагдаж болно. Хичээлийн турш салбарын мэргэжлийн гэрчилгээ олгох тал дээр анхаарч зааварлах болно.

- *Коллежийн кредит: Хойд Виржиниа мужийн Нийтийн коллежид Тус хичээлийг давхар суралцаж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.*

Кибер аюулгүй байдал III: Кибер аюулгүй байдлын програм хангамжийн үйл ажиллагаа, Ахисан түвшин(26663) (96663W)

Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо
Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Элсэхээс өмнөх шаардлага: Кибер аюулгүй байдал II: Кибер аюулгүй байдлын програм хангамжийн үйл ажиллагаа (26662) (96662W); Кибер аюулгүй байдал II: Компьютерийн програм хангамжийн сүлжээний ажиллагаа (26657) (96657W) ба

Кибер аюулгүй байдал III-т зэрэг элссэн байх.

Компьютерийн програм хангамжийн сүлжээний ажиллагаа (26658) (96658W)

Кибер аюулгүй байдлын III түвшний хичээлээр сүлжээний удирдлагын ерөнхий ойлголт, сүлжээний хэрэглэгчид болон системийн удирдлага, дэмжлэг зэргийн талаар заана. Компьютерийн мэргэжилтнүүдийн үүрэг хариуцлагыг ойлгох, эцсийн хэрэглэгчдийг сургах, шинэ технологийг үнэлэх, системийн бодлого боловсруулах, ажлын байрны алдааг олж засварлах, сүлжээний үйлчилгээ, протоколыг удирдах, имэйл, бизнесийн харилцаа холбоог үр дүнтэй ашиглах зэрэг сэдвүүд орно. Сурагчид харилцаа холбооны протокол, систем, клиент серверийн сүлжээнд гарсан алдааг олж засварлах арга техникт суралцахаас гадна вэбсайтын менежмент болон бусад дэвшилтэт сүлжээний сэдвүүдийг суралцана. Үйлдлийн систем суурилуулах, аккаунт тохируулах, удирдах, програм хангамж ачаалах, аюулгүй байдлын төлөвлөгөө бий болгох, хэрэгжүүлэх арга техникийг заадаг. Нэмэлт

сэдвүүдэд: сүлжээний аюулгүй байдлын тойм; криптологи ба шифрлэлтийн үндэс; халдлагын загвар, баталгаажуулалт, зөвшөөрлийн механизм, стандарт; нийтийн сүлжээний түлхүүр дэд бүтэц; цахим шуудангийн аюулгүй байдал; транспорт давхарга ба вэб аюулгүй байдал; пакет шүүлтүүр, файер волл, халдлага илрүүлэх, виртуал үйлдлийн систем, аккаунт тохируулах, удирдах, програм хангамж ачаалах, Линкус, Windows зэрэг үйлдлийн систем дээр аюулгүй байдлын төлөвлөгөө бий болгох зэрэг багтана. Хичээлийн турш салбарын мэргэжлийн гэрчилгээ олгох тал дээр анхаарч зааварлах болно.

- *Коллежийн кредит: Хойд Виржиниа мужийн Нийтийн коллежид Тус хичээлийг давхар суралцаж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.*

Мэдээллийн сангийн дизайн ба менежмент (26664) (96660W)

Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Мэдээллийн технологийн танилцуулга (26116)

Тус хичээлд мэдээллийн баазын дизайн, бүтэцлэгдсэн асуулга хэл (SQL) програмчлалыг багтаасан болно. Сурагчид мэдээллийн сан боловсруулах, загварчлах, хэвийн болгох зэрэг мэдээллийн баазын үндсийг судалдаг. Үүнээс гадна Сурагчдад мэдээллийн баазын програмчлалын талаар танилцуулна. Сурагчид өгөгдлийн хандалтыг удирдах, хянахын тулд мэдээллийн баазын програм хангамж, програмчлалын онцлогийг ашиглахад шаардлагатай ур чадвар, мэдлэгийг олж авдаг. Сурагчид гэрчилгээ олгох хоёр шалгалтын эхний шалгалтад бэлдэх болно.

- *Коллежийн кредит: Хойд Виржиниа мужийн Нийтийн коллежид Тус хичээлийг давхар суралцаж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.*

Дижитал Анимэйшн дараалал: 28457 ба 28458.
Хоёр хичээлд зэрэг хамрагдсан байх ёстой.

Дижитал Анимэйшн (28457)**Бүтэн жил, нэг кредит****Орох ангиуд: 10-12**

Элсэхээс өмнөх шаардлага: График холбооны систем хичээлд зэрэг элсэх (28458)

Сурагчид график, дизайны ойлголтыг ашиглан компьютерийн анимэйшн хийж сурах туршлага хуримтлуулна. Сурагчид 3 хэмжээст объектийг удирдах, түүхийн зураг, текстур/зураглал хийх, гэрэлтүүлэг, орчны геометр зэрэг агуулгуудыг багтаасан асуудлыг шийдвэрлэх замаар суралцдаг. Сурагчид бодит ертөнцийн хэрэглээг тусгасан янз бүрийн анимэйшн бүтээж интерактив болон 3 хэмжээст анимэйшн програм хангамжтай танилцдаг. Сурагчийн анхны бүтээлийн жишээг харуулсан портфолио үйлдвэрлэх ажлыг багтаасан болно.

График харилцаа холбооны систем (28458)**Бүтэн жил, нэг кредит****Орох ангиуд: 10-12**

Элсэхээс өмнөх шаардлага: Дижитал Анимэйшн хичээлд зэрэг элсэн байх ёстой. 28457)

График Харилцаа Холбооны Систем нь World Wide Web дээр харуулах компьютерын график дүрсийг бүтээхэд чиглэгддэг. Сурагчид Вэб график ба хэвлэх графикайн ялгааны талаар мэдлэг олж авдаг. Ангийн төслүүдээр дамжуулан сурагчид янз бүрийн дүрс гаргах програм хангамж ашиглан бүтээл туурвидаг. Чанартай уран зургийн дүрсийг хөгжүүлснээр сурагчид хараа зүйн харилцааны өндөр чадварыг эзэмшиж эхэлдэг. Эдгээр ур чадвар нь вэбээр холбогдсон манай гаригт улам бүр эрэлт хэрэгцээтэй болж байна. Сурагчид дуусгасан ажлуудаараа мэргэжлийн портфолиотой болдог.

Бага насны хүүхдийн боловсрол I (28235) (98235W)**Бүтэн жил, хоёр цагаар, хоёр кредит + 1.0 чанарын оноо****Орох ангиуд: 10-12**

Элсэхээс өмнөх шаардлага: Сүрьеэгийн үзлэг эсвэл цээжний рентген зураг авах шаардлагатай байж болно. Бага насны хүүхдийн боловсрол I нь хүүхэд асрах ажил, бага боловсролын чиглэлээр бага насны багшаар ажиллах сонирхолтой Сурагчдад зориулагдсан болно. Сурагчид танхимын зааварчилгаа, нярай, нялх, сургуулийн өмнөх, бага, тусгай хэрэгцээний хүүхдүүдтэй ажиллах практик туршлагыг авдаг. Сурагчид хүүхдийн өсөлт хөгжилтийн үндсэн зарчмуудыг сурч, бага насны хүүхдийн хөтөлбөр, онцлог шинж чанарыг судалж үздэг.

Коллеж кредит: Хойд Виржиниа мужийн Нийтийн коллежид Тус хичээлийг давхар суралцаж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.

Бага насны хүүхдийн боловсрол II (28236) (98236W)**Бүтэн жил, хоёр цагаар, хоёр кредит + 1.0 чанарын оноо****Орох ангиуд: 11-12**

Элсэхээс өмнөх шаардлага: Бага насны хүүхдийн боловсрол I, эсвэл Хүүхдийн хөгжил ба эцэг эх хичээлийг үзсэн байх; Мөн сүрьеэгийн шинжилгээ эсвэл цээжний рентген зураг авах шаардлагатай байж болно. Тус хичээл нь сурагчдын бага насны хүүхдүүдэд заах ур чадварыг дээшлүүлэх ажлыг үргэлжлүүлэн явуулдаг. Сурагчид Бага насны хүүхдийн боловсролын салбарт ажил мэргэжлийн талаархи бүх боломжуудыг мэддэг болно. Сурагчид Бага насны хүүхдийн сургалтын хөтөлбөрийн олон янзын үйл ажиллагааг газар дээр нь ажиллуулах, сурагчийн заах туршлагаар дамжуулан хэрэгжүүлдэг. Сурагч ParaPro даалгаврыг гүйцэтгэж, багшийн дагалдан эсвэл багшийн туслах болох алхмаа хийнэ.

- *Коллежийн кредит: Хойд Виржиниа мужийн Нийтийн коллежид Тус хичээлийг давхар суралцаж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.*
- *Гэрчилгээ: Бага насны хүүхдийн боловсролын I, II хичээлийг амжилттай дүүргэх нь Сурагчдад Хүүхэд Хөгжлийн Ассоциацийн (CDA) үндэсний үнэмлэхийг авахад нь туслах болно.*

Цахилгаан I (28534)**Бүтэн жил, хоёр цагаар, хоёр кредит****Орох ангиуд: 10-12**

Элсэхээс өмнөх шаардлага: Байхгүй.

Цахилгаан I хичээл нь Сурагчдад орон сууцны (байшингийн) барилгад ажиллахад шаардлагатай цахилгааны ур чадварыг хөгжүүлэх боломжийг олгодог. Сурагчдад түгээмэл хэрэглэгддэг цахилгаан хэрэгслийн зохистой хэрэглээ, холболтын арга техник, цахилгаан хэлхээг холбох, дүн шинжилгээ хийх, цахилгааны план унших, цахилгааны асуудлыг шийдвэрлэхэд сургах ойлголтыг заана. Сурагчдад арилжааны зориулалттай шинэ барилга, холбооны шугам сүлжээний талаар ойлголт өгнө. Энэхүү хичээлийн зааврыг Үндэсний цахилгааны хуулийг үндэслэн боловсруулсан болно. Ихэнх хичээл газар дээр, практик ажиллагаа маягаар явагдана. Аюулгүй байдал, ажлын зөв дадал нь уг хичээлд чухлаар үнэлэгдэнэ.

Цахилгаан II (28535)**Бүтэн жил, хоёр цагаар, хоёр кредит****Орох ангиуд: 10-12**

Элсэхээс өмнөх шаардлага: Цахилгаан I

Цахилгаан II хичээл нь утасны холболт, кабелийн телевизийн утас, VICSII/RBT систем, зэс дээр суурилсан сүлжээний кабель ба шилэн кабелийн кабель зэрэг арилжааны барилга байгууламж, харилцаа холбооны кабелийн холболтын аргуудын зааварчилгааг сургана. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага (OSHA)-ын газрын барилга байгууламжийг мөн ажиллах

боломжтой. Ахлах ангийнхан цахилгаан хангамжийн хуваарилалтын чиглэлээр ажиллах сургалтын хөтөлбөрт хамрагдах боломжтой. Арилжааны утас холбох агуулгыг Үндэсний цахилгааны хуулийн дагуу заадаг. Сүлжээний кабелийг BICSI//RBT Systems стандартын дагуу заадаг бөгөөд TIA//EIA 568A стандартыг хангасан болно. Сурагчид харилцаа холбооны шугам сүлжээний стандартууд, холболтын арга, техник, сүлжээ, кабелийн түүх, нэр томъёог судлах болно. Сүлжээний кабелийн бүх зааврыг бүрэн биелүүлж, муж, орон нутгийн болон багшийн бүх шаардлагыг хангасан сурагчид харилцаа холбооны салбараас үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн BICSI//RBT сертификат олгох шалгалтанд орох боломжтой болно.

- Гэрчилгээ: OSHA-10 барилгын аюулгүй байдлын үнэмлэх; BICSI//RBT Systems зэс дээр суурилсан сүлжээний кабель ба шилэн кабелийн гэрчилгээ (зөвхөн англи хэл дээр өгөгдсөн) авах боломжтой.

Түргэн тусламжийн техникч/Хүний анатоми ба физиологи (28334) (98334W)

Бүтэн жил, хоёр цагаар, хоёр крепит + 1.0 чанарын оноо

Орох ангиуд: 11-12

Элсэхээс өмнөх шаардлага: Биологи I хичээлд хамрагдсан байх ба сурагчид мөн Түргэн тусламжийн хөтөлбөрт хамрагдахын тулд Виржиниа мужийн Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын үеийн эмнэлгийн үйлчилгээний зохицуулалтын шаардлагыг хангасан байх ёстой. Хичээл эхлэхэд дор хаяж 16 настай байх; 18 нас хүрээгүй нь эцэг эхийн зөвшөөрөлтэй байх; Арлингтоны улсын сургуулиудын тогтоосон англи хэлээр унших, бичих, ярих, ойлгох чадварыг эзэмшсэн байх.

Энэхүү хөтөлбөр нь Үндэсний хурдны замын тээврийн аюулгүй байдлын агентлаг/АНУ-ын Тээврийн яаманд заадаг коллежийн түвшний сургалт бөгөөд 1994 оны эмнэлгийн яаралтай тусламжийн техникч-Суурь (EMT-B) үндэсний стандарт хөтөлбөр юм. Энэхүү хөтөлбөр нь анагаах ухааны салбар эсвэл Түргэн тусламжийн гэрчилгээ шаардсан ажил мэргэжлийг сонирхож буй Сурагчдад тохиромжтой. Сурагчид анатоми, физиологи, эмнэлгийн яаралтай тусламжийн танилцуулга, амьсгалын зам, өвчтний өвчлөлийн үнэлгээ, эмнэлгийн яаралтай тусламж, эх барих/эмэгтэйчүүдийн яаралтай тусламж, гэмтэлтэй өвчтөнийг эмчлэх, хүүхдийн яаралтай тусламж, түргэн тусламжийн үйл ажиллагааг судлах болно. Сурагчид мөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан Америкийн зүрх судасны нийгэмлэгийн Амьдралын анхан шатны дэмжлэг хөтөлбөрөөс хэрэгжүүлдэг анхан шатны тусламжийн сургалтад хамрагдах болно. Сурагчдад эмнэлгийн яаралтай тусламжийн хэлтэст туслах, ажиглалт хийх, түргэн тусламжийн машиныг жолоодох боломжийг олгоно.

- Ахлах сургуулийн нэмэлт кредит: Энэ сургалтанд хамрагдсан кредит нь ердийн дипломын Лабораторийн шинжлэх ухааны 3 дахь кредит эсвэл Ахисан шатны дипломын Лабораторийн шинжлэх ухааны 4 дэх кредитэд дүйцэх болно. Шинжлэх ухааны кредитээс гадна сурагчид дүрслэх урлаг/дадлага ажлын хоёрдахь кредитийг авах боломжтой.

- Коллежийн кредит: Хойд Виржиниа мужийн Нийтийн коллежид Тус хичээлийг давхар суралцаж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу. Тус хичээл нь сурагчид Жорж Вашингтоны их сургуулийн онлайн бакалаврын эрүүл мэндийн шинжлэх ухааны зэрэг олгох сургалтын хөтөлбөрт автоматаар элсэжэвч, Яаралтай түргэн тусламжийн чиглэлээр AAS зэрэг авах боломжийг олгодог.

Эрчим хүч ба цахилгаан эрчим хүч (26448)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Байхгүй.

Энэ дамжаанд сурагчид эрчим хүчний эх үүсвэрүүдэд дүн шинжилгээ хийж, Эрчим хүчний ажиллах хүчний хөгжлийн төвөөс (CEWD) Эрчим хүчний салбарын суурь модулиудыг ашиглан цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх талаар судалж үздэг. Сургалт нь практик хэрэглээний дэмжлэгтэйгээр математик, байгалийн ухаан, техникийн бичих чадварыг эзэмшдэг. Сурагчид эрчим хүчний салбарын үндэс суурийн гэрчилгээний даалгаврыг авах боломжтой.

Вэб хуудасны дизайн ба мультимедиа (26646) (96646W)

Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо

Орох ангиуд: 9-12

Элсэхээс өмнөх шаардлага: Байхгүй.

Сурагчид бүтээлийн стандарт хэрэглээний програм хангамж ашиглан мультимедиа танилцуулга/төсөл, вэбсайт зохион бүтээх чадварыг хөгжүүлдэг. Сурагчид төслөө гүйцэтгэхдээ зохион байгуулалт, дизайны зарчмуудыг баримтлан ажиллана. Сурагчид портфолио бүтээдэг бөгөөд үүнд анкет, хичээлийн явцад гүйцэтгэгдсэн төслүүд, мультимедиа бүтээлүүд, вэбсайтын төслүүд багтдаг.

- Коллежийн кредит: Хойд Виржиниа мужийн Нийтийн коллежид Тус хичээлийг давхар суралцаж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.

Төслийн манлайлал (PLTW)

“Төслийн манлайлал” нь сурагчдыг инженерчлэлд чиглүүлж, коллежийн инженерийн хөтөлбөрт амжилттай суралцахад бэлтгэх сургалтуудын үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн дараалал юм. Хичээлийн хөтөлбөрт хамрагдах сурагчид коллежийн математик, байгалийн ухааны бэлтгэл дараалалд хамрагдах ёстой.

Инженерчлэл I дараалал: 28491 ба 28492. Хоёр хичээлд зэрэг хамрагдсан байх ёстой.

Инженерчлэл I: Инженерийн дизайны танилцуулга (28491)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 9-12

Элсэхээс өмнөх шаардлага: Байхгүй.

Инженерчлэл I нь инженерийн дизайны хөгжилд голчлон анхаарч хичээлээ явуулдаг. Сурагчид компьютерийн програм хангамжийг ашиглан төслийн шийдлийн загваруудыг гаргаж, дүн шинжилгээ хийж, үнэлдэг. Тэд хэлбэр, функцийн дизайны үзэл баримтлалыг судалж, орчин үеийн технологийг ашиглан концептын загварыг дахин үйлдвэрлэж болохуйц бүтээгдэхүүн болгон хөрвүүлдэг. Тус хичээл нь Сурагчдад дизайны үйл явцыг ойлгох, хэрэгжүүлэх, дасан зохицох, загварын концептыг хэрэгжүүлэх, эскиз боловсруулах, дизайны асуудлыг шийдвэрлэх, макет гарган загварчлах, компьютерийн дизайны програм хангамж ашиглан бүтээгдэхүүний загварыг бий болгох, дүн шинжилгээ хийхэд сургадаг.

Инженерчлэл II: Инженерийн зарчим (28492)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд. Арлингтон Технологийн сурагчид 9-р ангиас эхлэж болох бөгөөд бусад сургуулиудад 10-12 анги. *Инженерчлэл I хичээлийг дүүргэсэн эсвэл Инженерчлэл I хичээлд зэрэг элссэн байх ёстой. (28491)* Энэ хичээл нь инженерийн технологийн ерөнхий тойм ойлголтыг өгнө. Сурагчид бодит инженерчлэлийн асуудлуудыг шийдвэрлэх замаар асуудал шийдвэрлэх чадварыг хөгжүүлдэг. Сурагчид онол, практик туршлагаар дамжуулан технологийн өөрчлөлтөөс үүдэн гарч буй нийгэм, улс төрийн үр дагаврыг дүгнэнэ. Зарим сэдвүүдээр инженерийн тойм, хэтийн төлөв, зураг төслийн явц, харилцаа холбоо, баримт бичиг, инженерийн систем, статистик, материал болон материалын туршилт, термодинамикийн тухай үзнэ.

Дижитал электроник (26671)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Инженерчлэл: Инженерийн танилцуулга I (28491) ба Инженерчлэл II: Инженерийн зарчим (28492)

Энэхүү инженерийн өмнөх сургалт нь Үндэсний инженерийн хөтөлбөрийн хүрээнд хоёр үндсэн хичээлийг (Инженерийн зарчим ба Инженерийн зураг төсөл боловсруулах танилцуулга) дагаж боловсруулсан болно. Сурагчид цахилгаан хэлхээ, төхөөрөмжийг зохион бүтээх, турших, бодитоор бүтээхдээ логикийн талаар сурахын тулд компьютерийн симуляцийг ашигладаг. Тэд хяналтын системийн програмчлалыг хэрэгжүүлж, дараалсан логик ба дижитал хэлхээний үндсийг судалж үздэг. Компьютерийн хэлхээний тухай сэдвүүд мөн агуулгад багтдаг.

Инженерчлэл II дараалал: 28493 ба 28494. Хоёр хичээлд зэрэг хамрагдсан байх ёстой.

Компьютерийн нэгдсэн бүтээлийн инженерчлэл (28493)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Инженерчлэл II (28492)

Энэхүү мэргэшүүлэх сургалтанд Сурагчдад компьютер загварчлалын програм хангамж бүхий 3 хэмжээст загварыг бүтээж робот техник, автоматжуулсан бүтээлийн талаархи ойлголтуудыг олж авна.

Инженерийн Капстон (Capstone): Дизайн ба хөгжил (28494)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Инженерчлэл I (28491) ба II (28492)

Энэхүү Инженерийн санаачилгын сургалтанд олон нийтийн зөвлөхүүдээр удирдуулсан сурагчийн багууд инженерийн асуудлуудыг судлах, боловсруулах, шийдэл гаргах чиглэлээр хамтран ажилладаг. Сурагчид мэдлэг, ур чадвар, чадамжийг жинхэнэ инженерийн туршлагаас суралцдаг. Сурагчид хараат бус судалгааны болон багт чиглэсэн төслүүдийг хөгжүүлж албан ёсоор танилцуулах бөгөөд үнэлгээний хорооноос төслүүдэд шүүмж хэлж үнэлнэ.

Биотехнологийн хэрэглээтэй шүүх шинжилгээний технологи (28325)

Бүтэн жил, хоёр кредит

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Биологи I

Биотехнологийн хэрэглээтэй Шүүхийн технологи нь аливаа шүүхийн шинжлэх ухааныг цаашдын карьер болгож ялангуяа биотехнологитой холбоотой нухацтайгаар сонирхдог Сурагчдад зориулагдсан болно. Энэхүү хичээл нь коллежийн түвшний баримт сэлт ихээр судалдаг тул ахисан түвшний хичээлд тооцогддог сургалт юм. Сурагчид гэмт хэргийн

үзэгдлийг хэрхэн боловсруулах, ДНХ-ийн шинжилгээ хийх, шилэн дэх дээжинд хугарлын индексийн сорилыг бөглөх, цус цацарсан ул мөрийн хэв шинжид дүн шинжилгээ хийх, семинарт оролцож кейс судлалын талаар ярилцах болно. Сурагчид лабораторийн стандарт протоколыг гаргаж, бүх шинжилгээнд шинжлэх ухааны аргыг дагаж мөрдөх шаардлагатай болно. Сурагчид өөр өөр шүүхийн шинжлэх ухаанд ашигладаг янз бүрийн арга техник, тухайлбал, энтомологи, остеологи, антропологи, шүүх ботаник, токсикологи, ДНХ-ийн шинжилгээнд суралцах болно. Энэ хичээлийг шинжлэх ухааны суурь мэдлэгтэй Сурагчдад зөвлөж байна.

Эрүүл мэндийн шинжлэх ухааны дараалал: 28303 ба 28383 эсвэл 98383W. Хоёр хичээлд зэрэг хамрагдсан байх ёстой.

Эрүүл мэндийн шинжлэх ухаан (28303)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 9-12

Элсэхээс өмнөх шаардлага: Анагаах ухааны нэр томъёо (28383) хичээлд давхар элссэн байх ёстой.

Тус хичээл нь Сурагчдад олон төрлийн эрүүл мэндийн ажил мэргэжлийн талаар танилцуулж, эрүүл мэнд, анагаахын бүх шинжлэх ухаанд шаардагдах анхан шатны чадварыг хөгжүүлдэг. Энэ хичээл нь Сурагчдад АНУ-ын эрүүл мэндийн тогтолцооны гол үндэс суурь, хүчин зүйлийг ойлгоход туслах, бие махбодийн тогтолцоо тус бүрт зориулсан эрүүл мэндийн анхан шатны нэр томъёо, анатоми, физиологи, эмгэг, оношлогоо, клиник процедур, эмчилгээний арга хэмжээ, гэмтлийн болон эмнэлгийн яаралтай тусламжийн үндсийг сурахад туслах зорилготой юм. Сургалтын туршид эрүүл мэндийн орчин дахь аюулгүй байдал, ариун цэвэр, нянгүйжүүлэлт, мэргэжлийн ур чадвар, хариуцлагатай байдал, үр ашгийг онцлон тэмдэглэж сургадаг. Сурагчид эрүүл мэнд, анагаахын шинжлэх ухааны салбарт ажиллахын тулд ажил хайх ур чадварыг энэ хичээлээс эзэмшдэг. Мөн түүнчлэн хичээлийн агуулга эмнэлгийн лабораторийн журам, фармакологийн үндэс, биотехнологийн консепт, өвчтөнд чанартай тусламж үзүүлэхэд зайлшгүй шаардлагатай харилцааны ур чадвар зэргийг багтаадаг болно.

- *Гэрчилгээ:* Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг тухайн хичээлтэй холбоотой салбарын гэрчилгээгээр дамжуулж авах боломжтой.

Анагаах ухааны нэр томъёо (28383) (98383W)

Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Эрүүл мэндийн шинжлэх ухаан хичээлд (28303) зэрэг элссэн байх ёстой.

Анагаахын нэр томъёо нь Сурагчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэлийг сурахад туслах зорилготой юм. Биеийн тогтолцооны анатоми, физиологиос эхлээд эмгэг судлал, оношлогооны процедур, эмчилгээний арга хэмжээ, эцэст нь фармакологийн чиглэлээр ахиц дэвшил гаргах сэдвүүдийг логик дарааллаар заан сургадаг. Сурагчид сэдэв тус бүрийн ойлголт, нэр томъёо, товчлолыг сурна.

- *Коллежийн кредит:* Хойд Виржиниа мужийн Нийтийн коллежид Тус хичээлийг давхар суралцаж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.
- *Гэрчилгээ:* Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг тухайн хичээлтэй холбоотой салбарын гэрчилгээгээр дамжуулж авах боломжтой.

Материал ба процессын технологи (28433)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 9-12

Элсэхээс өмнөх шаардлага: Байхгүй.

Сурагчид биет материал, боловсруулалт хийхэд анхаарлаа төвлөрүүлж, ашиглах боломжтой бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, туршилт явуулдаг. Суралцах туршлагад нь мэргэжлийн карьерын дүн шинжилгээ хийх, түүнчлэн металл, хуванцар, мод, керамик, нийлмэл материалыг шинжлэх, турших, боловсруулахтай холбоотой багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглах багтана. Энэхүү нэг удаагийн лабораторийн сургалтыг техникийн карьер сонирхож байгаа болон болон хэрэглэгчийн хувьд технологийн мэдлэгээ дээшлүүлэх хүсэлтэй бусад Сурагчдад зөвлөж байна.

Эмийн сангийн техникч (28305)

Бүтэн жил, хоёр кредит

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Байхгүй.

Энэхүү гэрчилгээ олгох хөтөлбөр нь Сурагчдад эмийн сангийн техникчээр ажиллах анхан шатны мэдлэг, ур чадвар олгоход зориулагдсан болно. Уг хичээлээр сурагчийн Эмийн сангийн зөвлөлийн шаардлагыг хангаж, улсын шалгалт эсвэл эмийн сангийн техникчийн гэрчилгээ олгох зөвлөлөөс зохион байгуулдаг үндэсний шалгалтанд ороход бэлтгэх болно. Зохистой ур чадвар, мэдлэгээ харуулах чадвартай, дадлага туршлагатай эмийн сангийн техникчид нь цаашид олон сонирхолтой, нэр хүндтэй мэргэжлийн сонголт хийх эсвэл эмийн сангийн чиглэлээр хоёрдогч шатны сургалтанд хамрагдах боломжтой болно.

- *Гэрчилгээ: Эмийн сангийн техникчид гэрчилгээ олгох эмийн сангийн шалгалт (ExCPT)*

Гэрэл зураг, видео технологийн дараалал: 28625 ба 28626. Хоёр хичээлд зэрэг хамрагдсан байх ёстой.

Фото зураг ба видео технологи I (28625)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Гэрэл зураг, видео технологи II хичээлд зэрэг элссэн байх ёстой. (28626)

Дүрс буулгах технологи нь Сурагчдад гэрэл зургийн үндсэн зарчмуудыг танилцуулж, дижитал дүрслэлд ихээхэн анхаарал хандуулж хичээлийг явуулдаг. Сурагчид харилцаа холбооны хэрэгсэл болох гэрэл зургийн хөгжил, дижитал ертөнцөд хэрхэн хөгжиж байгааг судалдаг. Сурагчид дижитал зургуудыг хүссэнээрээ хувиргахын тулд зураг засах төрөл бүрийн програмыг ашиглаж сурна.

- *Гэрчилгээ: Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг тухайн хичээлтэй холбоотой салбарын гэрчилгээгээр дамжуулж авах боломжтой.*

Гэрэл зураг, видео технологи II (28626)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Гэрэл зураг, видео технологи I хичээлтэй зэрэг элссэн байх ёстой. (28625)

Тус хичээл нь Сурагчдад видео болон медиа бүтээлийн бүхий л талыг судлах практик боломжийг санал болгодог. Сурагчид бүтээлийн өмнөх үе шатууд, бүтээл, бүтээлийн дараах үе шатуудаас мэдээлэл боловсруулж, төлөвлөж, хувь нэмрээ оруулах болно. Мөн түүнчлэн, сурагчид студийн зураг засварлах програм хангамж, видео, аудио тоног төхөөрөмжийг ажиллуулах явцад олон төрлийн видео, медиа продакшн бий болгох зорилгоор мэдээлэл цуглуулах, бүртгэх, шинэлэг контент бүтээх олон аргад суралцана.

Физик эмчилгээ/Спортын анагаах ухааны технологи (28332)

Бүтэн жил, хоёр цагаар, хоёр кредит (Нэмэлт: 105 клиник цагийг гурван кредитэд тооцно)

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Биологи I хичээлийг үзэж судалсан байх ба Эмнэлзүйн ажиглалт хийх сонголтын 3-р кредитэд бүртгүүлсэн нь цээжний рентген зураг, эсвэл сүрьеэн арьсны сорилыг тавиулсан байх ёстой.

Физик эмчилгээ/спортын анагаах ухааны технологи нь физик эмчилгээ, хөнгөн атлетикийн дасгал, дасгалын физиологи, хөдөлмөрийн эмчилгээ, спортын анагаах ухаан гэх мэт нөхөн сэргээх анагаах ухааны бүхий л асуудлыг сонирхдог Сурагчдад зориулагдсан болно. Энэхүү хичээл нь коллежийн түвшний баримт сэлт их судалдгаасаа шалтгаалан хүнд хэцүүд тооцогддог сургалт юм. Сурагчид анатоми, физиологи, зүрх судасны стресс тест, эмчилгээний дасгал, биеийн бүтэц, түргэн тусламж, хэт авиан үзлэг/цахилгаан өдөөлтийн

нөлөө, усан эмчилгээ, гониометрийн үр нөлөөг судлах болно. Мөн сурагчид хөнгөн атлетикийн осол гэмтлийг үнэлэх, эмнэлгийн яаралтай тусламжийн үнэлгээ, тусламж үйлчилгээ, хэвшлийн хэрэглээ, сэргээн засах дасгалын хөтөлбөр боловсруулах, бичлэг хийх зэрэгт чадварыг эзэмших юм. Мөн түүнчлэн Сурагчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид болох Америкийн Улаан Загалмайн нийгэмлэг болон Стандарт Анхны тусламжийн нийгэмлэгээс гэрчилгээ олгох болно. Хөтөлбөрийн салшгүй хэсэг нь сурагчид эмнэлзүйн дадлагын үеэр тусгай зөвшөөрөлтэй физик эмчилгээний эмч, гэрчилгээжсэн биеийн тамирын дасгалжуулагч, ортопед эмч, дасгалын физиологичдын хяналтан дор өвчтөнд туслах, эмчлэх явцад олж авах "дадлага туршлага" юм.

- *Ахлах сургуулийн нэмэлт кредит: Энэ сургалтанд хамрагдсан кредит нь ердийн дипломын Лабораторийн шинжлэх ухааны 3 дахь кредит эсвэл Ахисан шатны дипломын Лабораторийн шинжлэх ухааны 4 дэх кредитэд дүйцэх болно.*

Робот дизайн (28421)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 9-12

Элсэхээс өмнөх шаардлага: Байхгүй.

Сурагчид компьютер, микропроцессор, тэдгээрийн бүтээл, тээвэрлэлт, харилцаа холбооны системд хэрхэн ашиглах талаар судалдаг хичээл юм. Сэдвийн дотор компьютерийн тоног төхөөрөмж, үйлдлийн систем, робот техник, програмчлал, хяналтын систем, эдгээр технологийн нийгэм болон соёлд үзүүлэх/үзүүлсэн нөлөөлөл орно. Асуудлыг шийдвэрлэх даалгаврууд нь сурагчдыг компьютерийн системтэй дизайн хийх, програмчлах, интерфейс гаргах ажилд нь улам урагшлуулж урамшуулдаг. Сургалтын үйл ажиллагаанд робот техник, компьютерийн дизайн, Компьютерийн дэмжлэгтэй бүтээл, дизайн, цахилгаан механик төхөөрөмжүүдийн хяналт зэрэг орно. Сурагчид Робототехник ба Автоматжуулалтын технологийн шалгалт, ажлын байрны бэлэн байдлын шалгалтын аль алианаар нь гэрчилгээ авах боломжтой болно.

Амьтны шинжлэх ухаан I дараалал: 28064 ба 28061. Хоёр хичээлд зэрэг хамрагдсан байх ёстой.

Мал, амьтан судлал I/Мал эмнэлгийн шинжлэх ухаан I (28064)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 9-12

Элсэхээс өмнөх шаардлага: Биологи I дүүргэсэн байх; Мал, амьтан судлал II/Мал эмнэлгийн шинжлэх ухааны II (28061) хичээлд хамрагдаж байх ёстой.

Сурагчид амьтдын эрүүл мэнд, хоол тэжээл, менежмент, нөхөн үржихүй, үнэлгээний зааварчилгааны чиглэлд анхаарлаа төвлөрүүлж, жижиг амьтдыг хэрхэн арчлах, маллах талаар сурна. Хичээлийн агуулгад бага жижиг амьтдыг арчлах хэрэгсэл, тоног төхөөрөмж, тоног төхөөрөмжийн зааврыг багтаасан бөгөөд манлайллыг хөгжүүлэх агуулгыг мөн багтаадаг.

Малын техникийн шинжлэх ухаан II/Мал эмнэлгийн шинжлэх ухаан II (28061)

Бүтэн жил, нэг кредит

Орох ангиуд: 9-12

Элсэхээс өмнөх шаардлага: Биологи I дүүргэсэн байх; Мал, амьтан судлал I/Мал эмнэлгийн шинжлэх ухааны I (28064) хичээлд хамрагдаж байх ёстой.

Мал эмнэлгийн шинжлэх ухаан нь Сурагчдад дунд шатны боловсрол, мал эмнэлгийн анагаах ухаан эсвэл холбогдох мэргэжлээр мэргэжлээрээ амжилтанд хүрэхэд шаардагдах хөдөлмөр эрхлэлт, техникийн мэдлэг, ур чадварыг эзэмших боломжийг олгодог. Сурагчид Амьтан судлалын байранд байрладаг олон төрлийн гэрийн болон ховор амьтадтай ажилладаг. Хичээлийн агуулга нь эрдэм шинжилгээний ажилтнуудын хэрэглээ, ажил мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, бизнесийн менежмент, мал эмнэлэгтэй холбоотой багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, байгууламж ашиглах зэрэг тодорхой мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэгддэг. Хөтөлбөрийн амьтадтай холбоотой орон нутгийн бизнес эрхлэгчидтэй түншлэлийн харилцаа нь манлайлах чадварыг дээшлүүлэх, дадлагажигчид ажилд оролцох боломжийг олгодог. Сургалтанд хамрагдсан сурагчид математик, байгалийн ухааны мэдлэгтэй, жижиг мал амьтдын арчилгааны тухай бүрэн мэдлэгтэй болдог. Сурагчид ZOO 276-д Мал удирдлагын дадлагажигч II-хөтөбөрт хамрагдан Нью Йоркийн Улсын Их Сургууль - Жефферсоны Олон Улсын Коллежоос Амьтны хүрээлэнгийн Хэрэглээний Шинжлэх Ухааны Сургууль тус бүрээс Мал амьтны технологиор шинжлэх ухааны зэрэг горилох 3 кредит горилж болно.

- Ахлах сургуулийн нэмэлт кредит: Энэ сургалтанд хамрагдсан кредит нь ердийн дипломын Лабораторийн шинжлэх ухааны 3 дахь кредит эсвэл Ахисан шатны дипломын Лабораторийн шинжлэх ухааны 4 дэх кредитэд дүйцэх болно. Шинжлэх ухааны кредитээс гадна сурагчид дүрслэх урлаг/дадлага ажлын хоёрдахь кредитийг авах боломжтой. Тус хичээлийн агуулганы стандарт дипломын өөрчлөгдсөн дараалалд тооцогддог.

Телевизийн бүтээл I (28689) (98689W)

Бүтэн жил, хоёр цагаар, хоёр кредит + 1.0 чанарын оноо

Орох ангиуд: 9-12

Элсэхээс өмнөх шаардлага: Байхгүй.

Телевизийн бүтээл I хичээл нь дижитал медиа бүтээлийн онол, практикийн ойлголтыг өгнө. Виржиниа дахь хамгийн шилдэгт тооцогддог Ажил Мэргэжлийн Төвийн дэргэдэх Дижитал медиа бүтээлийн байгууламжид явагдах "практик" төслүүдэд ажилласнаар сурагчид ур чадвараа хөгжүүлдэг. Бүтээлийн даалгавар нь телевиз, радио, интернетийн салбаруудыг хамруулах бөгөөд үүнд олон нийтийн үйлчилгээний зар, дууны клип, бие даасан богино хэмжээний кино, радио нэвтрүүлэг, вэбсайт, анимэйшн багтдаг. Телевизийн продакшны сурагчид Тус хичээлд хамрагдах явцдаа үйлчлүүлэгчдээс ирэх ажлын бодит боломжоор дамжуулан орон нутгийн, улсын болон үндэсний тэмцээнүүдэд оролцон олон тооны шагнал тогтмол авдаг. Сурагчид бие даан болон багаар ажиллаж, оригиналь бүтээлээ гаргах бөгөөд хичээл дуусах үед мэргэжлийн портфолиогийнхоо нэг хэсэг болгон авч явдаг.

- *Коллежийн кредит: Хойд Виржиниа мужийн Нийтийн коллежид Тус хичээлийг давхар суралцаж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.*

Телевиз ба мультимедиа бүтээл II (28690) (98690W)

Бүтэн жил, хоёр цагаар, хоёр кредит + 1.0 чанарын оноо

Орох ангиуд: 10-12

Элсэхээс өмнөх шаардлага: Телевизийн бүтээл I хичээлийг дүүргэсэн эсвэл багшийн зөвшөөрлөөр суралцаж болно.

Элсэхээс өмнөх шаардлага: Өмнөх нийгмийн ухааны багшийн бичгээр гаргасан тодорхойлолт, эсвэл багшийн зөвшөөрөл байх ёстой.

Эдийн засаг нь нь нөөцийг хэрхэн яаж хуваарилдаг, яагаад ийм байдлаар хуваарилдаг болохыг харуулдаг динамик нийгмийн шинжлэх ухаан юм. Уг хичээл дээр эдийн засаг хэрхэн түүх, газарзүй, сэтгэл зүй, социологи, улс төр, математик, шинжлэх ухааны элементүүдийг нэгтгэж, хувь хүмүүс, байгууллага, үндэстнүүд эдийн засгийн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд өөрсдийгөө хэрхэн зохион байгуулдаг талаар сонирхолтой бөгөөд холбогдох судалгааг хийдэг

Хичээлийн турш бодит амьдрал дээрх асуудлуудад онолыг хэрхэн ашиглахад анхаарч суралцах болно. Микро эдийн засаг, макро эдийн засаг, олон улсын худалдаа, эдийн засгийн хөгжил зэрэг томоохон сэдвүүд багтана. Харгалзан үзэх хэд хэдэн асуудал нь:

Татварыг нэмэх үү, бууруулах уу? Худалдааны алдагдал чухал уу? Ажилгүйдлийг бууруулах боломжтой юу? Ирээдүйн засгийн газар нийгмийн даатгал төлж чадах уу? Байгаль орчинд үнийн шошго тавих ёстой юу? Хөгжиж буй орнуудын өрийг тэглэх ямар үндэслэлүүд байна вэ? U. S. NAFTA-д үргэлжлүүлэн явах ёстой юу? гэх мэт юм. Тус хичээл нь сурагчдыг сургалтын төгсгөлд Эдийн засгийн чиглэлээр шаардлагатай ОУБХ-ийн түвшний шалгалтанд бэлтгэнэ. Тус хичээлийг амжилттай дүүргэсэн сурагчид Эдийн засаг, хувийн санхүүжилтийн хичээлийн төгсөлтийн шаардлагыг хангана. Хичээлийн сегментийг онлайнгаар заах бөгөөд ингэснээр виртуал дамжааны төгсөлтийн шаардлагыг мөн хангана. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй

(22802). Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдсэнээр дүгнэгдэнэ.

ОУБ Газарзүй (SL) (32210) Бүтэн жил, нэг кредит (+1.0 чанарын оноо)

Орох ангиуд: 11 ба 12

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Нийгмийн ухааны багш эсвэл ОУБХ-ийн зохицуулагчийн тодорхойлолт

Тус хичээл нь зохион байгуулалтын хувьд сэдэвчилсэн, хүний анхаарлыг төвлөрүүлж, хамрах хүрээг өргөжүүлсэн ойлголтыг олгоно. Уг хичээлийн цөм нь хүн ам, нөөц баялаг, хөгжлийн харилцан хамааралтай сэдэв, түүний дотор эдийн засаг, амьдралын чанарын зарчмууд юм. хичээлийн үндсэн агуулгань физик газарзүйн асуудал бөгөөд үүнд хувь хүний менежмент, хариу арга хэмжээний тухай мөн уг хичээлээр онцолж судална. Газарзүйн

судлаачид газрын зураглал, түүнтэй ижил төстэй арга техникийг өвөрмөц байдлаар ашиглахад чиглэсэн ур чадварыг дээшлүүлж, сонголтууд нь сэдэвчилсэн хүний хийгээд физик талыг топографийн газрын зураг, бусад газрын зураг, зургаар дамжуулан нэгтгэх гэсэн агуулгыг багтаана. *Тус хичээл нь сурагчийн хичээлийн төгсгөлд газарзүйн чиглэлээр шаардлагатай стандарт түвшний ОУБХ-ийн шалгалтанд бэлтгэнэ. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (22210).* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ.

ОУБ Америкийн түүх (HL)

I хэсэг (32385)

Бүтэн жил, нэг кредит

(Хоёр жил дуусаж мөн мөн

ОУБХ-ийн шалгалтыг өгсний

дараа жил бүрээр тооцож +1.0

чанарын оноо)

Орох ангиуд: 11

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Дэлхийн түүх (Түргэвчилсэн хөтөлбөртэй анги) ба Ахисан түвшний Виржиниа муж болон АНУ-ын засгийн газрын түүх хичээлүүдийг дүүргэсэн байх ёстой.

Америкийн түүх нь Сурагчдад Америк тивийн талаар гүнзгий сэдэвчилсэн судалгаа хийх боломжийг олгодог. Тус хичээл нь Сурагчдад түүхийг сахилга бат болгох үүднээс танилцуулж, түүхэн эрэн сурвалжлах үйл явцыг ойлгоход нь тусалдаг. Америк тивийн түүх хичээлээр Америк тивийн түүхэнд онцлон анхаарч, Америк тивийн улс үндэстнүүдийн улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын түүхийг нарийвчлан судална. Сурагчид түүх нь нотолгоонд хандах талаасаа шинжлэх ухааны нэг хэсэг, олж мэдсэн зүйлээ тэмдэглэх, мэдээлэх талаасаа урлагийн нэг хэсэг гэж авч үзнэ. Түүхийн хичээл нь мэргэжлийн түүхчдийн олон янзын эх сурвалжаас олж авсан нотлох баримтыг судлах замаар өнгөрсөн үеийг тэмдэглэх, сэргээн босгох оролдлого юм. Тийм учраас улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын хамгийн өргөн хүрээнд түүх нь хувь хүн, нийгэмтэй холбоотой байдаг. Сурагчид түүхийн мөн чанарыг ойлгодог бөгөөд түүхэн бичлэгийг тайлбарлах, ойлгохын тулд анхдагч эх сурвалжуудыг ашиглаж сурна. *Тус хичээл нь Хорьдугаар зууны дэлхийн түүхийн сэдвүүдийн хамт Виржиниа муж, Америкийн түүх хичээлд тавигдах шаардлагыг хангаж, төгсөх жилийн төгсгөлд Түүхийн чиглэлээр шаардлагатай өндөр түвшний ОУБХ-ийн шалгалтанд сурагчдыг бэлтгэнэ. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (22385).* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ.

Хорьдугаар зууны дэлхийн түүхэн дэх сэдвүүдийг үргэлжлүүлэн үргэлжлүүлэхгүй байхыг сонгосон, Америк тивийн түүх, Виржиниа муж, Америкийн түүх хичээлийн SOL шалгалтанд тэнцсэн сурагчид Виржиниа муж, Америкийн түүх хичээлийн кредит авах болно; Гэсэн хэдий ч тэд чанарын онооноос татгалзах бөгөөд даалгавар нь АНУ, Виржиниа мужийн түүхийг унших болж өөрчлөгдөнө.

ОУБ 20-р зууны дэлхийн түүх

II хэсэг (32386)

Бүтэн жил, нэг кредит

(Хоёр жил дуусаж мөн мөн

ОУБХ-ийн шалгалтыг өгсний

дараа жил бүрээр тооцож +1.0

чанарын оноо)

Түүх (HL)

Орох ангиуд: 12

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Америкийн түүх (HL) I-р хэсэг хичээлийг үзсэн байх ёстой.

Тус хичээл нь Сурагчдад 20- зууны дэлхийн түүхийн сонгосон сэдвүүдийг судлах боломжийг олгож, бүс нутгийн онцлох сэдэв болох Америк тивийн түүхэнд анхаарлаа төвлөрүүлдэг. Хорьдугаар зууны түүхэн дэх томоохон үйл явдлууд ба асуудлууд Америк тивд тохиолдсон эсвэл нөлөөлж байсны үйл явдлуудыг ач холбогдолыг судална. *Энэхүү хичээл нь Америк тивийн түүхийн хамт Виржиниа муж, Америкийн түүх хичээлд тавигдах шаардлагыг хангаж, сурагчдыг төгсөх жилийн төгсгөлд өгөх түүхийн дээд түвшний ОУБХ-ийн шалгалтанд бэлтгэнэ. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (22386).* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ.

ОУБ Мэдээллийн технологи а

(36623)

Бүтэн жил, нэг кредит

(+1.0 чанарын оноо)

Дэлхийн нийгэм (SL)

Орох ангиуд: 11 ба 12

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Байхгүй.

Дипломын хөтөлбөрийн Мэдээллийн технологи, Дэлхийн нийгэм (ITGS) хичээл нь хувь хүн, нийгэмд мэдээллийн технологи (MT) хэрхэн нөлөөлж байгааг судлах зорилготой хичээл юм. Дижитал мэдээллийг орон нутгийн болон дэлхийн түвшинд ашиглах давуу болон сул талуудыг судалж үзнэ. Уг хичээл нь сурагчийн MT-ийн

хэрэглээний талаархи үндэслэлтэй дүгнэлт, шийдвэр гаргах орчинг бүрдүүлдэг. *Тус хичээл нь сурагчдыг сургалтын төгсгөлд уг хичээлд шаардагдах Стандарт түвшиний ОУБХ-ийн шалгалтанд бэлддэг. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (26616).* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ.

ОУБ Гүн ухаан (SL)

(32600)

**Бүтэн жил, нэг кредит
(+1.0 чанарын оноо)**

Орох ангиуд: 11 ба 12

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Өмнөх нийгмийн ухааны багшийн бичгээр гаргасан тодорхойлолт, эсвэл багшийн зөвшөөрөл байх ёстой.

ОУБХ-ийн Гүн ухааны хичээл нь ОУБ хөтөлбөрийн шаардлагыг хангасан нэг жилийн хугацаатай сургалт юм. Сурагчид хүний оршин тогтнох тухай үндсэн асуултуудыг судлах болно. Би хэн вэ? Би энд ямар зорилгоор ирсэн юм бэ? Аз жаргал гэж юу вэ? Амьдралын утга учир юу вэ? Амьдрал утга учиртай юу? Хүмүүс хүүрэлэн буй орчны өмнө хариуцлага хүлээдэг үү? Бид муу хууль гэж үзэж байсан ч гэсэн дандаа захирагдах ёстой юу? Сурагчид гүн ухааны мэдэгдэл, текстийн талаархи ойлголтоо харуулах, маргаантай стратеги боловсруулж, гүн ухааны уламжлалын олон талт мэдрэмжийг олж авах, товлосон, тохирсон, уялдаатай хэлний төлөвлөсөн утгыг нь тодорхой илэрхийлэх зэрэг чадварт суралцана. *Энэхүү хичээл нь сурагчдыг төгсөх жилийн төгсгөлд өгөх шаардлагатай Гүн ухааны хичээлийн өндөр түвшиний ОУБХ-ийн шалгалтанд бэлддэг. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (22600).* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ.

ОУБ Сэтгэл судлал (SL)

(32901)

**Бүтэн жил, нэг кредит
(+1.0 чанарын оноо)**

Орох ангиуд: 11 ба 12

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Өмнөх нийгмийн ухааны багшийн бичгээр гаргасан тодорхойлолт, эсвэл багшийн зөвшөөрөл байх ёстой.

Энэхүү ОУБХ-ийн сэтгэл судлалын хичээл нь ОУБ хөтөлбөрийн шаардлагыг хангасан нэг жилийн хугацаатай сургалт юм. Сурагч ОУБХ-ийн сэтгэл судлалын хөтөлбөрийг Стандарт түвшинд судалсны дараа биологийн, танин мэдэхүйн, сургалтын хэтийн төлөв гэсэн сэтгэлзүйн гурван хэтийн төлөвийн гол санаануудыг дүрсэлж, харьцуулж, үнэлэх чадамжтай болно. Сурагчид нэг эрдэм шинжилгээний туршилтыг хийж, 2000-3000 үгтэй судалгааны бүтээл гаргах шаардлагатай. Сурагчид шүүмжлэлтэй сэтгэх чадварыг хөгжүүлж, дэлхий дахины иргэд, насан туршдаа суралцагчдад хувь нэмэр оруулахад шаардлагатай мэдлэгийг олж авах болно. *Энэхүү хичээл нь сурагчдыг сургалтын төгсгөлд Сэтгэл судлалын стандарт түвшиний шалгалтанд бэлтгэнэ. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (22901).* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ.

ОУБ Сэтгэл судлал (HL)

I хэсэг (32903)

II хэсэг (32904)

Хоёр жил, хоёр кредит

**(Хоёр жил дууссаны дараа жил
бүрээр тооцож +1.0 чанарын
оноо)**

Орох ангиуд: 11 ба 12

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Өмнөх нийгмийн ухааны багшийн бичгээр гаргасан тодорхойлолт, эсвэл багшийн зөвшөөрөл байх ёстой.

Энэхүү ОУБХ-ийн сэтгэл судлалын хичээл нь ОУБ хөтөлбөрийн шаардлагыг хангасан хоёр жилийн хугацаатай сургалт юм. Сурагчид сэтгэлзүйн 4 үндсэн өнцгийг суралцана. Үүнд: Биологийн, танин мэдэхүйн, хүмүүнлэг, сургалтын хэтийн төлөв 4 багтана. Сурагчид мөн хоёр сонголттой сэдвийг судалж, туршилтын судалгаа, санал асуулга, ажиглалтын судалгаа гэсэн гурван судалгааны ажил хийнэ. *Тус хичээл нь сурагчдыг сургалтын төгсгөлд сэтгэл судлалын чиглэлээр шаардлагатай өндөр түвшиний шалгалтанд бэлддэг. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (22903) (22904).* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ. Энэхүү дамжаа нь нийгмийн ухааны 2 кредитийг авдаг.

ОУБ Нийгмийн антропологи (SL) (32372)

Бүтэн жил, нэг кредит

(+1.0 чанарын оноо)

Орох ангиуд: 11 ба 12

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Өмнөх нийгмийн ухааны багшийн бичгээр гаргасан тодорхойлолт, эсвэл багшийн зөвшөөрөл байх ёстой.

ОУБХ-ийн Нийгмийн антропологи хичээл ОУБ хөтөлбөрийн шаардлагыг хангасан нэг жилийн сургалт бөгөөд энэ хичээл энгийн ард иргэдэд чиглэсэн соёл, нийгмийг харьцуулсан судалгааны үндсэн тулгуурсан хичээл юм. Сурагчид нийгмийн болон соёлын амьдралын ерөнхий зарчмуудыг судалж, эдгээр зарчмуудыг тодорхой нийгэм, соёлд хэрэгжүүлдэг. Тус хичээлийн агуулгань орон нутгийн болон дэлхийн хэтийн төлөвийг тодорхойлон үздэг бөгөөд хот, хөдөөгийн нийгмийг нарийн холбон судалдаг. Судалгааны сэдвүүдийн дотор ураг төрлийн харилцаа, бэлгэдэл, хэл, үндэс угсаа, хүйс, эрх мэдлийн харилцаа орно. Нийгмийн антропологи нь дайн, мөргөлдөөн, хүрээлэн буй орчин, ядуурал, шударга бус байдал, тэгш бус байдал, хүний эрх зэрэг орчин үеийн чухал асуудлуудыг ойлгоход хувь нэмэр оруулдаг. *Тус хичээл нь сурагчдыг сургалтын төгсгөлд Нийгмийн антропологи судлах стандарт түвшний ОУБХ-ийн шалгалтанд бэлддэг. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (22372).* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдсэнээр дүгнэгдэнэ.

ОУБ Нийгмийн антропологи (HL)

I хэсэг (32375)

Хоёр жил, хоёр кредит

II хэсэг (32377)

(Хоёр жил дууссаны дараа жил бүрээр тооцож +1.0 чанарын оноо)

Орох ангиуд: 11 ба 12

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Өмнөх нийгмийн ухааны багшийн бичгээр гаргасан тодорхойлолт, эсвэл багшийн зөвшөөрөл байх ёстой.

ОУБХ-ийн Дээд түвшний Нийгмийн антропологи хичээл нь ОУБ хөтөлбөрийн шаардлагыг хангасан хоёр жилийн хугацаатай сургалт юм. Нийгмийн болон соёлын антропологи нь соёл ба хүний нийгмийг харьцуулсан судалгаа юм. Сурагчид нийгмийн болон соёлын амьдралын ерөнхий зарчмуудыг судалж, эдгээр зарчмуудыг тодорхой нийгэм, соёлд хэрэгжүүлдэг. Антропологийн асуудлын сэдэв нь нийгмийн өөрчлөлт, ураг төрлийн холбоо, бэлгэдэл, солилцоо, итгэл үнэмшлийн тогтолцоо, үндэс угсаа, хүч чадлын харилцаа орно. Нийгэм, соёлын антропологи нь хот, хөдөөгийн нийгэм, орчин үеийн улс үндэстнүүдийг судалдаг. Антропологи нь дайн, мөргөлдөөн, хүрээлэн буй орчин, ядуурал, шударга бус байдал, тэгш бус байдал, хүний, соёлын эрх гэх мэт орчин үеийн асуудлуудыг ойлгоход чиглэгдэнэ. Дээд түвшний сурагчид сургалтын хөтөлбөрийн нэмэлт хэсэг болох Антропологийн онолын хэтийн төлөвийг судлах болно. Сурагчид 1-р шалгалт (асуулт 2 ба 3), 2 ба 3р шалгалтуудын асуултанд хариулахдаа онолын мэдлэгээ багтаасан байх ёстой. HL түвшний сурагчид хэргийн судалгаа хийж тайлагнах нь SL сурагчид ажиглалт хийж, тайлагнах, шүүмжлэх чадварыг суралцдаг. *Тус хичээл нь сурагчдыг сургалтын төгсгөлд Нийгмийн антропологийн чиглэлээр шаардлагатай HL шалгалтанд бэлддэг. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (22374) (22377).* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдсэнээр дүгнэгдэнэ.

4-р бүлэг

Туршилтын шинжлэх ухаан

ОУБ Биологи (SL)

(34378)

**Бүтэн жил, нэг кредит
(+1.0 чанарын оноо)**

Орох ангиуд: 11 ба 12

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Биологи I ба Химийн хичээлийг дүүргэсэн байх ёстой.

Энэ дамжаа нь эс, молекул биологи, генетик, экологи, хувьсал ба биологийн олон янз байдал, хүний физиологийн талаархи судалгааг багтаана. Мөн түүнчлэн SL түвшний сурагчид долоон сонголтын сэдвээс хоёрыг нь судалдаг. Шүүмжлэлт сэтгэлгээ, шинжлэх ухааны онолыг ойлгох, туршилт хийхэд анхаарлаа хандуулах болно. *Тус хичээл нь сурагчдыг сургалтын төгсгөлд өгөх ёстой Биологийн чиглэлээр шаардлагатай Стандарт түвшний ОУБХ-ийн шалгалтанд бэлддэг. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (24378).* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдсэнээр дүгнэгдэнэ.

**ОУБ Биологи (HL)
Лабораторийн анги
Орох ангиуд: 11-12**

**I хэсэг (34376)
II хэсэг (34377)**

**Хоёр жил, хоёр кредит
(Хоёр жил дууссаны дараа жил
бүрээр тооцож +1.0 чанарын
оноо)**

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Биологи I ба Химийн хичээлийг дүүргэсэн байх ёстой.

ОУБ Биологи HL хичээл нь эрэл хайгуулд суурилсан шинжлэх ухааны анги бөгөөд амьдралыг янз бүрийн түвшинд судалдаг бөгөөд бичгэн харилцаагаар гол төлөв явагддаг. Амьд системийг молекулын түвшингээс дэлхийн түвшинд судлах бөгөөд үүнд амьдралын биохимийн процессууд, эсийн бүтэц, үйл ажиллагаа, гомеостаз, генетик ба генетикийн инженерчлэл, хувьсал, ангилал зүй ба харьцуулсан анатоми, нөхөн үржихүй ба хөгжил, хүрээлэн буй орчин, экосистем, хүн амын судалгаа, хүний системийн бүтэц, үйл ажиллагаа багтана. Энэ ангид хамрагдснаар лабораториудад ажиллаж, бие даасан судалгааны төсөл гүйцэтгэх шаардлагатай. Эхний жилийг үндэс болгон ашиглаж, хоёр дахь жил нь I хэсэгт дурдсан зарчмуудыг илүү гүнзгий судалж, хэрэгжүүлэх боломжийг олгодог. Амьд системийг молекулын түвшингээс дэлхийн түвшинд үргэлжлүүлэн судална. Хоёр жилийн сургалтын хоёр дахь жилийн судалгаа нь амьдралын биохимийн процесс, гомеостаз, ургамлын биологи, хувьсал, ангилал зүй ба харьцуулсан анатоми, үржил, хөгжил, хүний тогтолцооны бүтэц, үйл ажиллагааг хамардаг. Тус хичээлд статистик дүн шинжилгээ, бие даасан судалгааг багтаасан лабораторийн албан ёсны тайлан шаардагдана. Энэхүү хичээл нь сурагчдыг төгсөх жилийн төгсгөлд өгөх ёстой Биологийн чиглэлээр шаардлагатай Дээд түвшний ОУБХ-ийн шалгалтанд бэлддэг. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (24376) (24377). Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ.

**ОУБ Хими (HL)
Лабораторийн анги
Орох ангиуд: 11-12**

**I хэсэг (34476)
II хэсэг (34477)**

**Хоёр жил, хоёр кредит
(Хоёр жил дууссаны дараа жил
бүрээр тооцож +1.0 чанарын
оноо)**

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Хэвийн болон Түргэвчилсэн хөтөлбөртэй Хими мөн Алгебр II хичээлд В болон түүнээс дээш үнэлгээтэй; эсвэл багшийн зөвшөөрөлтэй байх ёстой. I хэсгийн эхэнд зуны даалгаврыг биелүүлэх ёстой.

Төв шинжлэх ухаан буюу хими нь академик судалгааг практик болон эрэн сурвалжлах чадварыг эзэмшихийг шаарддаг туршилтын шинжлэх ухаан юм. Тус хичээл нь ОУБ хөтөлбөрийн зорилгод нийцсэн хоёр жилийн хугацаатай сургалт юм. Энэ хичээл нь өндөр сахилга баттай, сониуч Сурагчдад туршилтын ур чадварыг хөгжүүлэх, шинжлэх ухааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх, үнэлэх өргөн боломжийг олгоход зориулагдсан болно. Судалгааны сэдвүүдэд атомын онол, үечлэл, холбоо, энерги, кинетик, тэнцвэр, хүчил ба суурь, электрохими, органик хими, тоон хими, мэдээлэл боловсруулах зэрэг орно. Тус хичээлд Анагаах ухаан ба эм, Аналитик хими, Байгаль орчны хими, Бүтээлийн хими, Хүний биохими, Хүнсний хими эсвэл Цаашдын органик хими зэрэг хоёр нэмэлт сэдвийг багтаана. Сурагчид салбар дундын 4-р бүлгийн төсөл, бие даасан судалгааны төсөл хэрэгжүүлэх шаардлагатай. ОУБ Хими (HL) хичээлийн 2-р хэсгийн үеэр сурагчид химийн сэдэв тус бүр дээр дээд түвшний нэмэлт материалыг судалж, Олон Улсын Бакалавриатын Байгууллагын шаардлагыг бүрэн хангана. Энэ хичээлийн хоёрдугаар хэсэг нь сурагчийн жилийн эцэст өгөх шаардлагатай химийн чиглэлийн өндөр түвшний ОУБХ-ийн шалгалтанд бэлддэг. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (24476) (24477). Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссан бөгөөд ОУБХ-ийн шалгалтаа өгсний дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ. Шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй.

**ОУБ Компьютерын шинжлэх
ухаан (SL)**

**I хэсэг (36540)
II хэсэг (36550)**

**Хоёр жил, хоёр кредит
(Хоёр жил дууссаны дараа жил
бүрээр тооцож +1.0 чанарын
оноо)**

Орох ангиуд: 11-12

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Алгебр II хичээлийг В боолон түүнээс дээш дүнтэй төгссөн байх ёстой.

ОУБ Компьютерын шинжлэх ухаан хичээл нь коллежийн түвшний сургалтын хөтөлбөр (CSI ба CS2)-ийг багтаасан хоёр жилийн сургалт юм. Сурагчид тооцоолох сэтгэлгээний үндсэн ойлголтуудын талаархи ойлголтоо хөгжүүлэхээс гадна компьютер болон бусад дижитал төхөөрөмжүүд хэрхэн ажилладаг талаар мэдлэгийг олж авах болно. Тус хичээл нь сурагчдыг жилийн эцэст өгөх шаардлагатай Компьютерийн шинжлэх ухааны стандарт түвшний ОУБХ-ийн шалгалтанд бэлддэг. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (26540) (26550). Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа

эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ. Тус хичээлийн агуулгань Ажил мэргэжил ба Техникийн//Дүрслэх Урлагийн кредитийг олгодог. *Хичээлийн сегментийг онлайнаар заах бөгөөд ингэснээр виртуал дамжааны төгсөлтийн шаардлагыг мөн хангана.*

ОУБ Компьютерын шинжлэх ухаан (HL)

I хэсэг (36560)

Хоёр жил, хоёр кредит

II хэсэг (36570)

(Хоёр жил дууссаны дараа жил бүрээр тооцож +1.0 чанарын оноо)

Орох ангиуд: 11-12

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Алгебр II хичээлийг B боолон түүнээс дээш дүнтэй төгссөн байх ёстой.

ОУБ Компьютерын шинжлэх ухаан хичээл нь Америкийн Мэдээлэл Боловсруулах Нийгэмлэгүүдийн Холбоо (AFIPS) дахь Компьютерийн машин механизмын холбоо (АСМ) болон бусад нийгэмлэгийн зөвлөсөн коллежийн түвшний сургалтын хөтөлбөр (CSI ба CS2) -ийг хамарсан хоёр жилийн сургалт юм. Компьютерийн програмчлалын хэл Java програмыг судална. *Энэхүү курс нь сурагчдыг жилийн эцэст өгөх шаардлагатай Компьютерийн ухааны дээд түвшний ОУБХ-ийн шалгалтанд бэлддэг. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (26560) (26570).* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ. Тус хичээлийн агуулгань Ажил мэргэжил ба Техникийн//Дүрслэх Урлагийн кредитийг олгодог. *Хичээлийн сегментийг онлайнаар заах бөгөөд ингэснээр виртуал дамжааны төгсөлтийн шаардлагыг мөн хангана.*

ОУБ Дизайн технологи (SL)

I хэсэг (38496)

Хоёр жил, хоёр кредит

II хэсэг (38497)

(Хоёр жил дууссаны дараа жил бүрээр тооцож +1.0 чанарын оноо)

Орох ангиуд: 11-12

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Байхгүй.

Дизайн гаргана гэдгийг “аливаа зүйлийн тухай оюун санаандаатөлөвлөгөө зохиох” гэж тодорхойлж болно. Дизайн нь хүрээлэн буй ертөнцийн талаархи мэдээллийг цуглуулах, тэрхүү мэдээллийг боловсруулах, тэнд байгаа зүйлийг өөрчлөх, төлөвлөгөө боловсруулах эсвэл шинэ зүйлийг нэвтрүүлэхээс бүрдэнэ. Дизайнер нь материаллаг орчны талаар мэдлэгтэй байхаас гадна хүмүүсийн аж амьдралд шууд нөлөөлдөг улс төр, нийгэм, эдийн засгийн талаар ойлголттой байх ёстой. Дизайн технологи хичээл нь мэдлэг, ур чадвар, дизайны зарчмуудыг асуудлыг шийдвэрлэх, нөхцөл байдалд шингээж, орон нутгийн болон бэлэн байгаа нөөцийг дээд зэргээр тулган ашиглах сургалтын загвар дээр суурилдаг. Дизайны өмнөх мэдлэг, туршлагагүй хүн суралцаж болно. Дизайны мөчлөг нь хичээлийн гол цөм бөгөөд сурагчид энэ үйл явцыг онолын зэрэгцээ эрэн сурвалжлан таниж мэдэх үйл явцдаа ашигладаг. Сурагчид дизайны төсөл, практик үйл ажиллагаа, бүртгэлийн дэвтэрийг бөглөх шаардлагатай болно. *Тус хичээл нь сурагчдыг Дизайн технологийн чиглэлээр шаардлагатай стандарт түвшний ОУБХ-ийн шалгалтанд бэлддэг. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (28496) (28497).* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ.

ОУБ Байгаль орчны систем ба Нийгэмлэг (SI)

(34275)

Бүтэн жил, хоёр блок цагаар, хоёр кредит, (нэмэлт +1.0 чанарын оноо)

Лабораторийн хичээл

Орох ангиуд: 11 ба 12

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Өмнөх шинжлэх ухааны хичээлүүдийн дундаж үнэлгээ B-гээс доошгүй эсвэл багшийн тодорхойлолт, багшийн зөвшөөрөлтэй байх ёстой.

Байгаль орчны систем ба нийгэмлэгүүд нь салбар дундын (3 ба 4 багаар) стандарт түвшний сургалт юм. Хичээлийн зорилго нь Сурагчдад хүрээлэн буй орчны тогтолцоо ба нийгэм хоорондын харилцан уялдаатай байдлыг уялдуулан харуулах боломжийг олгоход оршино. Судалгааны сэдвүүдэд систем, загвар, экосистем, хүн амын тоо, даац, нөөцийг ашиглах, хамгаалах, биологийн олон талт байдал, бохирдлын менежмент, дэлхийн дулаарлын асуудал, хүрээлэн буй орчны үнэ цэнийн тогтолцоог багтаасан болно. Тус хичээл нь байгаль орчны үйл явцын талаархи ойлголтыг орон нутгаас дэлхийн хэмжээнд хүртэл сурталчлах, хүрээлэн буй орчны асуудлуудад дүн шинжилгээ хийхэд ашиглаж болох мэдлэг, арга зүй, ур чадварыг Сурагчдад бий болгох зорилготой. Сургалт нь салбар тус бүрээр явагддаг тул Сурагчдад 3 ба 4-р зургаан өнцөгт багаар тавигдах

шаардлагыг санал болгодог тул Сурагчдад аль нэг зургаан өнцөгт бүлгээс өөр хичээл, түүний дотор 3 эсвэл 4-р бүлгийн өөр хичээлийг судлах боломжийг олгодог. *Тус хичээл нь сурагчдыг хичээлийн төгсгөлд авах шаардлагатай Байгаль орчны систем ба нийгэмлэгийн стандарт түвшний ОУБХ-ийн шалгалтанд бэлддэг. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (24275).* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ.

ОУБ Физик (SL)
Лабораторийн анги
Орох ангиуд: 11-12

I хэсэг (34576)
II хэсэг (34577)

Хоёр жил, хоёр кредит
(Хоёр жил дууссаны дараа жил бүрээр тооцож +1.0 чанарын оноо)

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Алгебр II хичээл дээр B ба түүнээс дээш, эсвэл Түргэвчилсэн хөтөлбөртэй Алгебр II хичээл дээр C буюу түүнээс дээш үнэлгээтэй байх ёстой.

Бусад бүх шинжлэх ухаанд үндэслэсэн суурь шинжлэх ухаан болох физик нь сурагчид өөрсдийн хүрээлэн буй физик ертөнцийн математик илэрхийлэлийг таньж мэдэхээс гадна физик нь орчлон ертөнцийн математик тодорхойлолт гэдгийг ойлгуулах зорилготой юм. Тус хичээл нь ОУБ хөтөлбөрийн зорилгод нийцсэн хоёр жилийн хугацаатай сургалт юм. Сургуульд туршид сурч байсан математикийн хичээлийн мэдлэгээ ашиглан сурагчид сонгодог механик, дулааны физик, цахилгаан ба соронзон, долгион ба энгийн гармоник хөдөлгөөн (үүнд дуу, гэрэл орно), атом ба цөмийн физик, харьцангуйн зэрэг үндсэн сэдвүүдийг судалдаг. Хичээл нь долгионы үзэгдэл ба астрофизик гэсэн нэмэлт хоёр сэдвээр төгсөх бөгөөд үндсэн сэдвүүдийг бүрэн гүйцэд судлах шаардлагатай. ОУБ Физик хичээл нь физик системийн математик загварыг боловсруулахад лабораторийн туршлага, өгөгдлийг цуглуулах, тайлбарлах, тэдгээрийн танилцуулгыг ашиглахыг чухалчилдаг. Сурагчид Вашингтон Либерти сургууль дахь бусад ОУБХ-ийн Шинжлэх ухааны ангиудтай хамтран салбар дундын 4-р бүлэгт хамаарах төслийг хэрэгжүүлэх шаардлагатай. ОУБ физикийн ангийн сурагчид 1-р жилийн эцэст үндсэн сэдвүүдийн дагуу цогц шалгалт өгөх болно. *2-р жилийн 5-р сард сурагчид дэлхий даяар Физик хичээлийн сонгон судалж байгаа сурагчдын өгдөг физикийн анхан шатны ОУБ түвшний шалгалтыг өгнө. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (24576) (24577).* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ.

ОУБ Спорт, Дасгал ба Эрүүл мэндийн Шинжлэх ухаан (SL)
Орох ангиуд: 11-12

I хэсэг (38055)
II хэсэг (38057)

Хоёр жил, хоёр кредит
(Хоёр жил дууссаны дараа жил бүрээр тооцож +1.0 чанарын оноо)

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Өмнөх шинжлэх ухааны хичээлүүдийн дундаж үнэлгээ B-гээс доошгүй эсвэл багшийн тодорхойлолт

ОУБ Спорт, Дасгал, Эрүүл мэндийн шинжлэх ухааны SL хичээл нь анатоми ба физиологи, биомеханик, сэтгэл судлал, хоол тэжээлийн уламжлалт салбаруудыг спорт, дасгал, эрүүл мэндийн хүрээнд судалдаг. Сурагчид үндсэн болон сонголтоор олон сэдвийг сонгож лабораторийн болон практик (туршилтын) судалгаа явуулна. Энэ хичээл нь шинжлэх ухааны зарчмууд, хувь хүний гүйцэтгэлд шүүмжлэлтэй дүн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдлэг, ойлголтыг олж авах боломжийг олгоно. Холбогдох тохиолдолд энэ хичээл нь аливаа хүний спорт, биеийн тамир, эрүүл мэндийн үзүүлэлтийг дэлхийн хэмжээнд харьцуулан авч үзэн интернационализм ба ёс зүйн асуудлыг хөндөх болно. *Тус хичээл нь сурагчдыг сургалтын төгсгөлд авах шаардлагатай Спорт, Дасгал, Эрүүл мэндийн шинжлэх ухааны стандарт түвшний шалгалтанд бэлтгэнэ. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (28055) (28057).* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ.

Математик

ОУБ Математик: Хэрэглээ ба тайлбар (SL) (33170)

Нийгэмлэг (SI)

Орох ангиуд: 11 ба 12

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.
Элсэхээс өмнөх шаардлага: Алгебр III ба өмнөх математикийн хичээлүүдэд В-ээс дээш оноо авсан эсвэл багшийн тодорхойлолт.

ОУБ Математик: Математикийн бодит хэрэглээ ба тайлбар хичээл нь математикийн утга агуулгыг агуулгаар нь онцолсон сургалт юм. Тус хичээл нь манай ертөнцийг дүрслэх, практик асуудлыг шийдвэрлэхэд зориулагдсан математикаа хөгжүүлэх сонирхолтой Сурагчдад зориулагдсан болно. Сурагчид дараахь математикийн сэдвүүдийг судалж үздэг. Үүнд: Тооны онол ба алгебр, геометр ба тригонометр, статистик ба магадлал, функцууд, танилцуулах дифференциал тооцоолол багтана. Сэдвүүд нь үндсэн ойлголтуудтай уялдан холбогддог. ОУ-ын шаардлагын дагуу сурагч бүр бие даасан эрэл хайгуул хийж гүйцэтгэсэн бие даалт ажил хураалгана. *Тус хичээл нь сурагчийн Хэрэглээ тайлбар хичээлийн чиглэлээр шаардлагатай Стандарт түвшний ОУБХ-ийн шалгалтанд бэлдэх болно. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (23170).* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ.

ОУБ Математик: Анализ ба Хандлага (SL) I хэсэг (33171)
II хэсэг (33172)

Орох ангиуд: 11 ба 12

Бүтэн жил, нэг кредит
(Хоёр жил дууссаны дараа жил бүрээр тооцож +1.0 чанарын оноо)

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.
Элсэхээс өмнөх шаардлага: Түргэвчилсэн хөтөлбөртэй Алгебр II хичээл дээр В ба түүнээс дээш дүнтэй эсвэл багшийн тодорхойлолт.

ОУБ Математик: Анализ ба хандлага (SL) хичээл нь Сурагчдад дараахь математикийн сэдвүүдийг судлах боломжийг олгох зорилготой хичээл юм. Үүнд тооны онол ба холбогдох сэдэв, алгебр, геометр ба тригонометрийн сэдэв, вектор, матриц, магадлал, статистик, функц багтана. Хоёр дахь жилийн сургалтын агуулгад нэг хувьсагчийн тооцооллын тухай ойлголтыг судлах ба Ахисан түвшний Анализийг багтаана. Шинжилгээ ба хандлага хичээлийн шалгалт. Сурагчид ОУБ Математикийг дүүргэх ёстой: Шинжилгээ ба хандлага II хичээлд хамрагдахын тулд I хэсгийг С ба түүнээс дээш үнэлгээтэй дүүргэх шаардлагатай. ОУБ-ийн хөтөлбөрийн дагуу бие даах ажлыг хичээлийн 2-р жилд сурагч бүр хийж гүйцэтгэнэ. Хувь хүний математикийн хайгуулыг бие даалтын сэдэв болгон өгнө.

Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (23171 (23172)). Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ.

ОУБ Математик: Анализ ба Хандлага (HL) I хэсэг (33181)
II хэсэг (33182)

Орох ангиуд: 11 ба 12

Хоёр жил, хоёр кредит
(Хоёр жил дууссаны дараа жил бүрээр тооцож +1.0 чанарын оноо)

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.
Элсэхээс өмнөх шаардлага: Түргэвчилсэн хөтөлбөртэй Анхан шатны Анализ/ОУБ Математикийг амжилттай дүүргэсэн байх ёстой. Стандарт түвшний Анализ ба хандлага хичээлийн I-р жилд В ба түүнээс дээш үнэлгээ авсан эсвэл багшийн тодорхойлолт; болон өмнөх математикийн хичээлүүдийн дунджаар В-ийн дундаж буюу түүнээс дээш үнэлгээтэй байх.

ОУБ Математик: Анализ ба Хандлага HL хичээл нь тун чанга хуваарьтай хоёр жилийн хугацаатай сургалт юм. Эхний жил нь функц, графикийн хязгаар ба тасралтгүй байдал, дифференциал тооцоолол, дифференциал хэрэглээ, интеграл тооцоолол, салшгүй хэрэглээ, дараалал ба цуврал зэрэг тооцооллын сэдвүүдийг багтаасан болно. Сэдвүүдэд алгебр, аксиоматик геометр, тригонометр ба аналитик геометрийн талаархи нарийн мэдлэг олгох агуулгууд багтана. ОУБ Математикийн хоёр дахь жил: Шинжилгээ ба хандлагын HL нь векторууд, хувиргалт, цогц тоо, магадлал ба статистик, функц ба тэгшитгэл, дугуй функц ба тригонометр ба вектор геометр зэрэг сэдвүүдийг үзнэ.

ОУБ Математик: Анализ, хандлага HL суурьтай тус хичээл нь коллежийн түвшний гүйцэтгэл, ажлын дадал зуршлыг шаарддаг. Ахлах ангийн сүүлийн жилийн төгсгөлд таван цаг үргэлжлэх ОУБХ-ийн шалгалт өгдөг бөгөөд дүнгийн наян хувийг уг шалгалтын дүн бүрдүүлдэг. ОУБ хөтөлбөрийн шаардлагын дагуу бие даах ажлыг

хичээлийн 2-р хэсэгт сурагч тус бүр хийж гүйцэтгэнэ. Хувь хүний математикийн хайгуулыг бие даалтын эдэв болгон өгөх бөгөөд дүнгийн 20%-ийг бүрдүүлнэ. *Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (23181) (23182)* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ.

6-р бүлэг

Урлаг

ОУБ Кино (SL)

I хэсэг (31144)

Хоёр жил, хоёр кредит

II хэсэг (31145)

(Хоёр жил дууссаны дараа жил бүрээр тооцож +1.0 чанарын оноо)

Орох ангиуд: 11 ба 12

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Өмнөх англи хэлний багийн бичгээр гаргасан тодорхойлолт эсвэл багийн зөвшөөрөл.

ОУБ Кино хичээл нь ОУБ хөтөлбөрийн шаардлагыг хангасан хоёр жилийн хөгжлийн сургалт юм. Тус хичээл нь сурагчдын ур чадварыг хөгжүүлэхэд чиглэгддэг бөгөөд ингэснээр тэд кино урлагийг бүтээж байж олж авдаг практик үйл ажиллагааны үр дүнд олж авсан ойлголтын ил тод байдал, шүүмжлэлт сэтгэлгээ, тусгалтай дүн шинжилгээ, үр дүнтэй оролцоо, уран сэтгэмжийн чадварыг эзэмшиж чаддаг. Тус хичээл нь кино зохиол дахь киноны текст, дасгалыг судлах, дүн шинжилгээ хийх замаар Сурагчдад киноны түүхийг судлах, мэдлэгийн онолын үндсэн зарчимтай харилцан уялдаа холбоо тогтоох, олон төрлийн кино хийх, хөгжүүлэх, бүтээлчээр хэрэгжүүлэх боломжийг олгодог. ОУБ Кино ангийн сурагчид хичээлийн туршид киноны хэлээр тайлбарлах, харилцах үйл явцыг ойлгох, оролцуулах чадварыг хөгжүүлж, киног хувийн, онолын, соёлын хүрээнд судалж, эдгээр нөхцөл байдал нь кино хийх дадлага, хүлээн авалтыг хэрхэн мэдээлж, хэлбэржүүлдэг талаархи ойлголтыг нэгтгэдэг. Сурагчдыг гаднаас ОУБХ, дотроос багш үнэлгээ тавина. Эдгээр нь ОУБХ-ийн шалгалтын ерөнхий онооны тавин хувийг эзэлж байна. *Тус хичээл нь сурагчдыг хоёр жилийн сургалтын эцэст шаардагдах Стандарт түвшний үнэлгээнд бэлтгэдэг. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (21144) (21145).* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ. Тус хичээлийн агуулгань Ажил мэргэжил ба Техникийн/Дүрслэх Урлагийн кредитийг олгодог.

ОУБ Кино (HL)

I хэсэг (31147)

Хоёр жил, хоёр кредит

II хэсэг (31149)

(Хоёр жил дууссаны дараа жил бүрээр тооцож +1.0 чанарын оноо)

Орох ангиуд: 11 ба 12

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Өмнөх англи хэлний багийн бичгээр гаргасан тодорхойлолт эсвэл багийн зөвшөөрөл.

ОУБ Кино хичээл нь ОУБ хөтөлбөрийн шаардлагыг хангасан хоёр жилийн хөгжлийн сургалт юм. ОУБ Кино хичээл нь сурагчдын ур чадварыг хөгжүүлэхэд чиглэгддэг бөгөөд ингэснээр тэд кино зохиол бичих, тайлбарлах чадварыг эзэмшдэг. Кино зохиол дахь киноны текст, дасгалыг судлах, дүн шинжилгээ хийх замаар Тус хичээл нь киноны түүх, онол, нийгэм, эдийн засгийн үндэслэлийг судалдаг. Кино урлагийн чиглэлээр суралцаж буй бүх сурагчид бие дааж судалгаа хийх, бичих, практик төсөл хэрэгжүүлэх, ОУБ-аас тогтоосон киноноос таван минутын хэсгийг нягт нямбай шинжилсний үндсэн дээр аман танилцуулга хийх ёстой. Хичээлийн хоёрдугаар хэсэг нь Сурагчдад бүтээлч ур чадвар, онолын ойлголт, текстэн анализыг илүү бүрэн дүүрэн хөгжүүлэх боломжийг олгодог. Хоёрдугаар хэсэг нь фолио хальс хөгжүүлэхэд зориулагдсан болно. Сурагчдыг гаднаас ОУБХ, дотроос багш үнэлгээ тавина. Эдгээр нь ОУБХ-ийн шалгалтын ерөнхий онооны тавин хувийг эзэлж байна. *Тус хичээл нь сурагчдыг хоёр жилийн сургалтын явцад шаардагдах дээд түвшний үнэлгээнд бэлтгэдэг. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (21147) (21149).* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ. Тус хичээлийн агуулгань Ажил мэргэжил ба Техникийн/Дүрслэх Урлагийн кредитийг олгодог.

ОУБ Хөгжим (SL)

(39227)

Бүтэн жил, нэг кредит

(+1.0 чанарын оноо)

Орох ангиуд: 11 ба 12

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Ахлах сургуулийн хөгжмийн сургалтанд нэг жил хамрагдсан байх ба эсвэл багшийн зөвшөөрөл.

Сурагчид хөгжмийн үндсийг сайн мэддэг, ангидаа элсэхийн тулд дор хаяж нэг нот хөгжим уншиж чаддаг байх ёстой. Энэ хичээл сурагчид олон үндэсний соёл, цаг үеийн хөгжмийг судалж, хөгжмийн бүтэц, нийгмийн холбоосыг бүрэн ойлгох болно. Сурагчид өөрсдөө бүтээл туурвих болно. Нэмэлтээр хувийн давтлага авч болох бөгөөд заавал авах шаардлагагүй юм. Сурагчид тэдний ажлын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор компьютерын M.I.D.I. програм ашигладаг. *Бичгийн шалгалтаас гадна сурагчид бүтээлийг буюу гүйцэтгэлийг үзүүлэх шаардлагатай. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (29227).* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ. Энэ хичээлээс Урлагийн 1 кредит авна.

ОУБ Театрын урлаг (SL)

(39141)

Бүтэн жил, нэг кредит

(+1.0 чанарын оноо)

Орох ангиуд: 11 ба 12

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Драммын аливаа хичээлийг (технологийн театр орно) С эсвэл түүнээс дээш дүнтэй амжилттай төгссөн байх; ба/эсвэл багшийн тодорхойлолт.

Театрын урлаг дахь хөтөлбөрийн зорилго нь Сурагчдад театрын мөн чанарыг ойлгуулах, түүнийг бүтээхээс гадна судлах замаар ойлгоход нь туслах, оюун ухаанаар төдийгүй мэдрэхүй, бие махбодь, сэтгэл хөдлөлөөрөө өөрсдийн соёлоос бусад соёлд шаардлагатай хэлбэрийг ойлгох, энэ ойлголтоор дамжуулан өөрсдийгөө, нийгэм, ертөнцийг илүү сайн ойлгоход туслах явдал юм. Стандарт түвшний хөтөлбөр нь заавал байх ёстой дөрвөн хэсгээс бүрдэнэ. Тоглолтын ур чадвар, Дэлхийн театр судлал, Тоглоомын практик анализ, Театрын бүтээл 4 юм. Тус хичээл нь сурагчдыг сургалтын төгсгөлд шаардлагатай Стандарт түвшний үнэлгээнд бэлтгэх бөгөөд театрын урлаг суралцагчид яаж нөлөөлсөн тухай 1750 үг бүхий судалгааны материал, аман танилцуулга (хамгийн ихдээ 15-20 минутын зайтай), 3000 орчим үгтэй портфолио бэлтгэсэн байна.

Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (29141). Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ. Энэ хичээлээс Урлагийн 1 кредит авна.

ОУБ театрын урлаг (HL)

I хэсэг (31942)

Хоёр жил, хоёр кредит

II хэсэг (39143)

(Хоёр жил дууссаны дараа жил бүрээр тооцож +1.0 чанарын оноо)

Орох ангиуд: 11 ба 12

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Драммын аливаа хичээлийг (технологийн театр орно) С эсвэл түүнээс дээш дүнтэй амжилттай төгссөн байх; ба/эсвэл багшийн тодорхойлолт.

Театрын урлаг дахь хөтөлбөрийн зорилго нь Сурагчдад театрын мөн чанарыг ойлгуулах, түүнийг бүтээхээс гадна судлах замаар ойлгоход нь туслах, оюун ухаанаар төдийгүй мэдрэхүй, бие махбодь, сэтгэл хөдлөлөөрөө өөрсдийн соёлоос бусад соёлд шаардлагатай хэлбэрийг ойлгох, энэ ойлголтоор дамжуулан өөрсдийгөө, нийгэм, ертөнцийг илүү сайн ойлгоход туслах явдал юм. Дээд түвшний сургалтын хөтөлбөр нь заавал хэрэгжүүлэх таван хэсгээс бүрдэнэ. Гүйцэтгэх ур чадвар, Дэлхийн театр судлал, Тоглоомын практик анализ, Театрын бүтээл, Хувь хүний төсөл зэрэг орно. Тус хичээл нь сурагчдыг сургалтын төгсгөлд шаардлагатай Стандарт түвшний үнэлгээнд бэлтгэх бөгөөд театрын урлаг суралцагчид яаж нөлөөлсөн тухай 2500 үг бүхий судалгааны материал, аман танилцуулга (хамгийн ихдээ 20-30 минутын зайтай), 4500 орчим үгтэй портфолиос бэлтгэсэн байна. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (29142) (29143). Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ. Тус хичээл нь Дүрслэх урлагийн 2 кредитийг олгоно.

ОУБ Визуал урлаг

(39144)

Бүтэн жил, нэг кредит

(+1.0 чанарын оноо)

Орох ангиуд: 11 ба 12

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: Урлаг II хичээлийг амжилттай төгссөн эсвэл багийн зөвшөөрлөөр элсэж болно.

Сурагчид урлагийн үйл явц, гоо зүйн асуудал, урлагийн шүүмжлэл, урлагийн түүх, соёлын талаархи дэвшилтэт судалгаанд оролцож, мэдлэг хуримтлуулна. Тэд өөрсдийн судалгаагаар сонгосон сэдвүүдийг хэрхэн яаж ойлгож хүлээж авснаа аман, бичгийн болон график хэлбэрээр үзүүлдэг. Судалгааг нотолсон судалгааны ажлын дэвтэр багш, сурагчийн тохиролцсон газарт заавал байх ёстой. *Бие даах ажлаар үнэлгээ дүгнэгдэх бөгөөд сурагч хүсвэл үзэсгэлэн гаргаж үнэлгээгээ нэмэгдүүлж болно. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй (29144).* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ. Тус хичээл нь Дүрслэх урлагийн 1 кредитийг олгоно.

ОУБ Визуал урлаг (HL)

I хэсэг (39146)

Хоёр жил, хоёр кредит

II хэсэг (39148)

(Хоёр жил дууссаны дараа жил бүрээр тооцож +1.0 чанарын оноо)

Орох ангиуд: 11 ба 12

Тавигдсан шаардлагыг хангасан Вашингтон Либерти сургуулийн 11, 12-р ангийн бүх Сурагчдад нээлттэй.

Элсэхээс өмнөх шаардлага: ОУБХ-ийн хүлээлттэй тохирох чадварыг харуулсан ажлаа үнэлүүлэх, шалгуулах эсвэл багийн зөвшөөрөл байх шаардлагатай.

Тус хичээл нь 240 цагийн (хоёр жил буюу түүнтэй тэнцэхүйц) үргэлжлэх бөгөөд нийт цагийн хагаст нь багш, сурагчийн тохиролцсон чиглэлээр хийсэн чухал судалгааны ажлыг нотлох судалгааны ажлын дэвтэр хөтлөнө. Сургалтын нөгөө хагаст нь энд тэндэхийн орчин, техник хэрэгслийг ашиглан бүтээлээ студид үйлдвэрлэх явдал юм. Энэхүү 240 цагийн хичээлийн дундуур үзмэр, үзэсгэлэн гаргах шаардлагатай. ОУБ Урлаг хөтөлбөрийн хүрээнд тасралтгүй хөгжихийг хүсэж байгаа сурагчид энэ хичээл нь хоёр жилийн хугацаатай үүрэг хариуцлага гэдгийг ойлгох хэрэгтэй. Тус хичээлд скетч дэвтэр, Тайлбар, студи зэрэг нь хоорондоо харилцан уялдаатай болно. *Бие даах ажлаар үнэлгээ тавигдах боловч үзэсгэлэн гаргаж үнэлгээ гаргуулах шаардлагатай. Үзэсгэлэнд оролцоогүй сурагчид нэмэлт чанарын оноо авах боломжгүй (29146) (29148).* Энэхүү ОУБХ-ийн хичээл нь хичээл дууссаны дараа эцсийн дүн дээр чанарын 1.0 онооны нэмэгдснээр дүгнэгдэнэ. Энэ хичээл нь Дүрслэх урлагийн кредит олгодог.

ОУБХ-ийн диплом олгох нэмэлт шаардлага

Мэдлэгийн онол (32605) Бүтэн жил, нэг кредит, +1.0 чанарын оноо

Орох ангиуд: 12

Зөвхөн Вашингтон Либертид суралцдаг 12-р ангийн ОУБХ-ийн бүрэн зэрэг горилогчдоод нээлттэй.

Мэдлэгийн онол хичээл нь ОУБ-ийн боловсролын философийн гол элемент юм. Үүний зорилго нь ангид болон гадуур олж авсан мэдлэг, туршлагын талаархи шүүмжлэлт эргэцүүллийг өдөөх, мэдлэг, туршлагын суурийг үнэлэх, нотлох баримт, маргааныг шүүмжлэн судлах үндсэн дээр хувийн бодлыг төлөвшүүлэхэд оршино. Мэдлэгийн онолын ОУБХ-ийн албан ёсны үнэлгээнд танилцуулга (дотоод үнэлгээ) ба тогтоосон сэдэвт үндэслэсэн эссе багтана (гаднаас үнэлнэ). Хичээлийн дүнг багш тодорхойлдог бөгөөд олон янзын дотоод үнэлгээ багтдаг. Бие даалтаа өгөөгүй эсвэл шалгалтанд хамрагдаагүй сурагчид нэмэлт чанарын оноо тооцуулах боломжгүй

ВАШИНГТОН-ЛИБЕРТИД САНАЛ БОЛГОЖ БУЙ БУСАД АХИСАН ТҮВШНИЙ ХИЧЭЭЛҮҮД

Ахисан түвшний консалтинг (20184)

Бүтэн жил, нэг хугацаа, нэг кредит, Орох ангиуд: 11-12

Элсэхээс өмнөх шаардлага: Ахисан түвшний анхны эсвэл ахисан шатны 2 дахь ангид хамрагдаж, ахисан шатны диплом авахаар явж байгаа сурагчид

- Унших, тайван судлах
- Ахисан түвшний сэдэвтэй холбоотой асуудлаар бусдад заах/ганцаарчилсан тусламж үзүүлэх
- Гэрийн даалгавар, нөхөх ажил
- Судалгааны бүлэг байгуулах
- Ахисан түвшний шалгалтын тухай тойм ярилцлага хийх
- PSAT//SAT семинар
- Ахисан түвшний хичээлийг даван туулах семинар (жишээлбэл, цаг хугацаа, зохион байгуулалтын ур чадвар, стресс менежмент гэх мэт)
- Коллеж төлөвлөлтийн семинар

ВАШИНГТОН-ЛИБЕРТИД САНАЛ БОЛГОЖ БАЙГАА АХИСАН ТҮВШНИЙ БУС ХИЧЭЭЛҮҮД

Африк Америкийн уран зохиол (21064)**Бүтэн жил, нэг кредит****Орох ангиуд: 10-12**

Африк Америкчуудын уран зохиолын хичээл нь Африк гаралтай Америк зохиолчдын яруу найраг, уран зохиол, жүжиг, намтар зэрэг төрөл бүрийн жанрын бүтээлүүдийн танилцуулга хичээл юм. Тус хичээл нь Африк-Америкийн уран зохиол нь өнөөгийн нийгэмд чухал ач холбогдолтой болохыг онцлох болно.

Газарзүйн багаж, техник (98423W)**Бүтэн жил, нэг кредит, + 1.0 чанарын оноо****Орох ангиуд: 11 ба 12***Элсэхээс өмнөх шаардлага: Байхгүй.*

Тус хичээл нь Жеймс Мэдисоны их сургуулийн газарзүйн улиралуирлын хөтөлбөрийн нэг хэсэг бөгөөд Сурагчдад газарзүйн мэдээллийн систем (ГМС), дэлхийн байрлалын систем (GPS), зайнаас тандан судлах гэх мэт газарзүйн технологийг ашиглах судалгааны туршлагыг эзэмшүүлдэг. Тус хичээл нь Сурагчдад өргөтгөсөн судалгааны төсөл боловсруулах, гүйцэтгэх боломжийг олгоно. Сурагчид сонирхсон асуудлаа тодорхойлох, асуудлын талаар оролцогч талуудаас тодорхойлох, асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай өгөгдөл, газарзүйн багаж хэрэгслийг үнэлэх, өгөгдөлд дүн шинжилгээ хийх, боломжит шийдлүүдийг санал болгож, оролцогч талуудад хүргэх чиглэлээр ажиллана.

- **Коллеж кредит:** Энэхүү хичээл амжилттай дүүргэвэл Жеймс Мэдисоны Их Сургуульд (JMU) Geog 161-ийн хамт JMU-д нийт 6 кредитээр давхар элсүүлж тооцно. Энэ хичээлийн агуулгыг коллежийн түвшинд заадаг. Боловсролын зөвлөхөөсөө дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

Дэлхий судлал II: Далай судлал (24220)**Бүтэн жил, нэг кредит****Орох ангиуд: 11, 12***Элсэхээс өмнөх шаардлага: Дэлхий судлал хичээл ба нэмэлт лабораторийн шинжлэх ухааны хичээл*

Энэхүү хичээл нь сурагчдыг Далай судлалтай танилцуулдаг үндсэн хичээл юм. Хичээлээр манай дэлхий дээрх далай тэнгисийн ач холбогдол, тэдгээр нь бидэнд яагаад чухал болохыг, далай тэнгис соёл иргэншлийн түүхэнд ямар нөлөө үзүүлж байсан тухай судална. Далай судлал хичээл нь газарзүй, биологийн талаас далайг судалдаг геологи, газарзүйн байршил, далайн усны физик шинж чанар, тэнгисийн хими, тэнгисийн биологи, далай дахь давсны агууламж, нягтралын эргэлт, давалгаа, далайн түрлэг, далайн хэмжүүрийн багаж хэрэгсэл, арга хэрэглүүрийн талаар агуулгыг багтаасан болно. Тус хичээл нь далай судлалын концептыг гүнзгийрүүлэн судлахад зориулагдсан болно.

Анхан шатны анализ, Хос элсэлт (93162W)**Бүтэн жил, нэг кредит, + 1.0 чанарын оноо****Орох ангиуд: 9-12***Элсэхээс өмнөх шаардлага: VPT шалгалтад шаардлага хангасан оноо авсан байх(Алгебр II хичээл хүртэл 9 хичээлийн агуулгыг бүрэн үзсэн байх)*

NOVA MTH 161 хичээл нь коллежийн алгебр, матриц, алгебрик, экспоненциал ба логарифм функцийг танилцуулдаг. NOVA MTH 162 нь тригонометр, аналитик геометр, дараалал ба цувралуудыг танилцуулдаг. Тус хичээл нь сурагчийн MTH 263/264 Анализ I/II хичээлд бэлтгэдэг.

- **Коллежийн кредит:** Хойд Виржиниа мужийн Нийтийн коллежид Тус хичээлийг давхар суралцаж болно. Бүртгүүлэхээс өмнө NOVA элсэлтийн шаардлагыг хангасан байх ёстой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийнхаа зөвлөхөөс авна уу.

Иорктаунд санал болгож байгаа ахисан бүс түвшний хичээлүүд**Хими, Лабораторийн хичээлийн зарчим (24400)****Бүтэн жил, нэг кредит****Орох ангиуд: 10-12***Элсэхээс өмнөх шаардлага: Байхгүй.*

Уг хичээлийн гол зорилго нь Сурагчдад хими өдөр тутмын амьдралд ямар хамааралтай байдгийг ойлгуулах явдал юм. Ангийн үйл ажиллагаа, лабораторийн туршилт зэргийг онцлон заана. Сургалтын төгсгөлд SOL шалгалт авдаг. SOL шалгалтыг давсан тохиолдолд баталгаажсан кредит авдаг.

Англи хэл 9 (21130) ба Дэлхийн түүх ба Газарзүй МЭӨ 1500 оноос өнөөг хүртэл түүх (22216)**Бүтэн жил, хоёр кредит, хоёр цагаар***Элсэхээс өмнөх шаардлага: Байхгүй.*

Тус хичээл нь Сурагчдад Англи хэл 9 ба дэлхийн түүх, газарзүйн чиглэлээр интерактив, Түргэвчилсэн хөтөлбөртэй судалгаа хийх боломжийг санал болгодог. МЭӨ 1500 оноос өнөөг хүртэл түүх Сурагчид хоёр сэдвийн хүрээнд сэдэвтэй холбоотой хэлэлцүүлэг, семинар, симуляци, судалгаанд оролцдог. Энэ анги нь сурагчид болон сургалтын багш нарыг хамтдаа суралцах сургалтын орчинд оролцох боломжийг олгодог. Дэлхийн Түүх II хичээлийн стандартын үнэлгээгээр тухайн хичээлээр баталгаажсан кредит авдаг.

Англи хэл 9 (21132), Түргэвчилсэн хөтөлбөртэй ба Дэлхийн түүх (22343), Түргэвчилсэн хөтөлбөртэй Бүтэн жил, хоёр цагаар, хоёр кредит (Англи хэл дээр нэг кредит, Дэлхийн түүх хичээлд нэг кредит)

Элсэхээс өмнөх шаардлага: Англи хэл ба Нийгмийн ухааны аль алинд нь сурлагын өндөр амжилт үзүүлсэн байх ёстой. Багш эсвэл зөвлөгчийн тодорхойлолт.

Тус хичээл нь авъяаслаг, ахисан түвшний сурагчдын хэрэгцээнд зориулагдсан бөгөөд дараах чадварыг эзэмшүүлдэг. Их хэмжээний материал сэлт унших, бичих, дүрмийн болон үгийн сангаа эрчимтэй ашиглах, уран зохиол, утга зохиол, жүжиг, яруу найргийг нарийвчлан судлах, Англи хэл 9 хичээлээс давсан хэмжээнд англи хэлний урлагийн бүх чиглэлд өндөр түвшинд ашиглаж сурах гэх мэт. Салбар хоорондын аргыг ашиглан Англи хэл ба Дэлхийн түүхийн хичээлийг хамтад нь заадаг. Уран зохиол болон утга зохиолын төрөл бүрийн төрлийг судлах замаар сурагчид Дэлхийн түүхийг ойлгож, соёл болгон мөргөлдөөний сэдэвчилсэн ойлголтыг судалж үздэг. Энэхүү хичээлийг авъяаслаг үйлчилгээтэй уялдуулдаг. Сурагчид энэ хичээлийн төгсгөлд Дэлхийн түүхийн SOL шалгалт өгөх болно.

**Кино судлал II (21447)
Нэг улирал, хагас кредит
Орох ангиуд: 11-12**

Элсэхээс өмнөх шаардлага: Кино судлал I хичээлийг дүүргэсэн байх эсвэл багшийн зөвшөөрөл.

